Сүүжийн дабааны бичээсийг одоогийн Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Намнан уулын Сүүжийн даваа гэдэг газраас олжээ[389]. Г.И.Рамстедт эл бичээсийг анх нээж олсон, бас магадгүй уг хөшөөг хамгийн сүүлд харсан судлаач болсон байна. Учир нь Г.И.Рамстедтээс хойш энэ хөшөөг олж судлахаар зоригсод бүгд ганзага хоосон буцацгааж яах аргагүй алга болсон нь тодорхой болжээ.

"Qïrγïz oγlï qutluγ baγa tarqan ögä buyruqï qutluγ yarγan" хэмээх нэрээс улбаалан эрдэмтэд бичээсийг киргизийн үед холбогдоно гэж үздэг.

Эл хөшөөний бичээсийг Г.И.Рамстедтийн хуулбар, уншлагад түшиглэн Х.Н.Орхун[390], А.Зуев[391], С.Е.Малов[392], С.Г.Кляшторный[393], Г.Айдаров[394], У.Мараззи (Ugo Marazzi)[395], Л.Болд[396] нарын эрдэмтэд хэл, түүх, эх бичиг судлалын үүднээс судалсан байна. Сүүжийн бичээсийг анх олж илрүүлэн эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж нийтлүүлсэн эхээс үзвэл ихэнх үсэг тодорхой байсан хэдий ч дараа дараагийн судлаачдад нарийвчлан үзэх бололцоо гараагүй байна.

Завхан аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Зүрийн овооны бичээс

Завхан аймгийн Баянтэс сумын ойролцоо орших Зүрийн овоо гэдэг газраас эртний нэгэн бичээсийг 1915 онд нэрт эрдэмтэн Б.Я Владимирцов анх олж судлан нийтлүүлэхэд бэлтгэжээ*. Алексей Бурдуковт " ..Би нэлээд сайн, сайхан явж ирлээ. Зөвхөн бороо л их орж тав тух алдуулав. Тэс дэх Орхон бичээсийн цаасан хэвийг нь авч чадсангүй. Учир нь уг бичээсийг засаж янзлаагүй хадан дээр бичсэн учир гэрэл зургийг нь авч хуулж бичих төдийгөөс хэтэрч чадсангүй. Энэ бичээс хэдийгээр жижигхэн боловч маш сонирхолтой юм. Би бүгдийг нарийвчлан үзлээ. Ихэд чармайн эрсэн боловч энэ бичээсээс өөр бичиг олсонгүй. Харин олон тооны сонирхолтой хиргисүүрийг үзлээ. Эдгээр газруудаас өөр иймэрхүү бичээс олдоно гэдэгт эргэлзэхгүй байна" гэж Б.Я Владимирцов захидал бичсэнийг "Шинэ ба хуучин Монголд" номонд хавсарган хэвлэжээ хэмээн доктор Л.Болд тэмдэглэсэн байдаг[397] . Уг бичээсийг 1969, 1971, 1975 онуудад Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн "Бичээс судлал"-ын хэсэг очиж дахин

---

[389] G.J. Ramstedt, Zwei uigurische Runeninschriften in der Nord-Mongolei, -Journal de la Société Finno-Ougrienne, Helsinki, 1913, pp. 30-3, 63, +3pls; Г.И.Рамстедт, Как был найден Селенгинский камень, Труды Троицко-Кяхтинского отделения Императорского Русского Географического обшества, Том IV, Вып.1, Санктпетербург, 1914; Г.И.Рамстедт, Перевод надписи Селенгинского камня, Труды Троицко- Кяхтинского отделения Императорского Русского Географического обшества, Том XV, Вып.1, Санктпетербург, 1914, стр.34-39, 40-49.

[390] H.N.Orkun, Eski Türk Yazıtalrı II, Istabul, 1939 (Birinci Baskı: 1936, 1938, 1940, 1941; İkinci Baskı: Ankara, 1987; Üçüncü Baskı: Ankara, 1987) s.107-123.

[391] А.Зуев, Киргизская надпись из Сужды, -Советское Востоковедение, Москва, 1958, №2, стр.133-135.

[392] С.Е.Малов, Енисейская письменность тюрков, Москва-Ленинград,1952, стр.84-90.

[393] С.Г.Кляшторный, Историко-культурное значение Суджинской надписи, -Проблемы Востоковедения, 1959, №5, стр.162-169.

[394] Г.Айдаров, Язык памятников древнетюркской письменности YIII века, Алма-Ата, 1971, стр.353.

[395] Ugo Marazzi, Alcuni problemi relative alla diffuisione del manicheismo presso i Turchi nei secoli XIII-IX, Annali dell'-Instituto Orientale di Napoli, 39(N.S.XXIX)/2, Napoli, 1979, pp.239-252.

[396] Л.Болд, Сүүжийн Орхон бичээсийн үгийн сангийн харьцуулсан судалгаа, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 154-175 дугаар тал.

* *"Ленинградын Дорно дахиныг судлах хүрээлэнгийн түрэг-монголын тасгийн гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй В.Я.Владимирцовын бүтээлийн цуглуулга дотор "В.Я.Владимирцов, Небольшая турецко-енисейская надпись на р.Тесе. Западная Монголия гэсэн нэрээр хадгалагдаж буй ажгуу. Уг өгүүлэл 410-416 гэсэн дугаартай, зөвхөн нэг талд нь барласан хэвлэлийн 7 дардас хуудас юм*" гэж М.Шинэхүү абугай тодорхойлсон байна.

[397] Л.Болд, Зүрийн овооны түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1999, 35 дугаар тал.

судалж шинжилгээний ажлын үр дүнгээ С.Г.Кляшторный 1975 онд[398], М.Шинэхүү 1977 онд[399] тус тус хэвлүүлжээ.

Нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный 2003 онд хэвлүүлсэн бүтээлдээ эл бичээсийн талаар дахин өгүүлсэн байна[400].

Өвөрхангай аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Онгийн гэрэлт хөшөө
Өвөрхангайн бичээс
Хутаг уулын түрэг бичээс

Онгийн гэрэлт хөшөө

Онгийн голын хөвөөнөөс тахилын томоохон байгууламж, гэрэлт хөшөө бүхий цогцолбор дурсгалыг анх Н.М.Ядринцев олж илрүүлсэн бөгөөд В.В.Радлов бичээсийн хэв дардсыг авсан байна.

Энэхүү дурсгал нь одоогийн Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг Мааньтын Бүрд хэмээх газар байжээ. Анх олж илрүүлэх хийгээд хэв дардас авах үед бүрэн бүтэн байсан тэрхүү хөшөө хожим аянганд ниргэгдэн хэдэн хэсэг болж бутарч унажээ. Гэрэлт хөшөөний бичээс золоор В.В.Радловын "атлас"-т гэрэл зураг, хэв дардсаар тодорхой үлдсэн байна. Хөшөөнөөс үлдсэн хоёр хэсэг бичигтэй хугархай Өвөрхангай аймгийн Орон нутгийг судлах музейд хадгалагдаж байгаа боловч уншиж судлах боломжгүй болсон байна.

Онгийн гэрэлт хөшөөний цогцолбор дурсгалын археологийн болон бичээс судлалын үүднээс Н.М.Ядринцев[401], В.В.Радлов[402], Х.Н.Орхун[403], С.Пэлси[404], П.К.Козлов[405], С.Е.Малов[406], Ж.Клоузон[407], Э.Трыярски[408], Т.Оосава[409], В.Е.Войтов[410], Д.Баяр, Л.Болд[411] нарын зэрэг олон эрдэмтэд судлан шинжилсэн байна.

---

[398] С.Г.Кляшторный, Наскальные рунические надписи Монголии (Тэс, Гурвалжин-Ула, Хангита-хат, Хэнтэй), -Тюркологический сборник 1975, Москва, 1978, стр.151-159.

[399] М.Шинэхүү, Тэсийн эртний түрэг бичээсийг дахин нягталсан нь, -Археологийн судлал,Tom.VII, fasc.9, Улаанбаатар, 1977, 113-120 дугаар тал.

[400] С.Г.Кляшторный, Надпись на р.Тэс, -История Центральной Азии и памятники рунического письма, Санктпетербург, 2003, стр.72-74.

[401] Н.М.Ядринцев, Отчет и дневник о путешествии по Орхону и в южной Хангае в 1891году, -Сборник трудов Орхонской экспедиции, V, Санкт-Петербург, 1901, 43.

[402] W.W.Radloff, Das Denkmal am Ongin ,- Die alttürkischen Inschrift der Mongolei, St.Petersburg, 3.Lieferung 1895; Neue Folge 1897; Zweite Folge 1899 (in 2 vols: Osnabrück 1987), pp.243-256.

[403] H.N.Orkun, Eski Türk yazıtları I, İstanbul, 1936,(Birinci Baskı: 1936, 1938, 1940,1941; İkinci Baskı: 1987; Üçüncü Baskı: 1994) s.127-132.

[404] Memoria Saecularis Sakari Pälsi, Aufzeichnungen von einer Forschungsreise nach der nördlichen Mongolei im Jahre 1909, Helsinki, 1982, Harry Halén ed.

[405] П.К.Козлов, Путешествие в Монголию (1923-1926), Москва, 1949, стр.167.

[406] С.Е.Малов, Онгинский памятник,-Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии, Москва-Ленинград, 1959, стр.7-10.

[407] G.Clauson, The Ongin inscription, -Journal of the Royal Asiatic Sosiety, 1957-3/4, pp.175-192.

[408] E.Tryjarski, Die heutige Mongolei und ihre alten Denkmäler.& The Present State of Preservation of Old Turkic Relics in Mongolia and the Need for their Conservation, -Ural-altaische Jahrbücher 38, pp.154-158 & pp.158-173, + many pls; E.Tryjarski, On the Archaeological Traces of Old Turks in Mongolia, -East and West, 1971, N.S.21-1, pp.121-135; Some Remarks on the Monument of the Orkhon Turks, - Türk Kültürü El Kitabı, Istanbul, 1972, pp.35-43, 418-422; E.Tryjarski, Zur neueren Geschichte des Ongin-Denkmals, -Sprache, Geschichte und Kultur der Altaischen Völker, (Schriften zur Geschichte und Kultur des Alten Orients 5), Berlin, 1974, 629-630; E.Tryjarski, Zwyczaje pogrebowe ludow tureckich na tle ich weirzen, -Polska Akademia Nauk Komitet Nauk Orientalstycznych, Warszawa, 1991, pp.50, 54,77; E.Tryjarski & P.Aalto, Two Old Turkic Monuments of Mongolia, -Mémoires de la Société Finno-Ougrienne, 1973, pp.413-420, -3 pls.

Хутаг уулын түрэг бичээс

Өвөрхангай аймгийн Баруун Баян улаан сумын нутаг Хутаг ууланд хадны зураг болон эртний бичээс буйг 1972 онд Монгол оронд ажилласан тухайн үеийн Ардчилсан Герман улсын геологичид олж илрүүлжээ[412].

Энэхүү лавтай мэдээллийн мөрөөр Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн бичээс, хадны зураг судлах хэсэг 1973 оны зун уг бичээсийн газар очиж судалсан байна[413].

Е.Трӣярски, Ж.Хамилтон нар 1975 онд[414] М.Шинэхүү 1976 онд уул бичээсийг үншиж судалсан дүнгээ нийтлүүлсэн[415] ажээ.

Өвөрхангайн бичээс

Өвөрхангай аймгийн музейд хадгалагдаж байгаа энэхүү бичээсийг Мааньтын Бүрд хэмээх газраас авчирсан аман мэдээ байдаг ажээ.

1978 онд Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний анги үзэж мэдээлснээр доктор Л.Болд үншиж судалсан байна[416].

---

[409] 大澤 孝· オンギ碑文· -モンゴル国現存遺跡· 碑文調査研究報告· 中央ユーラシア学研究会 · 1999 年 3 月 (Takashi Ōsawa, Ongi Inscription-Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999). pp.129-136.

[410] В.Е.Войтов, Онгинский памятник. Проблемы культуроведческой интерпретации, -Советская Тюркология, №3, Москва, 1989, стр.34-50; В.Е.Войтов, Древнетюркский пантеон и модель мироздания в культово-поминальных памятниках Монголии VI-VIII вв, -Государственный Музей Востока, Москва, 1996, стр.28-32.

[411] Д.Баяр, Монголын төв нутаг дахь түрэгийн хүн чулуу, Улаанбаатар, 1997, дүгээр тал.

[412] D.Laur, Archäologische Beobachtungen aus dem Bajan-Chongor-Aimak der Mongolischen Volksrepublik, Felszeichnungen und Inschriften –"Ethnographish-Archäologische Zeitschrifte", Veb Deutscher verlag der Wissenschaften, 1972, H.1, s.1-38.

[413] Уг хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Шинэхүү, хоёр оюутны хамт; Зөвлөлтийн ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Э.Новгородова нар оролцжээ.

[414] E.Tryjarski, J.H.Hamilton, L'inscription turque runiforme de Khutuk-ula,-Journal Asiatique, Paris, 1975.

[415] М.Шинэхүү, Хутуг уулын эртний түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №4, Улаанбаатар, 1976, 36-42 дугаар тал.

[416] Л.Болд, Шинээр олдсон түрэг бичээс, -Хэл зохиол судлал,Tom.XVI, fasc.1-19, Улаанбаатар, 1987, 68-71 дүгээр тал; Л.Болд, Өвөрхангайн түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 83-84 дүгээр тал; Л.Болд, Өвөрхангайн орхон бичээс-Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 254-257 дугаар тал.

Хөвсгөл аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Орюк хадны бичээс
Тэсийн гэрэлт хөшөө

Тэсийн гэрэлт хөшөө

Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн "Бичээс" судлалын хэсгийнхэн Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын Өвөр булгийн Хөх толгой хэмээх газраас Тэсийн гэрэлт хөшөөг анх олжээ[417].

Тэсийн гэрэлт хөшөөний бичээсийн бусад хэсэг хугархай олдоогүйгээс бичээсийн бүрэн утга агуулгыг тодорхойлон өгүүлэхэд бэрхтэй юм.

С.Харжаубай[418], С.Г.Кляшторный[419], Т.Текин[420], Т.Оосава[421] нарын эрдэмтэд уул бичээсийг уншиж судалсан байна.

Доктор Л.Болд бүтээлдээ уг бичээсийн судалгааны тойм хийгээд зарим үг хэллэгийн тухай өгүүлжээ[422].

Бид 1997 онд профессор А.Очирын хамт Тэсийн гэрэлт хөшөөний суурь гэгдэх Хөх толгойн Авдрантын тахилын байгууламж, хашлага чулууг үзэж гүйцэт судалсан хийсэн билээ.

Орюк хадны бичээс

Хөвсгөл аймгийн Ринчинлхүнбэ сумын нутагт, Шишгэд голд цутгасан Харанга ой голын дээд аманд, Хээргийн боом гэдэг хадан хясааны дээд талд, доод Тошдог уулын ард Орюк хад нэртэй багахан хаданд руни бичээс буйг 1986 онд Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Л.Болд очиж судлан шинжилжээ[423]. Одоогоор Л.Болд докторын өгүүллээс өөр эрдэм шинжилгээний бүтээл, судалгаа үгүй байна.

---

[417] С.Харжаубай, А.Очир, Тэсийн гэрэлт хөшөөний шинэ дурсгал, -Шинжлэх ухаан амьдрал, №3, Улаанбаатар, 1977, 75 дугаар тал.

[418] С.Харжаубай, Тэсийн гэрэлт хөшөө, -Хэл зохиол судлал,Tom.XIII, fasc.1-25, Улаанбаатар, 1979, 117-124; С.Харжаубай, Первый памятник Ель-Етмиш Бильге кагана (Тэсинская стела), -Объединенный каганат тюрков в 745-760 годах (по материалам рунических надписей), Астана, 2002, стр.20-31.

[419] S.G.Klyashtorny, The Tes Inscription of the Uighur Bögü Qaghan, - Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Budapest, 1985, 39-1, pp.137-156, +5 pls; S.G.Klyaştorniy, Tes âbidesi (ilk neşri), - Türk Kültürü Araştırmaları,Tom.XXIV, № 2, Ankara,1986, s.151-171; С.Г.Кляшторный, Тэсинская стела (Предварительная публикация),-Советская Тюркология, №6, 1983, стр.76-90.

[420] Talat Tekin, Nine Notes on the Tes Inscription, - Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Budapest, 1988, 42-1, pp.111-118.

[421] 大澤 孝· テス碑文· -モンゴル国現存遺跡・碑文調査研究報告· 中央ユーラシア学研究会 · 1999 年 3 月 (Takashi Ōsawa, Tes Inscription, -Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999). pp.158-167.

[422] Л.Болд, Тэсийн түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 113-117 дугаар тал; Л.Болд,Тэсийн Орхон бичээсийг дахин уншсан тухай тэмдэглэл, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 210-231 дүгээр тал.

[423] Л.Болд, Орюк хадны түрэг бичээс (урьдчилсан тайлан), -Дорно дахины судлалын асуудал, №2 (17), Улаанбаатар, 1987, 87-91 дүгээр тал; Л.Болд, Орюк хадны түрэг бичээс, - БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 78-80 дугаар тал.

Төв аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Көл ич чурын гэрэлт хөшөөний бичээс
Туньюкукийн гэрэлт хөшөөний бичээс

Туньюкукийн гэрэлт хөшөөний бичээс

Туньюкукийн гэрэлт хөшөөний бичээсийн талаар олон арван бүтээл гарсныг өмнө бид нийтлүүлсэн билээ[424]. Удахгүй "Туньюкукийн гэрэлт хөшөөний бичээсийн судалгаа" хэмээх бүтээл хэвлэгдэх бөгөөд уг номд энэ дурсгалын талаар судалгааны дэлгэрэнгүй бүртгэл буй.

Көл ич чурын гэрэлт хөшөөний бичээс

Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг, Хөшөөн тал хэмээх газар буй энэ дурсгалыг тусгай дэвтэр болгон хэвлүүлэхээр зэхсэн тул судалгааны тоймыг дурдаагүй болно.

Улаанбаатар хотод хадгалагдаж байсан руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Номын баринтгийн тээг дээрх бичээс

Улсын нийтийн номын санд хадгалагдаж байсан "Гучин хоёр модон хүний үлгэр" гэх номын баринтгийн оосорт буй чулуун тээг дээрх хоёр мөр бичээсийг 1956 онд академич А.Лувсандэндэв гуай тайлж уншсан байна[425].

Тэрээр 1960 онд герман хэлээр өгүүлэл нийтлүүлж[426] түрэг судлаачдын сонорт энэ бичээсийг дахин сонордуулсан ажээ.

Б.Ринчен академич "БНМАУ-ын Нийтийн номын санд байгаа нэг судрын баринтагийн оосрын чулуун тээгний түрэг бичээс" нэртэйгээр нийтлүүлснээс[427] гадна нэгэн өгүүлэл франц хэлнээ хэвлүүлжээ[428].

1959 онд Г.И.Константин[429], 1960 онд С.Г.Кляшторный[430], 1971 онд Г.Айдаров[431] нар тус тус өгүүлэл нийтлүүлжээ.

Доктор Л.Болд бүтээлдээ А.Лувсандэндэв гуайн судалгааг бараг хэвээр сийрүүлжээ[432].

Түрэг судлаач нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный уг бичээс хуурамч зүйл мөн хэмээн 2003 онд хэвлүүлсэн бүтээлдээ өгүүлжээ[433].

---

[424] Ц.Баттулга, Туньюкукийн гэрэлт хөшөөний судалгаа, -Түүхийн сэтгүүл, Ephemeris Historiae, Academia Doctrinae Mongolia, Tom.IV, fasc.1-23, Улаанбаатар, 2003, 29-39 дугаар тал.

[425] А.Лувсандэндэв, Шинээр олдсон түрк бичээсийн тухай, Улаанбаатар, 1956, 7 хуудас.

[426] A.Lubsangdendüp, Über eine in der Mongolei neu entdeckte türkische Runeninschrift aus dem 13.Jh, - Ural-altaische Jahrbücher, Wiesbaden, 1960, pp.122-123.

[427] Rintchen, Les dessigns pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum,Tom.XVI. fasc.1, Улаанбаатар (Oulanbaator), 1968, pp.43.

[428] B.Rintchen, La Mention du Nom de Činggis Qaqan en écriture des turcs d'Orkhon, - XXIV International Orientalisten –Kongres Arbeitsplan und Mitgliederverzeichniss, München, 1957, pp.42.

[429] G.I, Constantin, A late Kök-Türkish runic inscription on a semi-precious stone, found in Mongolia, - Archiv Orientalni, Prag, 1959, pp.427-437.

[430] С.Г.Кляшторный, К вопросу о подлинности древнетюркской надписи с именем Чингис хана, -Проблемы Востоковедения, Москва, 1960, № 1, стр.173-175.

[431] Г.Айдаров, Шингис Ханның атына баяланстн ескерткиш туралы, -Қазақ Епиграфикасы, Алматы, 1971, стр.156-160.

[432] Л.Болд, Номын баринтагийн тээг дээрх түрэг бичээс, -БНМАУ-ын хадны бичээс, Улаанбаатар, 1990, 72 дугаар тал.

Хэнтий аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Рашаан хадны бичээс
Цэнхэрмандалын бичээс

Цэнхэрмандалын бичээс

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумаас холгүй, "Бургастайн бичигт цохио" хэмээх газар хоёр мөр руни бичгийн дурсгал буй бөгөөд манай судалгааны ном зохиолд "*Цэнхэрмандалын бичээс*" нэрээр орос, туркийн эрдэмтэд "*Хэнтийн бичээс*" гэж өөр өөрөөр нэрлэжээ.

Д.А.Клеменц Дорнод Монголоор аялахдаа 1895 оны 5-р сард энэ бичээсийг анх олсон тухай доктор Л.Болд бүтээлдээ тодорхой өгүүлжээ[434].

Б.Ринчен академич "Үнэн" сонинд ажиллаж байхдаа "Новости Монголии" сонинд уг бичээсийн тухай мэдээлэл нийтлүүлсэн гэдэг.

Уул мэдээллийн мөрөөр С.Е.Киселевийн удирдсан шинжилгээний анги 1949 онд ирж үзэж нягтлан гэрэл зураг, гар хуулбар авчээ*.

Угсаатны зүйч К.В.Вяткина 1958 онд эл бичээсийг шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор мэдээлсэн байна[435] .

К.В.Вяткина гуайгаас авсан гэрэл зурагтаа дулдуйдаж Фэн Цзя-шэн хоёр мөр эл бичээсийг уншиж тайлсан судалгаагаа 1959 онд хэвлүүлсэн аж[436].

Б.Ринчен академич 1968 онд[437], Х.Пэрлээ академич 1974 онд[438] Цэнхэрмандалын бичээсийн гэрэл зураг болон гар хуулбарыг нийтлүүлжээ.

Дорнод Монголоос нилээд эрт үед олдож мэдэгдсэн энэ бичээсийг 1975 оны зун Монгол-Зөвлөлтийн хээрийн шинжилгээний анги үзэж дахин нягтлан судалсан байна*.

Тус хээрийн шинжилгээний ангид ажилласан түрэг судлаач С.Г.Кляшторный 1978 онд[439], М.Шинэхүү 1977 онд[440] Цэнхэрмандалын бичээсийг уншиж тайлсан судалгааны дүнгээ хэвлэн нийтлүүлсэн ажээ.

2003 онд хэвлүүлсэн номдоо С.Г.Кляшторный уг бичээсийн талаар тухайлан оруулсан байна[441].

---

[433] С.Г.Кляшторный, К вопросу о подлинности древнетюркской надписи с именем Чингиз-Хана-История Центральной Азии и памятники рунического письма, Санктпетербург, 2003, стр.75, 269-281.

[434] Л.Болд, Цэнхэр Мандалын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 139-142 дугаар тал.

* Энэ хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд нэрт эрдэмтэн С.Е.Киселев, К.В.Вяткина болон МУИС-ийн оюутан Х.Лувсанбалдан (хожмын тод үсэг бичиг судлаач, нэрт эрдэмтэн), И.Шарав-Иш нар оролцсон гэдэг.

[435] К.В.Вяткина, Кентейская руническая надпись, -Филология и история Монгольских народов, Москва, 1958, стр.217-218.

[436] Фэн Цзя-шэн, Руническая надпись из Восточной Монголии, -Советская этнография, №1, Москва, 1959, стр.3-6.

[437] Rintchen, Les dessigns pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum,Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.43.

[438] Х.Пэрлээ, Дорнод монголын эртний бичиг үсгийн дурсгалын зүйл (Археологийн тэмдэглэлээс), -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №4, Улаанбаатар, 1974, 71-74 дүгээр тал.

* Тус хээрийн шинжилгээний ангийг ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Шинэхүү, ЗХУ-ын ШУА-ийн Ленинградын салбарын Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан С.Г.Кляшторный нар удирдан ажиллажээ.

[439] С.Г.Кляшторный, Наскальные рунические надписи Монголии (Тэс, Гурвалжин –Ула, Хангыта- Хата, Хэнтэй), "Тюркологическпа Сборник 1975", Москва, 1978, стр.151-159.

[440] М.Шинэхүү, Цэнхэрмандалын эртний түрэг бичээсийг дахин уншсан нь, -Археологийн судлал,Tom.VII, fasc.8, Улаанбаатар, 1977, 97-111 дүгээр тал.

[441] С.Г.Кляшторный, Хэнтэйская надпись, -История Центральной Азии и памятники рунического письма, Санктпетербург, 2003, стр.75-77.

Дээрх бичээсийг хамтран үзэж судалсан түрэг судлаач М.Шинэхүү, С.Г.Кляшторный нарын судалгаа зарим талаар зөрүүтэй байсанд бид 2004 онд уг бичээсийг дахин үзэж нягталсан билээ*.

Рашаан хадны бичээс

Нэрт түүхч Х.Пэрлээ Хэнтий аймгийн Биндэр сумын Рашаан хаданд олон зүйл тамга тэмдэг, бичээс байсныг олж илрүүлсэн бөгөөд судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулах үүднээс 1974 онд эртний бичээсийнх нь талаар хэвлэн нийтлүүлсэн байна[442].

Профессор Ц.Шагдарсүрэн 1987 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд ажиллаж байх үедээ Рашаан хадны дурсгалыг очиж судалжээ[443].

Түрэг судлаач С.Харжаубай Рашаан хадны руни бичээсийг уншиж судлан эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн[444] бөгөөд түүний хэвлүүлсэн зураг, эх дурсгал бичээсийн үсэг тэмдэгтээс багагүй зөрж байсныг тэмдэглэс*.

---

* Цэнхэрмандалын бичээсийн хуулбар, гэрэл зураг МУИС-ийн Түрэг судлалын тэнхмийн гэрэл зураг, хэв дардасын цуглуулгад буй.

[442] Х.Пэрлээ, Дорнод монголын эртний бичиг үсгийн дурсгалын зүйл (Археологийн тэмдэглолээс), -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №4, Улаанбаатар, 1974, 71-74 дүгээр тал.

[443] Ц.Шагдарсүрэн, 1987 оны шинжилгээний ангийн тайлан, -Хэл зохиолын хүрээлэн, гар бичмэлийн сан.

[444] С.Харжаубай, Монгол нутгаас олдсон түрэг бичээсүүд, -Хэл зохиол,Tom.XVI, fasc.8, Улаанбаатар, 1987, 83-84.

* Проф. Ц.Шагдарсүрэн багш Рашаан хадны руни бичгийн маш тод, тодорхой гарсан нэгэн гэрэл зураг эрдэм судлалын ажилд тус санаж өгсөн нь Түрэг судлалын тэнхмийн гэрэл зургийн цуглуулгад хадгалагдаж байгаа билээ.

1.4.3. ТАЛ ХЭЭРИЙН БҮС НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛЫН СУДАЛГААНЫ ТОЙМ

Баянхонгор аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Бөмбөгөрийн бичээс
Гурванмандалын бичээс

Бөмбөгөрийн бичээс

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын төвөөс баруун өмнө зүгт, 11 орчим км-т Тайн нурууны төгсгөл, Шивээт хэмээх намхан уулын эхэнд эл бичигт хөшөө, дурсгал бий. Бөмбөгөрийн бичээс хэмээх гэрэлт хөшөө нь нүүрэн талдаа 4 мөр бичээс, баруун хажуудаа нэг мөр бичээс, 34 тамгатай хөшөө юм. Эрдэмтэн зохиолч Л.Түдэв гуай 1986 онд анх үзэж тусгай хамгаалалтанд авахыг зөвлөж байжээ.

Гэрэлт хөшөөний бичээсийг Ц.Баттулга тайлж уншсан байна[445].

Гурванмандалын бичээс

Баянхонгор аймгийн Буугагаан сумын нутагт Мандалын голын сав дагууд орших Гурванмандал хэмээх цувраа гурван уулнаа руни бичгийн дурсгал байгааг 1987 онд Дорно дахины нүүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан С.Дашцэвэл, Р.Бямбаа нар үзэж улмаар шинжлэх ухааны эргэлтэд оруулахыг зорьжээ.

Гурванмандал уулын руни бичгийн дурсгалыг доктор Л.Болд анх уншиж судалсан байна[446].

Монгол Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн судалгааны ангийн "Бичээс судлал"-ын хэсэг 1989 онд гүймэг судалгаа хийсэн байна[447].

Доктор Д.Баяр Гурванмандал уулын хадны бичээс тамга, тэмдгийг тухайлан судлан "Гурванмандын хадны зураг" хэмээх өгүүлэл нийтлүүлжээ[448]. Доктор Б.Напил Дундмандалын бичээсийг Т.Санжмятав гуайн хуулбарт тулгуурлан уншиж казак хэлнээ орчуулсан байна[449].

Ц.Баттулга "Гурван Мандалын бичээсийг дахин нягтлах нь" хэмээх өгүүлэлдээ уул бичгийн дурсгалыг өмнөх судалгаанаас нилээд зөрүүтэй уншиж тайлсан байна[450].

---

[445] Ц.Баттулга, Бөмбөгөрийн бичээс, -Acta Mongolica, Vol. IY (326), Ulaanbaatar, 2005.

[446] Л.Болд, Р.Бямбаа, Гурван Мандалын түрэг бичээс, - Дорно дахины судалын асуудал, №1 (18), Улаанбаатар, 1988, 103-108 дугаар тал; Л.Болд, Гурван Мандалын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар,1990, 25-27 дугаар тал; Ц.Баттулга, Гурванмандалын эртний бичээс, -Археологийн судлал, Улаанбаатар, 2005

[447] Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, МЗТСХЭ-ийн бичээс судлалын ангид 1989 онд ажилласан ажлын тайлан, -Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1989.

***Жич**: Уг ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, Зөвлөлтийн талаас түүрэг судлаач С.Г.Кляшторный, археологич В.Е.Войтов нар оролцож ажилласан байна.*

[448] Д. Баяр, Гурванмандалын хадны зураг, -Археологийн судлал, Tom.XVI, fasc. 1-11, Улаанбаатар, 1996, 89-102 дугаар тал.

[449] Н.Базылханұлы, Моңголияда жанадан табылған түркі бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Августа-Сентябрь 2000, Алматы, 2000, стр. 78.

[450] Ц.Баттулга, Гурванмандалын бичээсийг дахин нягтлах нь, -Археологийн судлал, Tom. XXII, fasc. 6, Улаанбаатар, 2005, 125-135 дугаар тал.

1.4.4. ГОВИЙН БҮС НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛЫН СУДАЛГААНЫ ТОЙМ

Говь-сүмбэр аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Чойрын бичээс

Хүн чулуун дээр бичигдсэн энэхүү өвөрмөц бичгийн дурсгал одоогийн Говь-Сүмбэр аймгийн Чойр өртөөнөөс баруун тийш 15 орчим км-т орших Бага Сансар уулын нэгэн хиргисүүрт булш, булшны дараас овоолгот чулуун дотор байсан гэдэг.

Энэ бичигт хүн чулууны тухай 1895 онд В.А.Обручев анх үзэж тэмдэглэсэн ажээ[451]. Хожим 1928 оны 9-р сард Эрдэмбаяр хиргисүүрт булш, хөшөөний анхны байрлал зэргийг тодорхой харуулсан гэрэл зураг авч харин утасны хорооны Цэндсүрэн гэх нэгэн Улаанбаатар хотод тээвэрлэн хүргэж ирсэн түүхтэй. Судар бичгийн хүрээлэнгээс уг бичээсийн гар хуулбарыг 1928 онд ЗХУ-ын Шинжлэх ухааны академид илгээжээ[452].

Ж.Цэвээн гуайгаас 1933 оны 5-р сард С.Е.Маловт Чойрын бичээсийн гэрэл зураг, гар хуулбар дахин илгээсэнд тэрээр уншиж судлан хэвлүүлсэн байна[453].

С.Г. Кляшторный биеэр үзэж судалсны хувьд эрдэм шинжилгээний томоохон өгүүлэл бичсэн нь хэд хэдэн удаа нийтлэгдсэн ажээ[454].

С.Г.Кляшторный гуайн судалгааг доктор Л.Болд монгол хэлнээ буулган бүтээлдээ оруулжээ[455].

1998 онд Туркийн эрдэмтэн С.Ф.Серткаяа эл бичээсийг дахин уншиж судлан турк, герман хэлээр хэвлүүлсэн байна[456] .

"Монгол нутаг дахь түрэгийн үеийн дурсгалууд" бүтээл[457] болон бусад олон эрдэмтэд судалгаандаа дурдсан ажээ[458] .

---

[451] В.А.Обручев, Список древных могил, замеченных на пути из Кяхты в Ургу и Калган, -Сборник трудов Орхонской экспедиции, II,СПб.,1895, стр.76.

[452] Судар бичгийн хүрээлэнгээс гадаадад явуулсан захидал- Үндэсний түүхийн архив,

[453] С.Е.Малов, Новые памятники и турецкими рунами, -Язык и мышление, Том.VI-XII, Ленинград, 1936, стр. 251-259.

[454] С.Г.Кляшторный, Руническая надпись на каменном изваянии из Чойра, -Проблемы Востоковедения, №5, Москва,1969, стр.46-49; С.Г.Кляшторный, Руническая надпись из Восточной Гоби, -Studia Turcica, Budapest,1971, pp.249-258; С.Г.Кляшторный, Древнетюркская надпись на каменном изваянии из Чойрэна, -Страны и народы Востока, Том.22, Москва, 1980, стр. 90-102.

[455] Л.Болд, Чойрын бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 143 дугаар тал.

[456] Osman Fikri Sertkaya,Göktürk harfli Çoyr Yazıtı, -Orkun, Türkçü Dergi, 5.sayı, Temmuz 1998, s.33-38; Osman Fikri Sertkaya, Die Runen-Inschrift von Čoir, Bahşı Ögdisi Festschrift für Klaus Röhrborn anläβlich seines 60.Geburtstags, Sonderdruck, Türk Dilleri Araştırmaları Dizisi:21, Freiburg· İstanbul, 1998, pp.349-361.+ 4 pl.

[457] Osman Fikri Sertkaya, Cengiz Alyılmaz, Tsendiin Battulga, Moğolistan'daki Türk anitları projesi albümü (Album of the Turkish monuments in Mongolia) - T.C. Başbakanlık Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başbakanlığı, Ankara. 2001, s.168-169.

[458] Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum,Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.39; Edward Tryjarski, On the Archaeological Traces of old Turks in Mongolia, - East and West, New Series, 21/1-2, Rome, 1971; E.Tryjarskı, Eski Türklerin Moğolistan'daki arkeolojık eserleri üzerine, -Türk Kültürü Araştırmaları, XVI/1-2 (1977-1978), Ankara, s.151-184, s.161; Nejat Diyarbekirli, Orhun'dan geliyorum, - Türk Kültürü, sayı:198-199, yıl:XVII, Nisan-Mayıs 1979, s.382 (62); Erk Yurtsever, Eski Türk yazıtları için bir tavsih ve iki zeyl,-Orkun, Aylık Türkçü Dergi, Kasım 1988, sayı:9, s.18-20;

Дундговь аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Их бичигтийн бичээс
Дэл уулын дурсгал
Ханангийн бууцны бичээс
Тамганы бичээс
Ханангийн бууцны бичээс

Дэл уулын дурсгал

Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутаг дахь Дэл уул хадны зураг, тамга тэмдэг, үсэг бичгийн дурсгалаараа нэгэнт алдаршжээ.

Дэл уулын хадны зургийг Д.Дорж, Э.А.Новгородова нар анх удаа судалсан байна[459].

1987 онд МУИС-ийн Түүхийн тэнхмийн эрхлэгч дэд доктор Д.Хүүхэнбаатар, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Т.Санжмятав нар руни бичгийн I, II дурсгалыг олж илрүүлжээ[460].

Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн "Бичээс судлал"-ын хэсэг 1989 оны 7-р сарын дундуур Дэл уулнаа очиж руни бичгийн дурсгалыг судалсан байна[461].

Т.Санжмятав бүтээлдээ Дэл уулын баруун Билүүний хадны зураг, мөн руни бичгийн 1,2-р дурсгал зэргийг хамтатган хэвлүүлжээ[462].

Дэл уулын зүүн Билүүний хятад бичээсийг Ц.Баттулга, Ц.Төрбат нар тайлан уншсан байна[463].

Дэл уулнаас одоогоор руни бичгийн дөрвөн дурсгал олдоод байгаа билээ. Монголын түүх соёлын дурсгал номд зүүн Билүүний хятад бичээс[464], хамтарсан хээрийн шинжилгээний ангийн "Бичээс судлал" тайланд эдгээр руни бичээсийн талаар өгүүлжээ[465].

Дэл уулын I бичээс

Дэл уулын нэгдүгээр бичээсийг судлаач Ю.Болдбаатар уншиж тайлан эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэд хэдэн удаа нийтлүүлжээ[466]. Ц.Баттулга уг бичээсийг дахин нягтлан судалсан байна.[467]

Б.Напил өмнөх судалгааг казах хэлээр орчуулж зарим үгийн өөрийн хувилбараар орчуулж тайлбарласан байна[468].

---

[459] Д.Дорж, Э.А.Новгородова, Петроглифы Монголии, Улаанбаатар, 1975, 30-31дүгээр тал, таблиц-X.

[460] Т.Санжмятав, 1988 оны хээрийн шинжилгээний тайлан, -Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1988.

[461] Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, МЗТСХЭ-ийн бичээс судлалын ангид 1989 онд ажилласан тайлан, -Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1989.

[462] Т.Санжмятав, Монголын хадны зураг, Улаанбаатар, 1995, 40-42 дугаар тал, таблиц 125-143.

[463] Ц.Баттулга, Ц.Төрбат, Б.Ганчимэг, Дэл уулаас шинээр олдсон хятад бичээс, - МУИС Монгол судлалын сургууль, Эрдэм шинжилгээний бичиг, Боть XYII (169) Улаанбаатар, 2001, 103 дугаар тал.

[464] Монголын нутаг дахь түүх соёлын дурсгал (сэдэвчилсэн лавлах),Улаанбаатар,1999, 212 дугаар тал.

[465] Cengiz Alyılmaz, Tsendiin Battulga, Epigrafik belgelemeler ve yüzey araştırmaları,-Moğolistan'daki Türk Anıtları Projesi 2001 yılı çalışmaları (Work for the Project Turkish Monuments in Mongolia in year 2001), T.C. Başbakanlık Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başbakanlığı, Ankara, 2003, s.362-363.

[466] Ю.Болдбаатар, Дэл уулын нэгдүгээр бичээс, -Mongolica Vol.10(31), Улаанбаатар, 2000, 219-226 дугаар тал.

[467] Ц.Баттулга, Дэл уулын нэгдүгээр бичээсийг дахин нягтлах нь, - Эрдэм шинжилгээний бичиг, МУИС Монгол хэл соёлын сургууль, Боть XXII, дэвтэр III, Улаанбаатар, 2004, 12-17 дугаар тал.

[468] Н.Базылханұлы, Моңғолияда жаңадан табылған түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000, стр.75-71.

Дэл уулын II бичээс
Дэл уулын III бичээс
Дэл уулын IV бичээс

Дээрх бичээсүүдийг Ц.Баттулга уншиж судалсан байна[469] . Б.Напил казах хэлээр орчуулж зарим үгийн өөрийн хувилбараар орчуулж тайлбарлажээ[470].

Их бичигтийн бичээс

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутаг, Аарагийн хадны салбар Их бичигт хэмээх газраас Ц.Баттулга 1997 онд олж илрүүлэн уншиж судалсан байна[471].

Б.Напил өмнөх судалгааг казах хэлнээ орчуулж судалжээ[472]. "Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал" ном[473] болон Монгол-Туркийн эрдэмтдийн хамтарсан хээрийн шинжилгээний ангийн "Бичээс судлал"-ын хэсгийн тайланд[474] дурдагджээ.

Тамганы бичээс

1961 онд Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Х.Лувсанбалдан Дундговь аймгийн орон нутгийг судлах музейд хадгалагдаж буй хүрэл зэвсгийн үеийн элдэв зүйл олдворыг үзэж сонирхож байгаад санамсаргүй тохиолдлоор руни бичиг бүхий тамга байсныг олсон түүхтэй. Нутгийн ардын гарт хадгалагдаж байсан эл түүвэр олдворыг чухам аль сумын нутаг, хэн гэдэг хүний гараас авсныг тэмдэглэсэн зүйл үгүй байжээ.

Х.Лувсанбалдан гуай уг бичээсийн талаар анх 1962 онд мэдээлжээ[475].

Б.Базылхан руни бичээсийг уншиж "Эртний тюрк бичээстэй мутрын тэмдэг" нэртэйгээр хэвлүүлсэн байна[476].

Уг дурсгал Б.Ринчен академичийн бүтээлд нийтлэгдснээс[477] гадна түүх соёлын дурсгалын ном[478], Монгол-Туркийн хамтарсан хээрийн шинжилгээний ангийн "Бичээс судлал"-ын тайланд дурдагджээ[479] .

---

[469] Ц.Баттулга, Дэл уулын баруун Билүүний II,III бичээс, -Археологийн судлал, Tom.XXXVIII, fasc. Улаанбаатар, 1998, 109-115 дугаар тал; Ц.Баттулга, Дэл уулын баруун Билүүний II, III бичээс, -Археологийн судлал, Tom.XXXVIII, fasc. Улаанбаатар, 1998, 109-115 дугаар тал; Ц.Баттулга, Дэл уулын баруун Билүүний IY бичээс, - Эрдэм шинжилгээний бичиг, МУИС Монгол судлалын сургууль, Боть XIY (151), Улаанбаатар, 1999, 74-79 дугаар тал

[470] Н.Базылханұлы, Моңғолияда жаңадан табылған түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000, стр.75-76.

[471] Ц.Баттулга, Их бичигтийн бичээс, - Эрдэм шинжилгээний бичиг, МУИС Монгол судлалын сургууль, Боть 10 (122), Улаанбаатар, 1997, 9-13дугаар тал.

[472] Н.Базылханұлы, Моңғолияда жаңадан табылған түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000, стр.75-76.

[473] Монголын нутаг дахь түүх соёлын дурсгал(сэдэвчилсэн лавлах),Улаанбаатар,1999, 212 дугаар тал.

[474] Cengiz Alyılmaz, Tsendiin Battulga, Epigrafik belgelemeler ve yüzey araştırmaları,-Moğolistan'daki Türk Anıtları Projesi 2001 yılı çalışmaları (Work for the Project Turkish Monuments in Mongolia in year 2001), T.C. Başbakanlık Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başbakanlığı, Ankara, 2003, s.356-359.

[475] Х.Лувсанбалдан, Өчүүхэн түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1962, №4, 68 дугаар тал.

[476] Б.Базилхан, Эртний тюрк бичээстэй мутрын тэмдэг, - Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1964, №1, 74-75 дугаар тал.

[477] Rintchen, Les dessigns pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum,Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.40.

[478] Монголын нутаг дахь түүх соёлын дурсгал(сэдэвчилсэн лавлах),Улаанбаатар,1999, 219 дүгээр тал.

[479] Cengiz Alyılmaz, Epigrapik belgelemeler ve yüzey araştırmaları,-Moğolistan'daki Türk Anıtları Projesi 2001 yılı çalışmaları (Work for the Project Turkish Monuments in Mongolia in year 2001), T.C. Başbakanlık Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başbakanlığı, Ankara, 2003, s.346-347.

Ханангийн бууцны бичээс

Монгол-Америкийн хамтарсан "Өмнөд Монгол" төслийн хээрийн шинжилгээний анги 2003 оны зун Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт сумдын зааг нутаг Бага газрын чулуу хэмээх уулын өмнөд бие, Улаан амны Ханангийн бууц хэмээх газраас олсон байна*.

Ч.Амартүвшин, Ц.Баттулга нар уул бичээсийг уншиж судлан хэвлүүлжээ[480].

Дорнод аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Зоосны бичээс

Археологич Н.Сэр-Оджав гуай 1961 онд Дорнод аймагт хийсэн археологийн хайгуул, шинжилгээний ажлын явцад санамсаргүй тохиолдлоор олжээ[481].

Зоосны руни бичээсийг С.Г.Кляшторный анх уншиж судалсан байна[482] .

Дээрх судалгаа хэвлэгдсэнээс хойш таван жилийн дараа С.Харжаубай руни бичээсийг дахин уншиж монгол хэлнээ орчуулан нийтлүүлжээ[483].

Доктор Л.Болд бүтээлдээ дээрх хоёр судлаачийн бичээсийг уншиж тайлсан байдлыг харьцуулан танилцуулсан байна[484].

---

* Тус хээрийн шинжилгээний ангид ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ажилтан Ч.Амартүвшин, Америкийн Мичиганы Их сургуулийн багш *W.Honeychurch,* Харвардын Их сургуулийн аспирант *J.Wright* нар ажилласан байна.

[480] Ч.Амартүвшин, Ц.Баттулга, Ханангийн бууцны бичээс, -Археологийн судлал, Том XII, fasc.3, Улаанбаатар, 2005, 82-86 дугаар тал.

[481] Н.Сэр-Оджав, Монголын эртний түүх / Түүхэн найруулал/, Улаанбаатар, 1977, 41,42 дугаар тал.

[482] С.Г.Кляшторный, Монета с руническое надписью из Монголии, -Тюркологический сборник 1972, Москва, 1973, стр.335-338.

[483] С.Харжаубай, Эртний гурван бичээс, -Studia Archaeologica, Tom.VII, fasc.10-18, Улаанбаатар, 1979, 32 дугаар тал.

[484] Л.Болд, Зоосон дээрх түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 31-33 дугаар тал.

Өмнөговь аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Сэврэйн бичээс

Өмнөговь аймгийн Сэврэй сумын нутагт, эртний бичиг бүхий нэгэн чулуу байдаг тухай нутгийн нэгэн залуу багш 1948 онд тус аймгийн нутагт ажилласан палентологийн шинжилгээний ангийнханд мэдээлэхэд тус шинжилгээний ангийн ахлагч И.А.Ефремов бичээсийг үзэж улмаар шинжлэх ухааны эргэлтэд оруулжээ[485].

Б.Ринчен академич бүтээлдээ "Сэврэйн бичээс" гэж нэрлэн бичээсийн гэрэл зургийг хэвлүүлсэн ажээ[486].

1969 онд Монгол-Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн "Бичээс судлал"-ын хэсэг анх бичиг судлалын үүднээс нарийвчлан судалсан байна*.

Монгол-Японы хамтарсан "Бичээс" төслийн хүрээнд 1997 онд бичээсийг дахин нягталсан ажээ.

Сэврэйн цагаан чулууны руни, согд бичээсийг С.Г.Кляшторный, В.А.Лившиц[487], Ю.Ёшида, Т.Мориясу, А.Катаяма[488] нар уншиж судалсан байна.

---

[485] И.А.Ефремов, Дорога ветров. Гобийские заметки. Изд.2-е. Москва, 1962, стр.229.

[486] Rintchen, Les dessigns pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum,Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, p.42.

* Шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Х.Лувсанбалдан, Б.Базылхан, Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Шинэхүү, Оросын эрдэмтэн С.Г.Кляшторный нар оролцон ажилласан байна.

[487] С.Г.Кляшторный, В. А.Лившиц, Сэврэйский камень, -Советская тюркология, Баку, 1971, №3, стр. 106-112; S.G.Kljaštornyj, V.A.Livšic, Une inscription inédite turque et sogdienne. La stèle de Sevrey (Gobi méridional), " Journal Asiatique", 1971, pp.11-20; С.Г.Кляшторный, В. А.Лившиц, Открытие и изучение древнетюркских и согдийских эпиграфических памятников Центральной Азии, -Археология и этнография Монголии. Новосибирск, 1978, стр.57-59(37-60).

[488] 吉田 豊・森安孝夫・片山 章雄・セブレイ碑文・-モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月(Yutaka Yoshida, Takao Moriyasu, Akio Katayama, Sevrey Inscription, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998. The Society of Central Eurasian Studies, 1999), pp.125-127.

1.5.0. МАНАЙ ЭРДЭМТДИЙН ТУУРВИСАН РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛЫН ХОЛБОГДОЛТ НОМ

Б.Ринчен, ***Монгол нутаг дахь хадны бичээс гэрэлт хөшөөний зүйл,*** *Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, - Corpus Scriptorum Mongolorum, Tom XVI, fasc.I, Улаанбаатар, 1968, хэвлэлийн нэгж хуудас 13, 73 хуудас.*

Эл номын оршил хэсэгт археологич Н.Сэр-Оджав "БНМАУ-д түрэг бичгийн дурсгалыг судалж байгаа нь" гэсэн тоймд 1966 он хүртэл монгол нутгаас олдсон руни бичгийн дурсгалыг оруулсан байна. Руни бичигт гэрэлт хөшөө, хад чулууны нийт 26 бичээсийн гэрэл зураг, гэрэл зургаас дам буулгасан хуулбар зэргийг тус тус хэвлүүлжээ.

М.Шинэхүү, ***Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал,*** *-Studia Archaeologica, Tom VI, fasc.1, Улаанбаатар, 1975, хэвлэлийн хуудас 15, 219 хуудас.* Эл ном нь,

Оршил, удиртхал,
Монгол нутаг дахь Орхон бичээсийг судалсан тойм
Тариатын гэрэлт хөшөөний төрх байдал
Тариатын гэрэлт хөшөөний үсэг-зурлага, бичээс
Тариатын дурсгалт бичгийн үг, үсгийн галиг ба орчуулга
Тариатын дурсгалт бичгийн үгсийн сангийн судалгаа гэсэн үндсэн хэсгээс бүрджээ.
Тариатын дурсгалт бичгийн үгсийн сангийн судалгаа сэдэв нь дотроо
- хүний нэр,
- ураг төрөл, садан сүлбээ, худ, худгуйн нэр,
- овог аймаг, угсаатан ястан, улс үндэстний нэр,
- аймгийн холбоо, цэрэг-засаглал, түүний тэргүүн нарын цол хэргэм
- албан тушаал, өршөөл хайр, эрэлхэг гавьяаны нэр
- орд өргөө, аж ахуйн нэр,
- оюун сэтгэлгээний нэр
-тоо хэмжээ, цаг хугацаа, их багыг заасан үгс
-өнгө зүс, зүг чигийг заасан нэр
- уул усны нэр
- хүний бие, юмыг заасан нэр
- үйл хөдлөл, байдал байц заасан үгс гэсэн бичил зүйл хуваасан хэсэгтэй ажээ.

Тариатын дурсгалт бичиг дотор гарах үгийг "Орхоны бусад бичээс"-т тохиолдох үгтэй жишиж сонгодог монгол бичгийн хэлтэй харьцуулсан толь хийхдээ монгол, орос орчуулга давхар хадсан нь туйлын сайшаалтай бөгөөд монгол түрэг хэлний харьцуулсан судалгаанд төдийгүй Алтай хэлний судлалд ч чухал эх хэрэглэгдэхүүн болгон ашиглахаар бүтээл болжээ.

М.Шинэхүү, ***Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал,*** *-Археологийн судлал, Том VIII, fasc.1, Улаанбаатар, 1980, хэвлэлийн хуудас 6, 81хуудас.*

Энэ номын Удиртгал хэсэгт Орхон-Енисейн бичгийг судлахын учир холбогдол, руни бичгийн нээлт, Орхон бичгийн судалгааны тойм зэргийг оруулсан байна.

I бөлөгт, руни бичгийн гарал хамаадал, Орхоны руни бичгийн үсэг-зурлага, хэл аялгууны асуудалд, Орхоны руни бичгийг дурсган босгосон зарим зан үйл гэсэн сэдэвт хамаарагдах судалгааг боломжийн хирээр оруулжээ.

II бөлөгт, Тариатын руни бичиг, Тэсийн руни бичээс, Карабалгасун [М.Шинэхүү ийн бичсэн болой]-аас шинээр олдсон руни бичээсийн галиг, монгол орчуулга зэргийг оруулсан байна.

III бөлөгт, Тариатын дурсгалт бичгийн түүхэн мэдээ, Тэсийн руни бичгийн түүхэн мэдээ, Харбалгасын руни бичгийн түүхэн мэдээг нангиад болон бусад хэлээрх сурвалж, судалгааны бүтээлийн мэдээ, баримтад тулгуурлан тодорхой өгүүлж тэдгээр дурсгалууд түүхэн чухаг сурвалж болохыг баталсан ажээ.

М.Шинэхүү, ***Орхон бичгийн атлас****, 1976-1980 он*

Эрдэмтэн М.Шинэхүү "Орхон бичгийн атлас" зохион хэвлүүлэхээр төлөвлөн ажиллаж байсан ч харамсалтай нь амжаагүй байна. Түүний хийж бэлтгэсэн төлөвлөгөө хожим мөн бичгийн ном, атлас хийхэд магад хэрэг болуужин хэмээн санаж бас түүний хичээл зүтгэлийг үнэлэн харуулахын тул толилуулав.

1976-1980 онд зохион үйлдэх "Орхон бичгийн атлас"-ын бүтцийн нарийвчилсан төлөвлөгөө

I БОТЬ

1. Хянан засварлагчдын үг
2. Оршил
3. Удиртхал
4. Өмнө хавсаргасан 36 бичээс орно

Уг хэсэгт дурсгалын тодорхойлолт, орчны план зураг, хэмжээ, ажиглал, тэмдэглэл, хөшөөний дурсгалыг олон талаас нь авсан гэрэл зураг оруулахаар төлөвлөсөн байна. Барагцаалбал 20 хэвлэлийн хуудас байхаар төлөвлөсөн ажээ.

II БОТЬ

1. Өмнө хавсаргасан 36 бичээсийн дор дурдсан зүйлүүд орно. Үүнд:

А.Транслитерация
Б. Транскрипция
В. Орчуулга:
1. Сонгодог монгол бичгийн хэлтэй жишсэн
2. Орчин цагийн монгол хэлээр найруулсан
3. Үгчилсэн орос хэлний
4. Үгчилсэн англи хэлний орчуулга орж II боть дуусна. Барагцаалбал 15 орчим хэвлэлийн хуудас байна.

III БОТЬ

1. Өмнөх 36 бичээсийн транскрипци /орчуулгад хийсэн зүүлт тайлбар/
2. Толь бичиг /36 бичээсийн бүх үгээр хийсэн/
3. Үгийн хэлхээ /36 бичээсний бүх үгээр хийнэ/
4. Ном зүй
5. Товчилсон үгс
6. Гарчиг / III боть барагцаалбал 10 орчим х.х. байх болно.

Жич өгүүлэх нь: Редакторын үг, оршил, удиртхал, бичээсүүдийн товч тодорхойлолт, орчуулга, зүүлт тайлбар, толь бичиг зэрэг нь монгол, орос, англи 3 хэлнээ байх болно.

Энэ атласыг хянан засварлах редакцийн коллеги нь дурдсан бүрэлдэхүүнтэй байх болов уу гэж санана. Үүнд: Ш.Бира, А.Лувсандэндэв, Э.А.Тенишев, Д.М.Насилов, Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав, В.М.Наделяев, Е.И.Убратова, С.Г.Кляшторный, М.Шинэхүү, Б.Базылхан, Л.Ю.Тугушева.

Дээрх редакцийн гишүүд дотроос ерөнхий редактор нь Ш.Бира, А.Лувсандэндэв, В.М.Наделяев, Н.Сэр-Оджав

Хариуцлагатай редактор нь С.Г.Кляшторный, Е.И.Убрятова, Б.Базылхан, М.Шинэхүү.

Харин редакцийн гишүүд нь атлас тус бүрийн онцлогийг харгалзаж хуваан засварлах болно. Үүнд:

I ботийн ерөнхий редактор нь Ш.Бира, Н.Сэр-Оджав

Хариуцлагатай редактор нь С.Г.Кляшторный гишүүд нь Х.Пэрлээ, В.М.Наделяев, М.Шинэхүү

II ботийн ерөнхий редактор нь Ш.Бира, А.Лувсандэндэв

Хариуцлагатай редактор нь Э.Р.Тенишев, Б.Базылхан, гишүүд нь Д.М.Насилов, В.М.Наделяев, М.Шинэхүү, Л.Ю.Тугушева

III ботийн ерөнхий редактор нь Ш.Бира, В.М.Наделяев

Хариуцлагатай редактор нь М.Шинэхүү, гишүүд нь Е.И.Убрятова, С.Г.Кляшторный, Л.Ю.Тугушева. Уг атласыг хийж дуусаад редакцид шилжүүлэхийн өмнө академич Б.Ринчен, Ш.Лувсанвандан, А.Н.Кононов, доктор Чой.Лувсанжав, Э.А.Севортян, Г.Д.Санжеев нарт

үзүүлж зохих санал зөвлөлгөөн авч түүний нь харгалзан үзнэ гээд *төлөвлөгөө боловсруулсан М.Шинэхүү, 1976.IY.19* гэж огноолсон байна.
Мөн 1976-1980 онд зохиох "Орхон бичгийн атлас"-ыг хэрхэн үйлдэх ажлын төлөвлөгөө гээд жил бүр юу хийхийг он тус бүрээр нь гарган жагсааж 1976.IY.20 гэжээ.

Уг атлас зохиогдож хэвлэгдсэн бол монголын руни бичгийн судлалд төдийгүй түрэг, монгол судлалд үнэлж баршгүй чухал ач холбогдолтой бүтээл болох байсан нь гарцаагүй.

Б.Базылхан, ***Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтэц****, Улаанбаатар, 1984,158 хуудас.*

Зохиогч уг номынхоо удиртгал хэсэгт руни бичгийн судалгааны холбогдох ном зохиолыг нилээд дэлгэрэнгүй тоймлон бичжээ.

Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтцийг а/бүтээвэр, б/залгавар бүтээвэр, в/нийлмэл залгавар бүтээвэр, язгуур үг хэмээн ангилж эртний түрэг хэлний язгуур бүтээвэр нь хэлбэр бүтцийн хувьд "э /V", "гэ /CV" /бүтэцтэй 104, "э", "г" гэ" /"V", "C", "CV"/ гэсэн бүтэцтэй 163 залгавар бүтээвэр байна гээд нийлмэл залгавар бүтээвэр VC,VCV, VCVC, VCC, VCCV, VCCVC, CV -гээр/гийгүүлэгч+эгшгээр/ эхэлсэн CVC, CVCV, CVCVC, CVCCV, CVCCVC, CCVC, CCVCV, CVCVCCVC, CCVCCVCVC, CCVCCVCCVCVCV гэх мэт загвар бүхий олон хэлбэртэй байхыг дурьдаад "V" бүтэцтэй 8 язгуур бүтээвэр,"CV" бүтэцтэй 71 язгуур бүтээврийн талаар тухайлан өгүүлжээ.

Л.Болд, ***БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс*** *(Түрэг бичгийн дурсгал I), Улаанбаатар,1990, хэвлэлийн хуудас10, 153 хуудас.*

Зохиогч энэ номдоо монгол нутгаас олдсон нийт 40 бичгийн дурсгалын судалгааны тоймыг эмхэтгэж оруулсан байна. Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалыг судлагч, сонирхогч бүхний гарын авлага, лавлах ном болсонд уг бүтээлийн гол үнэ цэнэ оршиж байгаа юм.

*Л.Болд, "****Орхон бичгийн дурсгал II****" Улаанбаатар, 2000, хэвлэлийн хуудас 17, 268 хуудас.*

Монгол улс дахь Орхон бичиг судлал, Орхон бичгийн дурсгалыг аврагтун, гэсэн удиртгал, санамжаас гадна нийт 13 бичээсийн талаар тухайлан өгүүлсэн байна. Үүнд;

1. Хар балгасын орхон бичиг
2. Хөл Асгатын орхон бичээсийг уншсан тэмдэглэл
3. Онгийн голын орхон бичээсийг сурвалжилсан дүн ба түүний тайлбарууд
4. Күли-чурт зориулан босгосон гэрэлт хөшөөний орхон бичээс
5. Сүүжийн орхон бичээсийн үгийн сангийн харьцуулсан судалгаа
6. Тариатын орхон бичээс
7. Тэсийн орхон бичээсийг дахин уншсан тухай тэмдэглэл
8. Их хануй нуурын бичээс
9. Тэвшийн орхон бичээс
10. Ханан хадны орхон бичээс
11. Хар балгасын II бичээс
12. Өвөрхангайн орхон бичээс
13. Орюк хадны бичээсийн тухай

Мөн зарим бичээсийн хэлзүй, үгийн санг судалсан судалгааны ажлын үр дүнг оруулжээ.

1.6.0. МОНГОЛ НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛЫН БҮРТГЭЛ

Монгол нутагт руни бичгийн хэдэн дурсгал, хаана байдаг талаар хэд хэдэн бүртгэл гарчээ. Тэдгээр бүртгэл мэдээлэл дотор нэр тэмдэглэгдсэн ч чухам аль аймаг, сумын нутаг, ямар нэртэй газар байдаг нь тодорхойгүй бичээс, нэр хаяг тодорхой боловч одоо болтол судалгааны эргэлтэд ороогүй дурсгал нилээд хэд байна. Руни бичгийн дурсгалын дээрх жагсаалтад зарим дурсгалын нэр өөр өөрөөр тэмдэглэгдэж нэрлэгдсэн байх тул үзэгч судлагч нарт тустай хэмээн санаж бүрэн эхээр нь сийрүүлэхийг хичээлээ.

Х.Пэрлээ академичийн бүртгэл[489]

а) Надписи- на надгробных стелах

1. Стела, поставленная в честь Кюль-Тегина в районе Кошо-Цайдама.
2. Стела, поставленная в честь Бильге или Могилян-хана в районе Кошо-Цайдама.
3. Онгинский (Маанитуйнский) памятник, или памятник Гудулу-хану в районе Онгин-гол.
4. Стела, поставленная в честь мудрого Тоньюкука в котловине горы Баянцогту в районе Налайхи.
5. Памятник, поставленный в честь Кули-чура в урочище Ихе-Хушоту.
6. Обломки камней от стел с руническими надписями на развалинах Хара-Балгасуна на берегу реки Орхона.
7. Стела, поставленная в честь Яклагар-хана в местности Суджи на северном берегу реки Селенга (от горы Намнан на запад).
8. Стела, поставленная в честь Моюнчур-хана в урочище Могойн Шинэ-ус, в бассейне реки Селенга.
9. Стела в местности Кюль-Асгат (Их-Асгат) в бассейне реки Орхон.
10. Стоячий камень с руническими надписями у могилы "Долоодоя" в урочище Хар-ус (около города Улангом).
11. Стела в местности Долоон-мод (на северном берегу реки Хойт-Тэрхи).
12. Стела в урочище Сонгинын Турулж (на юг от города Кобдо).
13. Каменное изваяние с руническими надписями из Чойра (находится в экспонатах Центрального Государственного музея в Улан-Батор).
14. Постамент памятника, поставленного в честь Кюль-Тегина в районе Кошо-Цайдама.
15. Новооткрытые обломки от стелы, поставленной в честь Кюль-Тегина в районе Кошо-Цайдама.

б) Надписи на скалах

16. Надписи на скале г.Гурвалжин-Уул (в районе реки Хар-бухын гол)
17. Надписи на скале в урочище Хадаасангийн Бутуугийн бууц (в среднем течени реки Хар бухын гола).
18. Надписи на скалах в местности Байшин-узуур (на юго-восточном направлении, надалеко, на северной стороне от автотракта Улан-Батор-Кобдо).
19. Надписи на отдельной скале Тайхар-Чулуу на южном берегу реку Хойт Тамир.
20. Надписи на скале Цохио в поди Бор-бургаасны ама (в районе Цэнхэрмандал).
21. Надписи на скале Рашаан- хада горы Биндэр (в районе реки Онона).
22. Надписи на скале ущелья реки Цагаан гола. (Наран сомон Гоби Алтайского аймака).

в) Надписи на отдельных вещах

23. Надписи на шкатулках, обнаруженных при раскопках в могиле Тоньюкука в урочище Налайхи.
24. Надписи на камешке, привязанном на конце шнура от повязки старой книги << Гэсэнэ-хааны үлгэр>> (находится в Гос.библиотеке в Улан-Батор).
25. Надписи на бронзовой печати "Кутлуг-хана" (находится Краеведческом музее Дунд-Гобийского аймака).
26. Надписи на бронзовой монете (находится в археологической лаборатории Института Истории АН. МНР).

---

[489] Х.Пэрлээ, Карта рунических письмен на территории МНР, -Studia Museologica,Tom.I, fasc.1-8, Улаанбаатар, 1968, 11 дүгээр тал; Академич Х.Пэрлээ, Карта рунических письмен на территории МНР, -Эрдэм шинжилгээний өгүүллүүд (эмхитгэл) II, Улаанбаатар, 2001, 20-27 дугаар тал.

27. Надписи на обломке вулканического туфа на горе Тебши (находится в археологической лаборатории Института Истории АН. МНР)
(г.Улан-Батор 30.XI.62г)

Б.Ринчен академичийн бүртгэл[490]

1. Тайхир чулууны түрэг бичээс
2. Хангидайн хадны бичээс
3. Гурвалжин уулын түрэг бичээс
4. Ар Ханангийн өвөлжөөний түрэг бичээс
5. Байшин үзүүрийн их бичээс
6. Байшин үзүүрийн бага бичээс
7. Жанжин Чойрын бичээс
8. Кюлтегиний хөшөөний суурь, мэлхий чулууны солгой бөөрцөг дээрх түрэг бичээс
9. Завхан Тэс сумын нутагт байгаа түрэг бичээс
10. Тоньюкүкийн тахилгын сүмийн шаваасны түрэг бичээс
11. Улаангомын хиргисийн түрэг бичээс
12. Хөл Асгатын түрэг бичээс
13. Сэврэй сумын зүүн талд байгаа түрэг бичээстэй чулуу
14. Өвөр дөрөлжийн худгийн ард байгаа чулууны түрэг бичээс
15. Биндэрийн рашааны хадан дээрх түрэг бичээс
16. Тэвш ууланд байгаа түрэг бичээс
17. Цэнхэр-мандлын Бургастайн амны бичигт цохионы түрэг бичээс
18. Нийтийн номын санд байгаа нэг судрын баринтагийн оосрын чулуун тээгний түрэг бичээс
19. Онгийн түрэг бичээс
20. Тоньюкүкийн гэрэлт хөшөө
21. Кюльтегин ноёны хөшөөний бичээс
22. Билгэ хааны хөшөөний бичээс
23. Байбалагийн хөшөөний түрэг бичээс

Номод оруулсан дэс дарааллаар, бичигдсэн байдлаар нь сийрүүлэв.

М.Шинэхүү гуайн бүртгэл[491]

Түүний "Орхон бичгийн атлас"т оруулахаар төлөвлөсөн дурсгалын нэрсийн жагсаалтыг толилуулбал,

1. Хөшөө цайдам дахь Бильгэ хаганы дурсгал
2. Хөшөө цайдам дахь Кюльтегин ноёны дурсгал
3. Баянцогтын мэргэн Тоньюкук жанжины дурсгал
4. Могойн шинэ усны Моюн-чур хаганы дурсгал
5. Их хөшөөтийн Кули-чур хаганы дурсгал
6. Мааньт бүрдийн Кутлуг хаганы дурсгал
7. Тариатын Торян хаганы дурсгал
8. Хөл асгатын Алтан тамган чур хаганы дурсгал
9. Хар балгасуны анхдагч дурсгал
10. Хар балгасуны дэд дурсгал
11. Сүүжийн голын Яглахар хаганы дурсгал
12. Хойт Тамирын Тайхар чулууны бичээс
13. Бөхмөрөний Долоодойн хиргисүүрийн бичээс
14. Арханангийн түрэг бичээс
15. Жүргэрийн цагаан толгойн түрэг бичээс
16. Сэврэйн түрэг бичээс
17. Чойрын түрэг бичээс
18. Хангидайн хадны түрэг бичээс
19. Зүрийн овооны түрэг бичээс
20. Бор бургастайн түрэг бичээс
21. Хар аарагийн түрэг бичээс
22. Ямаан усны түрэг бичээс

---

[490] Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, - Corpus Scriptorum Mongolorum,Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968.

[491] М.Шинэхүү, гар бичмэл, -ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан.

23. Гурвалжин уулын түрэг бичээс
24. Тэвшийн хадны түрэг бичээс
25. Өвөрдөрөлжийн түрэг бичээс
26. Хутуг уулын түрэг бичээс
27. Юлтын түрэг бичээс
28. Баябаликийн түрэг бичээс
29. Кюльтегиний мэлхийн бөөрцөгний бичээс
30. Торян хаганы мэлхийн бөөрцөгийн түрэг бичээс
31. Тоньюкукийн тахилганы сүмийн шаваасны бичиг
32. Дундговь аймгийн орон нутгийг судлах музейд буй хүрэл тамганы түрэг бичээс
33. Номын сангийн нэгэн судрын баринтагны чулуун тээгний түрэг бичээс
34. Рашаан хадны бичээс?
35. Лабораторид буй хүрэл зоосны түрэг бичээс
36. Битүүгийн өвөлжөөний түрэг бичээс? /Хар бухын гол?/

Бид уг эхийг үсэг үггүй хуулсан тул алдаа мадагтай буруу бичсэн гэх зүйл үгүй. Олон жил өнгөрсөн тул зарим нэгэн дурсгалын нэр арай өөрөөр бичигдсэнийг тоочвол,

1. Мааньт бүрдийн Кутлуг хаганы дурсгал →Онгийн бичээс
2. Тариатын Торян хаганы дурсгал →манай судлаачид "Тариат бичээс" хэмээн нэрийдэх авч харь судлаач нар "Тэрхийн бичээс" гэж нэрлэсэн байх
3. Хөл асгатын Алтан тамган чур хаганы дурсгал →Хөл асгатын бичээс. Алтан тамган тарханы бичээс гэж хоёр өөрөөр нэрлэж бичсээр буй
4. Сүүжийн голын Яглахар хаганы дурсгал →Сүүжийн бичээс
5. Хойт Тамирын Тайхар чулууны бичээс→Монголд Тайхар чулуу гэж алдаршсан хэдий ч гадаадад Хойт Тамирын дурсгал нэрээр мэдмүй
6. Бөхмөрөн Долоодойн хиргисүүрийн бичээс →Долоогойдойн бичээс
7. Жүргэрийн цагаан толгойн түрэг бичээс→Дарвийн түрэг бичээс
8. Бор бургастайн түрэг бичээс→Цэнхэрмандалын түрэг бичээс
9. Хар аарагийн түрэг бичээс→Бигэрийн түрэг бичээс
10. Ямаан усны түрэг бичээс→Ханан хадны түрэг бичээс
11. Кюльтегиний мэлхийн бөөрцгийн бичээс→Көлтигинд зориулан босгосон гэрэлт хөшөөний суурь мэлхий чулууны бичээс
12. Торян хаганы мэлхийн бөөрцгийн түрэг бичээс→Тариатын гэрэлт хөшөөний мэлхий чулууны бичээс

Л.Болд гуайн бүртгэл[492]

1.Арханангийн түрэг бичээс
2. Бигэрийн түрэг бичээс
3. Бугатын бичээс
4. Гурвалжин уулын түрэг бичээс
5. Даривын эртний түрэг бичээс
6. Долоодойн түрэг бичээс
7. Зоосон дээрх түрэг бичээс
8. Их Хануй нуурын түрэг бичээс
9. Күли-чурт зориулсан гэрэлт хөшөөний түрэг бичээс
10. Күли-тегинд зориулан босгосон гэрэлт хөшөөний түрэг бичээс
11. Күли-тегиний мэлхий чулууны түрэг бичээс
12. Могилян (Билгэ) хаанд зориулан босгосон гэрэлт хөшөөний түрэг бичээс
13. Моюн-чур хагаанд зориулсан гэрэлт хөшөөний түрэг бичээс
(мөн Сэлэнгийн чулуу ч гэдэг)
14. Мутрын тэмдэг дээрх эртний түрэг бичээс
15. Номын баринтгийн тээг дээрх түрэг бичээс
16. Өвөрдөрөлжийн түрэг бичээс
17. Онгийн голын түрэг бичээс
18. Рашаан хадны түрэг бичээс
19. Сүүжийн түрэг бичээс
20. Сэрвэйн түрэг бичээс
21. Тайхар чулууны түрэг бичээс (мөн Хойт Тамирын түрэг бичээс ч гэдэг)

---

[492] Л.Болд, БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1983, №3, 65-87 дугаар тал.

22. Тэрхийн түрэг бичээс (мөн Тариатын түрэг бичээс ч гэдэг)
23. Тонькукт зориулан босгосон гэрэлт хөшөөний түрэг бичээс (Тонькук I)
24. Тоньюкук II
25. Төмөр цоргын түрэг бичээс
26. Тэвшийн түрэг бичээс I
27. Тэвшийн түрэг бичээс II
28. Тэсийн түрэг бичээс I
29. Тэсийн түрэг бичээс II
30. Ханан хадны түрэг бичээс
31. Хангидийн хадны түрэг бичээс
32. Хар балгасны түрэг I бичээс
33. Хар Балгасны түрэг II бичээс
34. Хар Цагаан усны түрэг бичээс
35. Хөл асгатын түрэг бичээс
36. Хутаг уулын түрэг бичээс
37. Цахирын эртний түрэг бичээс
38. Цэнхэр мандалын түрэг бичээс
39. Чагтан дээрх түрэг бичээс
40. Чойрын түрэг бичээс

Д.Д.Васильевын бүртгэл[493]

Түрэг судлаач Д.Д.Васильевын 1976, 1978 онуудад хэвлүүлсэн өгүүлэлдээ монгол нутгаас олдсон руни бичгийн дурсгалыг тоочсон байх бөгөөд тэрээр тухайн үед лавтай мэдэгдэж олдоод байсан 33 бичээсийг нэрлэжээ.

О.Ф.Серткаяагийн бүртгэл[494]

О.Ф.Серткаяа Монгол улс дахь руни бичгийн дурсгалтай холбогдох археологи, хэлний судалгааны тоймыг 1982, 1984 онуудад тус тус хэвлүүлжээ. Тэрээр нийтдээ 33 бичээсийг судалсан судалгааны тойм, номзүйг хавсаргасан байна.

О.Ф.Серткаяагийн бүртгэл (1996)[495]

Göktürk devri (550-745) yazıtları

Хөхтүрэгийн үеийн (550-745) бичээсүүд

1. Bugut Yazıtı – Бугатын бичээс
1. Çoyr yazıtı: 6 satır –Чойрын бичээс: 6 мөр
2. Ongin yazıtı:19 satır - Онгийн бичээс: 19 мөр
3. Köl-İç-Çor (İhe-Höşötü) yazıtı: 29 satır - Көл Ич Чорын (Их Хөшөтү) бичээс: 29 мөр
4. Köl Tudun inisi Altun Tamgan Tarkan (İhe Aşete) yazıtı:10 satır –Көл Тудуны дүү Алтан Тамган Таркан /Их Ашете/ бичээс: 10 мөр
5. Köl Tigin (Orhon-I) yazıtı:71 satır –Көл Тигиний (Орхон-I) бичээс: 71 мөр
6. Bilge Kağan (Orhon-II) yazıtı:79 satır – Билгэ Хааны (Орхон-II) бичээс: 79 мөр
7. Tonyukuk yazıtları: İki taşta 62 satır – Тоньюкукийн бичээсүүд: Хоёр чулуунаа 62 мөр
8. Ulug Hanoy Gölü (İhe Hanuin Nur) yazıtı: 6 satır –Улуг Ханой Гөлийн (Ихэ Хануйн Нур) бичээс: 6 мөр
9. Hangiday yazıtı: 4 satır – Хангидайн бичээс: 4 мөр

Uygur devri (745-840) yazıtları

---

[493] Д.Д.Васильев, Памятники тюркской рунической письменности Азиатского ареала, I, -Советксая Тюркология, Москва, 1976, №1, стр.71-81; Д.Д.Васильев, Памятники тюркской рунической письменности Азиатского ареала, II, -Советская Тюркология, Москва, 1978, №5, стр.92-95.

[494] O.F.Sertkaya, Köl Tigin'in kitâbesinin dikilmesinin 1250. yıl dönümü dolayısı ile Moğolistan Halk Cumhuriyetindeki Köktürk harfli metinler üzerinde yapılan arkeolojik ve filolojik çalışmalara toplu bir bakış, -Türk Kültürü, XXI/234, Ankara, 1982, s. 747(17)-756 (32); O.F.Sertkaya, Köl Tigin'in ölümünün 1250. yıl dönümü dolayısı ile Moğolistan Halk Cumhuriyetindeki Köktürk harfli metinler üzerinde yapılan arkeolojik ve filolojik çalışmalara toplu bir bakış, -Belleten, Türk Tarih Kurumu, XLVII/185 (Ocak 1983), Ankara, 1984, s. 67-85; O.F.Sertkaya, -Göktürk Tarihinin Meseleleri, Türk Kültürü Araştırma Enstitüsü, yayınları: 131, Seri:IV, Sayı: A.40, Ankara, 1995, s.313-334.

[495] O.F.Sertkaya, Göktürk yazıtları, -ORKUN, Mart, 1996, 1.say, s.24-25.

Уйгурын үеийн (745-840) бичээсүүд

1. Tes yazıtı: 22 satır – -Тэсийн бичээс: 22 мөр
2. Terh (Taryat) yazıtı: 30 satır – Тэрх (Тариат)-ийн бичээс: 30 мөр
3. Bayan Çor veya Moyun Çor (Şine-Usu) yazıtı: 55 satı - Баян Чор буюу Моюн Чор(Шинэ- Ус)-ын бичээс: 55 мөр
4. Hoytu-Tamır yazıtları:10 ayrı yazıt – Хойт-Тамирын бичээсүүд: 10 хэсэг бичээс
5. Kara Balgasun (Orhon-III) yazıtı: 6 satır –Кара Балгасун (Орхон- III)-ы бичээс: 6 мөр
6. Üç köşe (Gurvaljin) yazıtı:1 satır – Үч хөше (Гурвалжин)-гийн бичээс: 1 мөр
7. Somon-Tes yazıtı: 1 satır – Сомон-Тэсийн бичээс: 1 мөр

Кırгız devri (745-840) yazıtları
Киргизийн үеийн (745-840) бичээсүүд

1. Bel (Suci) yazıtı:11 satır – Бел (Сүжи)-ийн бичээс: 11 мөр

Tarihi ve devresi belli olmayan yazıtlar
Түүх, он цаг нь тодорхойгүй бичээсүүд

1. Aru Han yazıtı: 3 satır – Ару Ханын бичээс: 3 мөр
2. Ak-Baş Dağı (Çagan-Tolgoy-I) yazıtı:1 satır – Ак-Баш уул(Чаган-Толгой-I)-ын бичээс
3. Ak-Baş Dağı (Çagan-Tolgoy-II) yazıtı:1satır -Ак-Баш уул (Чаган-Толгой-II)-ын бичээс
4. Öbör-Dörölji yazıtı: 1 satır - Өвөр Дөрөлжийн бичээс: 1 мөр
5. Hentey-I yazıtı: 2 satır -Хэнтий бичээс I: 2 мөр
6. Arts Bogdo (Arka Bogdo, Töv§) yazıtı:1 satır- Арц Богдо (Ар Богдо, Төвш)-ийн бичээс: 1 мөр
7. Beger yazıtı:3-4 yazıtta 4 veya 5 satır – Бэгэрийн бичээс: 3-4 бичээснээ 4-5 мөр
8. Kutuğ-Ula yazıtı: 4 satır – Кутуг –Ула-ийн бичээс: 4 мөр
9. Keçinin Suyu (Yamanı-us) yazıtı: 2 satır – Кечин Сүюу (Яманы-ус)-ны бичээс: 2 мөр
10. Hentey-II yazıtı: 1 satır – Хэнтий II бичээс: 1 мөр
11. Kutlug yazılı mühür yüzük yazıtı:1 kelime - Кутлуг бичээст тамганы бичээс: 1 үг
12. Göktürk harfli para yazıtı: 1 satır: -Хөхтүрэг үсэгтэй зоосны бичээс: 1 мөр
13. Örük (Igde) yazıtı: 4 satır -Өрүк (Игдэ)-ийн бичээс: 4 мөр
14. Tömör-Tsorgo yazıtı: 1 satır - Төмөр-Цоргийн бичээс: 1 мөр
15. Tsahir yazıtı:...satır -Цахирын бичээс: ....мөр
16. Açit Nur (Acı Göl) yazıtı: 1 satır -Ачит Нур (Ажы Гол)-ын бичээс: 1 мөр
17. Açit Nur (Acı Göl) yazıtı: 1 satır -Ачит Нур (Ажы Гол)-ын бичээс: 1 мөр
18. Arts-Bogdo (Töv§) yazıtı: 1 satır -Арц-Богдо (Төвш)-ын бичээс: 1 мөр
19. Arts-Bogdo (Töv§) yazıtı: 3 satır -Арц-Богдо (Төвш)-ын бичээс: 3 мөр
20. Gurvan-Mandal yazıtı I: 2 satır -Гурван-Мандалын бичээс: 2 мөр
21. Gurvan-Mandal yazıtı II: 2 satır -Гурван-Мандалын бичээс: 2 мөр
22. Gurvan-Mandal yazıtı III: 3 satır -Гурван-Мандалын бичээс: 3 мөр

İsimleri bilinip henüz yayımları yapılmayan metinler
Нэрс мэдэгдэж буй ч хэвлэгдэж нийтлэгдээгүй дурсгалууд

1. Yazıt parçası yazıtı: 3 satır -Бичигт хэлтэрхийн /хугархайны/ бичээс: 3 мөр
2. Hotol-us (Tepe suyu) yazıtı: 1 satır - Хотол- ус (Тере сүюу)-ны бичээс: 1 мөр
3. Nogon-Tolgoy yazıtı: 2 satır - Ногон- Толгойн бичээс: 2 мөр
4. Deel-uul yazıtı: 2 satır - Дээл-уулын бичээс: 2 мөр
5. Hatuv-su yazıtı:...satır -Хатув-сугийн бичээс.....мөр
6. Hara-Mangday (Kara alın) yazıtı: 1 satır- Хара-Мангдай (Кара Алын)-н бичээс: 1 мөр
7. Olon-Nur (Çok Göl) yazıtı:1 satır - Олон-Нур (Чок Гол)-ын бичээс: 1 мөр
8. Dellun Somon (Ortalık) yazıtı: 1 satır -Дэллүн Сомон (Товийн)-ын бичээс: 1 мөр

Дээр дурдсан бүртгэл нь тухайн цаг үедээ Монгол нутгаас олдсон руни бичгийн талаарх мэдээг эрдэмтэн судлаачид хийгээд олон нийтэд хүргэж байснаараа ихээхэн ач холбогдолтой юм. Гэвч тэр цагийн байдал болоод бусад шалтгаанаас үүдсэн зарим нэг учир дутагдал буйг тэмдэглэе.

Б.Ринчен академичийн хэвлүүлсэн жагсаалтад буй "Байбалагийн хөшөөний бичээс"-ийг уншиж судалсан зүйл үгүй, бас бичигт чулуу ч алга болсон бололтой (Алга болсон дурсгалууд хэсгээс лавлан үзнэ үү). Бичээсүүдийн нэрийн хувьд бага зэрэг зөрүүтэй байгаа ч огт өөр нэрээр нэрлэж тэмдэглэсэн нь үгүй байна.

Б.Ринчен академичийн мэдээллийн мөрөөр Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн "Бичээс" судлалын хэсгийнхэн замнаж ажилласан гэдгийг дурдах хэрэгтэй.

М.Шинэхүү гуайн гаргасан жагсаалт харьцангуй үнэн зөв, бодит эх сурвалжид тулгуурласан хэмээн үзэж байна. Тэрээр "Орхон бичгийн атлас" зохиохоор төлөвлөж монгол нутаг дахь руни бичгийн дурсгалын нэрсийн жагсаалт гаргахдаа тухайн үеийн Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн "Бичээс" судлалын хэсгийн олон жилийн ажлын тайлан, эх хэрэглэгдэхүүнд тулгуурласнаас гадна өөрийн биеэр очиж үзсэн нь лавтай. Эл жагсаалтад буй *"Юлтын түрэг бичээс", "Битүүгийн өвөлжөөний түрэг бичээс? (Хар бухын гол)* " гэх хоёр дурсгалын талаар ямар ч мэдээлэл алга. Уг бичээс хаана, ямар аймаг сумын нутагт байдаг талаар ч мэдэх зүйл үгүй (Нэр тодорхой ч судлагдаагүй дурсгал хэсгээс лавлан үзнэ үү).

Л.Болд гуайн бүртгэлд зарим нэгэн мадагтай мэдээлэл оржээ. Жишээ нь, "*Тэсийн түрэг бичээс II, Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг Хужирт бригадын нутагт буй Ногоон толгой гэдэг газарт байсан, эдүгээ ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн археологи этнографийн лабораторид буй*" гэжээ. Эшлэл зүүлтээс үзвэл энэ нь Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хужирт бригадын нутаг Авдрантын хөндий гэдэг газраас олдсон Тэсийн бичээс мөн байна.

"*Тэвшийн түрэг бичээс II, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш ууланд буй түрэг бичээс, Окладников А.П, Петроглифы центральной Азии Хобд-сомон (Гора Тэбш) Л.,1980. стр.52.табл.116*" гэж тэмдэглэсэн, "*Хар цагаан усны түрэг бичээс, 1982 онд Увс аймгийн Баруун турууны САА-н нутаг Хар цагаан ус гэдэг газарт буй, Цэвээндорж Д, Монголын төмөр, хүрэл зэвсгийг судлах шинжилгээний ангийн тайлан, УБ.,1980 (гар бичмэл). БНМАУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн фонд*" хэмээн дурдагдсан эл хоёр бичээсийн талаарх өгүүлсэн тодорхой байрлал, судлагдсан эсэх талаар бидэнд ямар ч мэдээлэл байхгүй байна.

Туркийн эрдэмтэн О.Ф.Серткаяа "Köktürk Yazıtları /Хөхтүрэгийн бичээсүүд" хэмээх нийтлэлдээ монгол нутаг дахь руни бичгийн дурсгалыг жагсаасныг үгчлэн орчуулж дурсгалын нэрсийг кирилл үсгээр үсэгчилэн буулгав. Уг жагсаалтад зарим газар, дурсгалын нэрийг нилээд алдаа мадагтай бичсэн нь учир үл мэдэх нэгэн ташааран будилахад хүргэхээр байна.

Мэдээж хэрэг, хэрхэн яаж бичих, нэрлэх нь зохиогчийн хэрэг мөн боловч газар ус, дурсгал бичээсийн нэрийг дур мэдэн өөрчлөх, орчуулан хэрэглэх нь ташаарал, андууг арвитгаж шинжлэх ухаанд багагүй маргаан, төөрөгдөл үүсгэдгийг анхаарах хэрэгтэй мэт санагдана.

Хэдүйбээр зарим нэрийг шаардлагын дагуу орчуулан хэрэглэх нь буй боловч газар усны нэрийг тухайн нутгийнхны эртнээс нааш нэрлэсээр ирсэн уламжлалыг даган баримтладаг нь эрт эдүгээгийн соёлт ёс төдийгүй шинжлэх ухаанд ч бүртгэн тэмдэглэхдээ энэ зарчмыг баримталдаг бөлгөө.

1.6.1. Дахин нягтлан судлууштай дурсгалууд

Монголын руни бичгийн дурсгалуудаас, нэн ялангуяа бага бичээсийн нилээд дурсгалыг дахин нягтлан судлууштай байна. Судлахад бэрхтэй, судалгаа нь маргаантай бичээсийн заримыг XIX зууны үед, тодруулбал В.В.Радловын үед судалгааны эргэлтэд орсон ч өнөө хүртэл дахин нягталж үзээгүй, шүүн шинжлэх эрдэмтдийг хүлээсээр байна.

Нэгэнт шүүн нягталсан чамбай бүтээл үгүй тул шинэ тутам олон ном, бүтээл гарч байгаа ч өмнөх судалгааг дахин хуулах, даган баримтлах нь түгээмэл болжээ.

Ерөнхийд нь авч үзвэл хэд хэдэн учир шалтгаантай бололтой. Үүнд;

- өмнөх эрдэмтдийн судалгааг сайн болсон гэж үзэж даган баримтлах,
- газар усны холоос ирж судлах боломжгүй учир аргагүйн эрхэнд дам хуулбарт шүтэж дагах,
- нар салхи, цас бороо зэрэг байгалийн сүйтгэлд автсанаас уг бичээсийг дахин уншиж судалсан ч өмнөх судалгааг давах хангалттай баримт нуталгаатай шинэлэг ажил болоогүй,
- эх буюу уг дурсгал алга болсон зэрэгтэй шууд холбоотой юм.

Нэг талаас, дээр өгүүлсэн зүйл үнэний хувьтай ч яг газар дээр нь уул бичиг, бичээсийг уншиж судлахаар зорин очигсод, дорвитой судалгаа хийгсэд цөөн аж. Дахин нягтлан судлууштай дурсгал олон байгаа ч энэ удаад зөвхөн Монголын төв нутгаар буй зарим бага бичгийн дурсгалыг жишээ болгон өгүүлсүү.

Үүнд,

-Хөл асгатын бичээс
- Тайхар чулууны бичээс
- Чойрын бичээс
- Зөвхөн нэг судлаач судалсан бүх бичээс орно.

Үсэг бичгийн, судалгааны зөрүүтэй санал бүхүй эдгээр дурсгалуудаас гадна орчуулгын ташаарал, мадгийг арилган дахин нягтлан орчуулууштай цөөнгүй бичээс буй.

Бичээсийг уншиж галиглах нэг хэрэг боловч түүнийг зөв оновчтой орчуулж, тайлбарлах нь зарим тохиолдолд уншихаас илүү нарийн нягт, бэрх хэцүү чимхлүүр ажил болой. Үүний учир Монголын руни бичиг, дурсгалтай холбогдох шилдэг судалгааг монгол хэлнээ зөв орчуулах нь дахин нягтлах, судлах ажлын салшгүй нэг хэсэг болохыг манай эрдэмтэд, судлаачид анхаарах буй за.

Хөл Асгатын бичээс

Булган аймгийн Могод сумын нутаг, Түлээ уулын хормойд орших тахилын онгон дурсгалыг эрдэмтэд Их Асгатын бичээс, Хөл Асгатын бичээс хэмээн нилээд ялгаатай нэрлэсээр ирсэн байна. В.Радлов анх судлан үсэг, үгийн галиг хийж герман орчуулгын хамт хэвлүүлсэн байна[496].

Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун орчин цагийн турк хэлнээ. В.Радловын уншлага, орчуулгаас хөрвүүлжээ [497] . Хожим С.Е.Малов дахин уншиж судлан орос хэлнээ орчуулжээ[498].

---

[496] W.Radloff , Die Inschrift von Iche-As'chete, -Die alttürkischen inschriften der Mongolei, Dritte Lieferung (Verbesserungen, Zusätze und Bemerkungen zu den Denkmälern von Koscho-Zaidam, die übrigen Denkmäler des Orchon-Beckens und die Denkmäler im Flußgebiete des Jenissei) Neudruck der Ausgabe St.Petersburg, 1895, (Osnabrück, 1987), pp.256-258.

[497] H.N.Orkun, İhe Ashete yazıtı, -Eski Türk Yazıtları II, İstanbul, 1938, s.122-127. s.313-319.

[498] С.Е.Малов, Памятники Ихе-Асхете, -Памятники древнетюрской письменности Монголии и Киргизии, Москва-Ленинград,1959, стр. 44-46.

Манай эрдэмтдээс Б.Ринчен академич бүтээлдээ гэрэл зургийг нь хэвлүүлсэн[499] ба доктор Н.Сэр-Оджав уул цогцолбор дурсгалын хэмжээ байршил, хүн чулууны хэлбэр хийц зэргийг товч тодорхойлоод бичээсийн хувьд С.Е.Маловын уншлага, орчуулгад ташаарсан зүйл мэр сэр байгааг тэмдэглэж өөрийн саналаа дурджээ[500].

Доктор Л.Болд Хөл Асгатын бичээсийн талаар эхний бүтээлдээ эрдэмтдийн судалгааг тоймлон дурдаж удаах номдоо бичээст гарах үгийг монгол түрэг хэлний хүрээнд харьцуулан тайлбарласан байна[501].

Тайхар чулууны бичээс

Тайхар чулууны руни бичээсийг В.В.Радловоор удирдуулсан шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан Д.А.Клеменц анх гар хуулбар хийж тэмдэглэснээр "Хойт Тамирын бичээс" хэмээн нэршиж эрдэм шинжилгээний эргэлтэд оржээ. Тэдгээр бэхэн бичээсийг анх В.В.Радлов уншиж судалсан[502] бөгөөд түүний уншлага нийтлүүлсэн эх хуулбар хийгээд уншлага орчуулгыг Х.Н.Орхун орчин цагийн түрэг хэлнээ хөрвүүлжээ[503].

С.Е.Малов эл бичээсийг дахин нягтлаад орос хэлнээ орчуулжээ[504].

П.Аалто нарын "Монгол дахь эртний түрэгийн хөшөө дурсгалын эх хэрэглэгдэхүүн" [505] –д Тайхар чулууны бичээсийн талаар дурдсан байдаг. Академич Б.Ринчен бүтээлдээ гэрэл зургийг нь хэвлэсэн ажээ[506]. Нэрт түүхч Х.Пэрлээ гуай "Тайхар чулуу" хэмээх тусгай товхимолдоо руни бичээсийн өмнөх хуулбаруудаас зөрүүтэй байгаа хэд хэдэн хуулбарыг хэвлүүлсэн байна[507].

Д.Д.Васильев "Хойт Тамирын дурсгалын бичээсийн онцлогууд" өгүүлэлдээ бэхэн бичээсийн эл дурсгалын үсэгзүйн онцлогийн талаар тухайлан өгүүлсэн байна[508]. Туркийн эрдэмтэн проф. О.Ф.Серткаяа түрэг судлаач С.Харжаубай нар "Hoyto Tamır (Moğolistan)dan yeni yazıtlar (ön neşir)" хэмээх өгүүлэлдээ нийтдээ 21 бичээсийн үсэг, үгийн галиг, орчин цагийн турк хэлнээ орчуулсан нь Тайхар чулууны бичээсийн талаар нийтэлсэн хамгийн сүүлийн судалгаа болох юм[509].

Тайхар чулууны эртний бичээсүүд он цагийн уртад нар салхи, цас борооны усанд идэгдэж муудснаас гадна ухвар мөчид хүмүүсийн сүйтгэлд ихээхэн өртөж судлахад нэн бэрхтэй болжээ. Тиймээс ч Тайхар чулууны руни бичээсийн талаар харилцан адилгүй санал

---

[499] Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, --Corpus Scriptorum Mongolorum,Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp. 34-36.

[500] Н.Сэр-Оджав, Их Асгатын хөшөөт булш, -ШУА-ийн мэдээ №3, Улаанбаатар, 1965, 91-95 дугаар тал; Н.Сэр-Оджав, Эртний түрэгүүд (YI-YIII зуун), Улаанбаатар, 1970, 43-46 дугаар тал; Н.Сэр-Оджав, Монголын эртний түүх, Улаанбаатар, 1977, 141 дүгээр тал; Н.Сэр-Оджав, Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл, Улаанбаатар, 2003, 239-243 дугаар тал.

[501] Л.Болд, Хөл Асгатын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 129-134 дүгээр тал; Л.Болд, Хөл Асгатын Орхон бичээсийг уншсан тэмдэглэл, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар,2000, 67-85 дугаар тал.

[502] W.Radloff , Die Inschriften am Choito-Tamir, -Die alttürkischen inschriften der Mongolei, Dritte Lieferung (Verbesserungen, Zusätze und Bemerkungen zu den Denkmälern von Koscho-Zaidam, die übrigen Denkmäler des Orchon-Beckens und die Denkmäler im Flußgebiete des Jenissei) Neudruck der Ausgabe St.Petersburg, 1895, (Osnabrück, 1987), pp.260-268.

[503] H.N.Orkun, Hoytu-Tamır yazıtları, -Eski Türk Yazıtları II, İstanbul, 1938, s.107-117. s.299-309.

[504] С.Е.Малов, Памятники Хойто-Тамира, - С.Е.Малов, Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии, Москва-Ленинград,1959, стр. 46-54.

[505] P.Aalto, G.J.Ramstedt, J.G. Granö, Materialien zu den alttürkischen Inschriften der Mongolei,- Journal de la Société Finno- Ougrienne, LX/7, Helsinki, 1958, pp.3-91.

[506] Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, --Corpus Scriptorum Mongolorum,Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.34-36.

[507] Х.Пэрлээ,Тайхар чулуу, -Studia Archaeologica,Tom.I, fasc. IV,Улаанбаатар, 1960, 1-26 дүгээр тал .

[508] Д.Д.Васильев, Графические особенности памятников Хойто- Тамира, - Вопросы восточного литературоведения и текстологии, Москва, 1975, стр.100-109.

[509] O.F. Sertkaya, S.Harcavbay, Hoyto Tamır (Moğolistan)dan yeni yazıtlar (ön neşir), -Türk Dili Araştırmaları Yıllığı Belleten 2000 , Ankara, 2001, s.313-346.

гарч байгаа юм. Бидний судалгаагаар 30 орчим руни бичээс байгааг олж тогтоосон бөгөөд удахгүй хэвлэн нийтлэх гэж байна[510].

Чойрын бичээс

Дорноговь аймгийн Чойр өртөөнөөс баруун тийш 15 орчим км-т орших Бага Сансар уулнаа байсан нэгэн хиргисүүрт булш, булшны дараас овоолгот чулуун дотор байсан хүн чулууны цээж, өвөрт сийлсэн бичээсийг судалгааны ном зохиолд "Чойрын бичээс" хэмээн нэрлэн тэмдэглэсээр иржээ. Улаан хүрэн өнгөтэй хүрмэн чулууг засаж янзлан хүний зөвхөн нүүрэн хэсгийг маш тодорхой, бодит байдлаар нилээд ур хийцтэй дүрсэлсэн байх бөгөөд харин бичээсийг эмх журам, дараалал муутай сийлсэн байна. Нутгийн ард "Жанжин Чойрын хөшөө" гэж нэрлэж байсан хэмээнэ. Манай монголчууд Дэмчигбурмын хөшөө(*Өвөрхангай аймгийн Баруун-Баян Улаан сумын нутаг, Хутаг уулын Зосын Сайр хэмээх газар буй*), Даян баатрын хөшөө (*Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутаг, Даян нуурын хөвөөнд буй),* Далха Вандад (*Булган аймаг, Ингэтолгой сангийн аж ахуйн ойр буй*), Гэлэн хөшөө (*Хэнтий аймгийн Өндөрхаан хотын нисэх онгоцны буудлаас баруун урагш 3 км орчимд буй*) гэх мэтээр хүн чулуунд нэр өгөх нь элбэг бөлгөө. Эртний түүх домог, цадиг намтар, түүгээр дамжин уламжлагдсан аман түүхийн гэрч нь хөшөө чулуу байдаг бөгөөд өвөг дээдсийн тэдэнд хайрласан нэрс түүнтэй салшгүй холбоотой төдийгүй бас нарийн ухаж ойлгож чадвал зарим судлаачийн дэмий хоосон таамаглалаас ч илүү их үнэ цэнэтэйг өгүүлэх юун.

Чойр нэр бидний санахад  chos- ном,  ri -уул гэсэн хоёр үг хоршиж "номтой уул, бичигтэй уул" хэмээх нэр бүтээсэн бололтой. Хуучин цагт, үсэг, бичиг бүрийг ялгалгүй ном хэмээн дээдлэн хүндэтгэж байсны илрэл буй за.

Энэхүү бичигт хүн чулууг В.А.Обручев 1895 онд анх үзэж тэмдэглэсэн ажээ[511]. Хожим 1928 оны 9-р сард Эрдэмбаяр хиргисүүр, хөшөөний анхны байрлал зэргийг тодорхой харуулсан гэрэл зураг авч харин утасны хорооны Цэндсүрэн гэх нэгэн Улаанбаатар хотод тээвэрлэн хүргэж иржээ.

Ж.Цэвээн гуай хүсэлт гаргаж улмаар түүний зааврааар энэ ажлыг гүйтэтгэсэн гэдэг. Судар бичгийн хүрээлэнгээс уг дурсгал, бичээсийн 4 ширхэг гэрэл зураг, хүн чулуун дээрх бичээсийн гар хуулбар зэргийг 1928 онд ЗХУ-ын Шинжлэх Ухааны Академид илгээсэнд[512] анх А.Н.Самойлович гардан авсан байна. Тэрээр өөрөө уншиж судалсан эсэх нь тодорхойгүй, юутай ч С.Е.Маловт тэр захидал бичээсийн тухай мэдээллийг дамжуулан өгсөн гэх аман мэдээ л үлджээ.

Ж.Цэвээн гуайгаас 1933 оны 5-р сард С.Е.Маловт Чойрын бичээсийн гэрэл зураг болон гар хуулбар дахин ирсэнд "нөхрийн сайн үйлст энэ тусыг бодож" 1936 онд урьдчилсан уншлага судалгаагаа хэвлүүлсэн[513] ажээ.

Чойрын бичээсийг нүдээр үзэж судалсны хувьд С.Г. Кляшторный[514] тухайлсан эрдэм шинжилгээний өгүүллүүд нийтлүүлсэн байна.

Тэрээр бичээсийг;

1. ... ilig yty säbin baryŋ

---

[510] Бичээс судлалын дадлагын тайлан, -Түрэг судлалын тэнхмийн гар бичмэлийн сан, 2004.

[511] В.А.Обручев, Список древных могил, замеченных на пути из Кяхты в Ургу и Калган, -Сборник трудов Орхонской экспедиции, II,СПб.,1895, стр.76.

[512] Архив. Судар бичгийн хүрээлэнгээс гадаадад явуулсан захидал.

[513] С.Е.Малов, Новые памятники с турецкими рунами, -Язык и мышление,Том.VI-XII, Ленинград, 1936, стр. 251-259.

[514] С.Г.Кляшторный, Руническая надпись на каменном изваянии Из Чойра, - Памятники письменности и проблемы истории и культуры народов Востока, Ленинград, 1969, стр.46-49; С.Г.Кляшторный, Руническая надпись из Восточной Гоби, -Studia Turcica, Budapest,1971, pp.249-258; С.Г.Кляшорный, Древнетюркская надпись на каменном изваянии из Чойрэна, - Страны и народы Востока, Вып.22, Кн.2, Москва, 1980, стр. 90-102.

2. ältäris qaγanqa
3. tun bilgä
4. tun jägän irkin
5. jäti qa (aqa?) adyrylmaz tutunuz da
6. toñ [uquq]... [i] tdim yrqučun (?) äb aγyl baŋa... гэж галиглан орос хэлнээ
1. ...государь (меня) послал: "Радуйся и иди!" (он сказал)
2. От Эльтэриш-кагана
3. (вы) Тун-бильгэ,
4. Тун-йеген-иркин,
5. вы, семь родичей (братьев?) смотрите не отделяйтесь же
6. Я, Тонь [юкук], (государство?) привел в порядок (создал).

Ради предсказания (? ради <моего> предвидения? за <мои> советы?) дома и загоны для скота мне... хэмээн орчуулжээ.

С.Г.Кляшторный абугайн орос орчуулгыг доктор Л.Болд монгол хэлнээ

1. ...улс (намайг) илгээв. үг нь очиж...
2. Елтирис хагаанаас
3. Тун-Билгэ
4. Тун-йегин-иркин
5. долоон ах бүү салтугай
6. Тонькук би...илгээв... (урьдчилан хэлсэн ёсоор) гэр бэлчээрт минь[515] хэмээн буулгажээ.

Эл орчуулгаас гадна доктор Ё.Жанчивын үгчлэн буулгасан бас нэгэн орчуулга буйг сийрүүлбэл;

1. ...хаан (намайг) илгээв: "Хөөрөн баяс, явж од!" (тэр өгүүлэв)
2. Эльтериш хаанаас
3. (Та) Тун-бильгэ,
4. Тун-йеген-иркин,
5. Та нар, долоон төрөл садан (эсвэл нэг овгийнхон Ё.Ж) (ахан дүүс?) харцгаа, бүү салан од!
6. Би, Тонь [юкук], (улсыг?) эмх журамд оруулав (үүсгэн байгуулав). Урьдчилан хэлсэн ёсоор

(? <миний> урьдчилан харсан ёсоор? <миний> зөвлөлгөөнөөр?) гэр ба малын хашаа надад...

Чойрын гэрэлт хөшөөний бичээсийн утга агуулгыг судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлүүдэд С.Г.Кляшторный уншлага орчуулгад тулгуурлан тайлбарлаж, эшлэсээр ирсэн билээ.

Харин 1998 онд Туркийн эрдэмтэн О.Ф.Серткаяа эл бичээсийг дахин уншиж судлан турк, герман хэлээр хэвлүүлсэн нь бичээсийг дахин нягтлан судлах шаардлагатайг харуулж байна. Бичээсийг эмх замбараа муутай тойруулан бичсэн нь судалгааг ихээхэн маргаантай болгож байгаа юм. Судалгааг харьцуулан үзээсэй хэмээж С.Ф.Серткаяа профессорын сэргээсэн руни бичгийн эх, галиг орчуулгыг толилуулъя.

Бичээсийн эхийн сийрүүлгэ;

1. 𐰚𐰇𐰃𐰍𐰀 𐰴𐰃𐰋𐰇𐰾𐰆𐰋𐰢𐰴𐰃𐰍𐰴
2. 𐰚𐰾𐰋𐰃𐰢𐰢𐰋𐰾𐰃𐰋𐰾
3. 𐰋𐰍𐰏𐰍 𐰋𐰍𐰀𐰉 𐰴𐰆
4. 𐰾𐰃𐰉 𐰚𐰀𐰖𐰢 𐰴𐰆
5. 𐰚𐰃 𐰍𐰋𐰉 𐰀 𐰾𐰖𐰍 / /(?)𐰃 𐰚𐰃𐰴𐰢𐰃 𐰍𐰢𐰋𐰖𐰍
6. 𐰇𐰋𐰃 𐰍𐰋𐰢𐰀 𐰍𐰋𐰀𐰍

Үгийн галиг;

1. tulku b(i)t(i)d[d](im) ırk (a)çu (a)yg(ı)l b(a)nga

---

[515] Л.Болд, Чойрын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 143-145 дугаар тал.

2. (a)d(ı)r(ı)lm(a)z t(a)t b(a)rda /// /// ///
3. tun y(i)g(e)n (i)rk(i)n (ı)
4. tun b(i)lge şad
5. ilt(i)r(i)ş k(a)g(a)nka (i)ç(i)k(i)ng üç(ü)nç (a)y y(i)ti ka
6. ögüni sebini barıng[(ı)z]

Орчин цагийн турк хэлээрхи хөрвүүлгэ;

1. Taş baba üzerine yazdırdım. Fal açarak söyle bana!
2. Birbirinden ayrılmayan yabancı [düsman] olduğu zaman
3. Tun Yigen İrkin
4. Tun Bilge Şad
5. İltiriş Kağan'a tabi olun (?). Üçünc(ü) ay(ı)n yedi(nci günün)de
6. sevinerek gidin(iz)[516]

Бичээсийн герман хэлээрх орчуулга;

1.Zeile: Ich habe (es) auf die Stein-Baba schreiben lassen. Sag mir, indem Du wahrsagst.
2. Zeile: İndem Fremde (Feinde), die zusammenhalten, zugegen sind.
3. Zeile: Tun Yigen İrkin
4. Zeile: Tun Bilge Schad
5. Zeile: Sei untergeben dem Khagan, İltiriš (?) Am 7. Tag des 3. Monats.
6. Zeile: Gehen Sie fröhlich[517] ийм болой.

О.Ф.Серткаяагийн орчуулгыг монгол хэлнээ үгчлэн буулгавал;

1. Хүн чулуун дээр бичүүлэв би. Мэргэлээд надад хэл!
2. бие биенээс үл хагацах харь (дайсан) байх цагт
3.Тун Ийген Иркин
4. Тун Билгэ шад
5. Илтириш хаанаа захирагд (а-гтун). Гуравдугаар сарын долоо (дахь өдөр)-т
6. баярлан (баясан) явцгаа (та нар).

Уг бичээсийн хоёрдугаар мөрийг уншсан уншлага, турк, герман орчуулгын аль алийг нь ухаарч ойлгоход бэрхтэй, монгол хэлнээ буулгахад ч төвөгтэйг онцлон хэлье.

Түрэг судлаач нэрт эрдэмтэд С.Г.Кляшторный, О.Ф.Серткаяа нарын хэн нь зөв уншсан, хэн нь юун дээр алдаж оносон зэргийг шинжлэх ухааны үүднээс бодитой үнэлж дүгнэсэн дараа дараагийн судлагаанаас улам тодорхой болох бизээ. Чойрын бичээсийг уншиж судалсан дээрх бүтээлээс гадна бас бусад судалгаа ч буй[518] .

---

[516] Osman Fikri Sertkaya,Göktürk harfli Çoyr Yazıtı, -Orkun, Türkçü Dergi, 5.sayı, Temmuz 1998, s.33-38; Osman Fikri Sertkaya, Die Runen-Inschrift von Čoir, Bahşı Ögdisi Festschrift für Klaus Röhrborn anläßlich seines 60.Geburtstags, Sonderdruck, Türk Dilleri Araştırmaları Dizisi:21, Freiburg· İstanbul 1998, pp.349-361.+ 4 pl.

[517] Osman Fikri Sertkaya, Die Runen-Inschrift von Čoir, Bahşı Ögdisi Festschrift für Klaus Röhrborn anläßlich seines 60.Geburtstags, Sonderdruck, Türk Dilleri Araştırmaları Dizisi:21, Freiburg· İstanbul 1998, pp.349-361.+ 4 pl.

[518] Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie,-Corpus Scriptorum Mongolorum,Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968; Edward Tryjarski, On the Archaeological Traces of old Turks in Mongolia, - East and West, New Series, 21/1-2, Rome, 1971; E.Tryjarskı, Eski Türklerin Moğolistan'daki arkeolojık eserleri üzerine, -Türk Kültürü Araştırmaları, XVI/1-2 (1977-1978), Ankara, s.151-184, s.161; Nejat Diyarbekirli, Orhun'dan geliyorum, - Türk Kültürü, sayı:198-199, yıl:XVII, Nisan-Mayıs 1979, s.382 (62); Erk Yurtsever, Eski Türk yazıtları için bir tavsih ve iki zeyl,-Orkun, Aylık Türkçü Dergi, Kasım 1988, sayı:9, s.18-20.

1.6.2. Нэр мэдэгдэж буй ч судлагдаагүй дурсгал

Эрдэмтдийн хэвлүүлсэн руни бичгийн дурсгалын нэрсийн жагсаалт, эрдэм шинжилгээний тайлан, цуглуулсан эх хэрэглэгдэхүүнээс үзэхэд бичээсийн нэр тодорхой байгаа боловч өнөө хэр уншиж судлаагүй, мэдээллийн мөрөөр дахин шалгаж үзээгүй, аль аймаг, сумын нутагт байдаг нь тодорхой бус дурсгал нилээд хэд байна.

Зарим мэдээллийг бичиг судлаач нар хараахан олж үзээгүй, мэдээллийг олж сонссон нэгэн тэдгээр бичээсийн газар хүрч судлах боломж бололцоо багатай, зорин очивч ганц нэг мөр бичээсийг хэд хичнээн км үргэлжлэх уул, нуруу, хад асга дундаас олж судлах нь амаргүйгээс зарим тохиолдолд ганзага хоосон буцсан нь буй.

Тиймээс монгол нутагт руни бичгийн яг хэдэн дурсгал байгааг баттай, нуталгаатайгаар тодорхой тоогоор хэлэхэд нэн бэрхтэй.

Үүний учир нэр мэдэгдэж буй судлагдаагүй зарим дурсгалын талаар товч өгүүлье.

Нэр мэдэгдэж буй ч судлагдаагүй дурсгалуудад одоогийн байдлаар доорхи 9 бичээсийг оруулж байна. Үүнд;

1. Байбалагийн хөшөө
2. Битүүгийн өвөлжөөний түрэг бичээс? /Хар бухын гол/,
3. Юлтын түрэг бичээс
4. Хөтөл усны бичээс
5. Ногоон толгойн бичээс
6. Цахирын бичээс
7. Далан уулын бичээс
8. Бигэрийн бичигт хадны бичээс
9. Дэлүүн сумын төвийн бичээс

Байбалагийн хошооний түрэг бичээс

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын төвөөс баруунш 11 км гаруй, Сэлэнгэ мөрнөөс хойш 2 км орчим зайтай голын хөндий, хойд уулсын хормойн дэвсэц уулзвар болох хуурай тэгш дэнжид Бийбулагийн балгас буюу эртний Байбалык хотын туйр (Газарзүйн байрлал: Хойд өргөргийн 49^0 23' 38", зүүн уртрагийн 102^0 30' 21", далайн төвшнөөс дээш 1127 м өндөрт) бий[519]. Худалдаа арилжаа, шашин соёлын нэгэн төв болж байсан эртний энэ хотыг байгуулсан тухай мэдээ руни бичгийн сурвалжид анх тэмдэглэгдсэн байна[520].

Нэрт эрдэмтэн Г.И.Рамстедтийн "Уйгур улсын хураангуй түүх" (Улсын Үндэсний номын сангийн хэвлэмэл эхэд энэ нэрээр, харин ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөгт буй гар бичмэлд "Уйгур улсын түүхийн товч" гэсэн нэрээр буй)[521]-

---

[519] Д.Баяр, Н.Ширайши, Ц.Баттулга, Бийбулагийн балгасыг судалсан хээрийн шинжилгээний хэсгийн тайлан, 1998, -ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг; Монгол-Япон улсын хамтарсан "Бичээс" төслийн археологийн хэсгийн тайлан, 1997, -ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

[520] G.J.Ramstedt, Zwei uigurische Runeninschriften in der Nord-Mongolei, Mémoires de la Socitété Finno-OugrienneHelsinki,1913-1918, Vol.XXX.N 1; Г.И.Рамстедт, Перевод надписи Селенгинского камня, -Труды Троицкосавско-Кяхтинского отделения Императорского Русского геогрфического общества. Вып.1, Санкт-Петербург, 1914; Ц.Баттулга, Орхоны руни бичгийн сонгодог дурсгалд нэр тэмдэглэгдсэн гурван хот, -Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, XYIII боть, МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001, 109-118 дугаар тал.

[521] G.I. Ramstedt, Uyiγur ulus-un teüke-yin tobči, -Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг (монгол бичгээр) Ф.IV, ХН.16,Т.56. 1924; G.I. Ramstedt, Uyiγur ulus-un teüke-yin tobči, -Улсын төв номын сан (монгол бичгээр) Ф.IV, ХН.16,Т.56. 1924.

д болон хожмын түүхч, археологич нарын судалгааны бүтээлд[522] уг хотын талаар нилээд тодорхой дурджээ.

Байбалыкийн туйрын газар бичигт хөшөө байсан мэдээ баримтыг анх Б.Ринчен академич толилуулсан[523] билээ.

Доктор Д.Баяр "Уйгурын Байбалык хотын тухай тэмдэглэл"-ийнхээ "Бичигт хөшөөний тухай" хэсэгт "Академич Юншээбүү Ринчен авгай 1968 онд хэвлүүлсэн "Монгол нутаг дахь хадны бичээс, гэрэлт хөшөөний зүйл" хэмээх номдоо руни үсгийн тэмдэгт болон тамгын дүрс бүхий нэгэн хөшөөний бүдэгхэн гэрэл зураг, хуулбарыг нийтэлж "Байбалыкийн хөшөөний түрэг бичээс, тамгын зүйл" гэсэн тайлбар бичсэн байна. Түүнчлэн түрэг судлаач С.Г.Кляшторный 1977 онд Пенжикент хотноо зохиогдсон эрдэм шинжилгээний хуралд толилуулсан "Монголын эртний хотууд" илтгэлдээ 1975 онд Байбалыкт очиж хайгуул судалгаа хийх үед хэрмийн зарим байгууламжийн хашаан дотор руни бичиг болон тамга бүхий хөшөөд байлаа гэж тэмдэглэсэн нь буй"[524] гэж тодорхой өгүүлжээ.

Б.Ринчен академичийн хэвлүүлсэн "Байбалагийн хөшөөний бичээс, тамгын зүйл" хэмээх нилээд тод, 12 үсэг тэмдэгт бүхий хөшөө чулууны гэрэл зураг, бас ганц тамгын зураг хавсаргасан байх бөгөөд хөшөө чулууны гэрэл зураг дээрх бичээсийн зарим үсэг тэмдэгт, гэрэл зургаас дам буулгаж хамт хадсан хуулбарын үсэг тэмдэгтээс зөрүүтэй ажээ. Уг бичээсийг нарийвчлан үзвээс Билгэ хааны тахилын онгоны бичигт зэл чулуу мөн болох нь тодорхой байна. Тухайн үед андууран "Байбалагийн хөшөөний бичээс"-ийн оронд дурдсан зэл чулууны бичээсийн зургийг тавьж ташаарсан бололтой.

Байбалык хотын туйр, одоогийн Бийбулагийн сүмийн газар бичигтэй, ядаж ганц нэг үсэгтэй хөшөө чулуу байхгүй бөгөөд он цагийн нар салхинд үсэг бичиг нь элэрч долорч унаснаас огт мэдэгдэхгүй болсон байж мэднэ.

Доктор Д.Баярын тэмдэглэсэнчлэн "энд нарийвчилсан хайгуул хийхээс өмнө уг хөшөө үрэгдэж алга болсон буюу эсвэл цаашид хаа нэгтэйгээс олдож болохыг үгүйсгэх аргагүй"[525] юм.

Юутай ч 1975 онд уг бичигт хөшөө байсныг нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный гуайн мэдээлэл баталж байна. Байбалык хотын туйрын талаар Тошио Хаяаши, Нориюуки Ширайши, Койчи Мацуда нарын судалгаа буй билээ[526].

---

[522] Х. Пэрлээ, Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон, Улаанбаатар,1961, 51-52 дугаар тал; Х.Пэрлээ, Монголын эртний сөнөсөн хот, суурины түүхийн асуудалд, Улаанбаатар, 1956; С.В. Киселев, Древние города Монголии, -Советская Археология. №2, 1957, стр. 97; Ю.С.Худяков, Памятники уйгурской культуры в Монголии, -Центральная Азия и соседние территории в средние века, Новосибирск,1990.

[523] Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc.1, Oulanbator, 1968, pp.69.

[524] Д.Баяр, Уйгурын Байбалык хотын тухай тэмдэглэл,-Studia Archaeologica,Tom.(I) XXI, fasc. 1-16, Улаанбаатар, 2003, 96 дугаар тал; С.Г. Кляшторный, Древние города Монголии, Древние города, -Материалы к Всесоюзной конференции, Культура Средней Азии и Казахстана в эпоху раннего средневековья (Пенджикент, Октябрь 1977г.) Ленинград,1977, стр.65.

[525] Д.Баяр, Уйгурын Байбалык хотын тухай тэмдэглэл,-Studia Archaeologica, Tom.(I) XXI, fasc. 1-16, Улаанбаатар, 2003, 97 дугаар тал.

[526] 林 俊雄・白石典之・松田孝一・バイバリク遺蹟・-モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999 年 3 月 (Toshio Hayashi, Noriuki Shiraishi, Site of Bay-Balïq, -Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999). pp.196-198.

Битүүгийн өвөлжөөний түрэг бичээс

М.Шинэхүү "Битүүгийн өвөлжөөний бичээс (Хар бухын гол?)"[527] гэж тэмдэглэснээс үзвэл өөрийн биеэр очиж үзээгүй байж магадгүй.

Х.Пэрлээ гуайн "Хадаасангийн Битүүгийн бууц"-ны бичээс[528] хэмээснээс дам авсан байж мэднэ.

Энэ бичээс нь Хар бухын голоор баримжаалбал Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт байдаг бололтой. Одоогийн засаг захиргааны хуваариар өөр өөр сумын нутагт харьяалагдаж байгаа хэдий ч 100-150 км-т газар Хангидайн хадны бичээс, Арханангийн бичээс, Гурвалжин уулын бичээс зэрэг уйгурын үед холбогдох хэд хэдэн дурсгал байгаа нь Дашинчилэн сумын нутагт Битүүгийн өвөлжөөний бичээс байх бүрэн үндэслэлтэйг харуулж байна.

Юлтийн түрэг бичээс

Юлт нэртэй газар хаана байх талаар бид асууж сурагласан боловч хараахан тодорхой мэдэж амжсангүй. М.Шинэхүү гуай "Орхон бичгийн атлас"-т[529] оруулахаар бичсэнийг бодоход уг бичээсийг өөрийн нүдээр үзсэн нь мэдээж бөгөөд харин уншиж тайлсан эрдэм шинжилгээний өгүүлэл, тэмдэглэл байхгүй байна.

Монгол улсын газар усны нэрийн тольд ч Юлт хэмээх уул, гол ус тэмдэглэгдээгүй байна. Юлтийн түрэг бичээсийг манай судлаач нар сурвалжилж мэдээд уншиж тайлах буй за.

Хөтөл усны бичээс

О.Ф.Серткаяагийн нийтлүүлсэн жагсаалтад Hotol-us (Tepe suyu) yazıtı: 1 satır гэж байх бөгөөд тэрээр 1960-д оны үед Арбогдын бичээстэй хамт Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумнаас олсон болохыг тэмдэглэжээ[530]. Манай эрдэмтдийн нийтлүүлсэн жагсаалт, судалгааны бүтээлд эл бичээсийн тухай огт дурдаагүй ажээ.

Ногоон толгойн бичээс

Энэ бичээсийн талаар О.Ф.Серткаяагийн жагсаалтад[531] байх бөгөөд манай эрдэм шинжилгээний тайлан, эх хэрэглэгдэхүүнд тэмдэглэсэн зүйл алга байна. Энэ бичээс нь 2 мөр гэж тэмдэглэснээс үзэхэд нилээд баттай сурвалжаас авсан бололтой байна.

1977 онд Хэнтий аймгийн Дархан сумын Ногоон Толгой гэдэг газраас Х.Пэрлээ анх олсон гэжээ.

Жич, проф. О.Ф.Серткаяагийн "(Arts Bogdo (Arka Bogdo, Tövş)- үгчлэн орчуулбал, Ар богд, Төвш) 1 satır, Arts-Bogdo (Арц Богдо) (Tövş) yazıtı II: 1 satır, Arts-Bogdo (Арц Богдо) (Tövş) yazıtı III: 3 satır" гэсэн гурван бичээсийг бид "Тэвшийн бичээс"-ийг нэрлэсэн олон хувилбар нэр хэмээн үзэж тухайлан оруулаагүй болохоо тэмдэглэе.

---

[527] М.Шинэхүү, гар бичмэл, -Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

[528] Х.Пэрлээ, Карта рунических письмен на территории МНР, -Studia Museologica,Tom.I, fasc.1-8, Улаанбаатар, 1968, 11 дүгээр тал; Академич Х.Пэрлээ, Карта рунических письмен на территории МНР,- Эрдэм шинжилгээний өгүүллүүд (эмхэтгэл) II, Улаанбаатар, 2001, 20-27 дугаар тал.

[529] М.Шинэхүү, гар бичмэл- Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

[530] O.F.Sertkaya, Göktürk yazıtları, -ORKUN, Mart, 1996, 1.say, s.24-25.

[531] O.F.Sertkaya, Göktürk yazıtları, -ORKUN, Mart, 1996, 1.say, s.24-25.

Далан уулын бичээс

ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн санд Г.Мэнэс нарын 1982 оны археологийн судалгааны ажлын тайландаа руни бичээс олсон тухай мэдээлсэн байна[532]. Тайланд "Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг дахь Далан уулын өмнө биеийн нэгэн салбар жалганаас ганц мөр түрэг бичээсийг оллоо. Уг бичээсийн урт нь 65 см, үсэг зурлагын өндөр нь 6,5 см, өргөн нь 0,9 см. Хадан толгойн дээд хэсэгт байгаа наран тал руу харсан хаданд сийлсэн байна" хэмээжээ. Бичээсийг түрэг судлаач С.Харжаубай

[ ] 𐰴𐰃𐰏𐰇𐰚𐰃𐰴𐰃𐰏𐰇𐰚𐰃

qipcaq čino idi qutluγ bol[zun]

Кипчакийн чоно онгон нь өлзий буянтай болтугай гэж уншсан урьдчилсан судалгааг бичээсийн гар хуулбартай хамт хавсаргасан байна[533]. Археологич Г.Мэнэстэй уулзаж эл бичээсийн тухай асуухад нэгэн бэсрэг бага хаданд руни бичээс байсныг лавтай үзэж хуулснаа хэлсэн билээ. Гэвч Далан уул хэмээх хэдэн мянган гүвээ жалга, аараг адаргаас бүтэх энэ уулын хаана байхыг олж үзнэ гэдэг нэн бэрх. Руни бичээсээс гадна монгол бичгийн дурсгал байдаг тухай мэдээ бас бий.

Цахирын түрэг бичээс

1981 онд Увс, Хөвсгөл аймагт ажилласан Чандманий соёлын дурсгал судлах ангийн тайланд "Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг, сумын төвөөс 10-15 км-т Тэсийн голын өргөн хөндийн хойд талаар хөшиглөн тогтсон цайвар өнгийн шаварлаг зөөлөн чулуутай хадан уул толгодыг нийтэд нь Цахир гэнэ. Зүүн, дунд, баруун, рашаантын гэж дөрвөн Цахир бий. Хамгийн баруун талд Цахирын рашааны зүүн талын хэсэг хадны урд зүг харж тогтсон нэгэн ханан хаданд олон тооны хүн амьтны дүрс, тамга тэмдэг сийлсний дунд хоёр хэсэг газар 3 мөр руни бичиг хонхойлгон цохижээ. Нэгдэх мөр нь 15, хоёрдох нь 3, гуравдах нь 9 үсэг зурлагаас бүрдэж байна"[534] гэж тэмдэглэсэн байна.

Доктор Д.Цэвээндорж шинжлэх ухааны эргэлтэд оруулах үүднээс 1984 онд уг бичээсийн тухай тэмдэглэл нийтлүүлсэн[535] бөгөөд хожим "БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс" номд[536] Цахирын бичээсийн тухай дахин мэдээлсэн ажээ. Бид 1997 оны зун Тэсийн гэрэлт хөшөөний суурийг дахин үзэх далимд Цахирын бичээсийг доктор А.Очирын хамт өдрийн хугас эрсэн боловч "олоогүй" билээ.

Бигэрийн бичигт хадны бичээс

Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутагт руни бичээсийг судлаачид "Бигэрийн бичээс" хэмээн нэрлэж заншсан ажээ. Харин эл бичээсээс гадна 3 мөр руни бичээс Бигэр сумаас холгүй байх Бичигт хаднаа байсныг эх бичиг судлалын ангийн оюутан Н.Батзаяа хуулж ирсэн билээ. Бид нүдээр үзэж судалсны хойно бичээсийн талаар нийтлүүлэх болно.

---

[532] Г.Мэнэс, 1982 оны Археологийн шинжилгээний тайлан, - ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан, 1982, 25 дугаар тал.

[533] Г.Мэнэс, 1982 оны Археологийн шинжилгээний тайлан, - ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан, 1982, 25 дугаар тал.

[534] Д.Цэвээндорж, 1981 онд Увс, Хөвсгөл аймагт ажилласан Чандманий соёлын дурсгал судлах ангийн тайлан, -ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1982.

[535] Д.Цэвээндорж, Новые памятники Орхоно-Енисейской письменности из Цахира и Тумур цорго, -Studia Historica, Tom.XVII, fasc.1-13, Улаанбаатар, 1984, 124-126 дугаар тал.

[536] Л.Болд, Цахирын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 138 дугаар тал.

Дэлүүн сумын товийн бичээс

1990 оны эхээр ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн археологийн карт зохиох ажлын хүрээнд тус аймгийн нутгаас руни бичгийн нилээд хэдэн дурсгал олж илрүүлсэн билээ. Тэдгээр дурсгалуудын нэг Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын төвд, нэгэн жолооч айлын хашаанд нэг мөр бичээстэй хөшөө байгааг археологич Д.Баяр, Д.Эрдэнэбаатар нар олж тэмдэглэсэн байна[537].

Саарал өнгийн барсгар гадаргатай боржин чулуунд нэг мөр цохимол бичээс байсан нь олон жилийн нар салхи, цас бороонд усанд идэгдэж ихэд өгөршсөн тул бичээсийг тайлж уншихад нэн бэрхтэй болжээ. Уг дурсгалыг даруй хамгаалалтад авч уншиж судлах зайлшгүй шаардлагатайг онцлон тэмдэглэе.

Хар цагаан успы бичээс

Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт байдаг бололтой[538]. Уг бичээсийн талаар Д.Цэвээндоржийн 1980 оны хээрийн судалгааны ажлын тайланд байдаг хэмээн тэмдэглэжээ. Гэвч дурдсан тайланд бичээсийн талаар мэдээ баримт, тодорхойлолт алга байна[539].

Тэвшийн түрэг бичээс II

Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг, Тэвш уулнаас олсон бололтой[540].

Одоогоор уул бичээсийн талаар өгүүлэх тодорхой баримт бидэнд үгүй байна. Өмнөх Тэвшийн бичээстэй андуурсан байж магадгүй.

---

[537] Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, 1989 онд Баян-Өлгий аймгийн нутагт явуулсан эртний судлалын хайгуулын ажлын тайлан, Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг; Д.Эрдэнэбаатар, 1990 онд Баян-Өлгий аймагт ажилласан хээрийн шинжилгээний тайлан, Археологийн хүрээлэнгийн сан, хөмрөг; Д.Эрдэнэбаатар, Монгол нутгаас олдсон эртний бичээсүүд, -Ил товчоо сонин, №9 (112), 3-р сар, 1994.

[538] Л.Болд, БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1986, №3, 65-87 дугаар тал.

[539] Д.Цэвээндорж, Монголын төмөр, хүрэл зэвсгийг судлах шинжилгээний ангийн тайлан, -Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1980.

[540] Л.Болд, БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар,1986, №3, 65-87 дугаар тал; П.А.Окладников, Петроглифы Центральной Азии. Ленинград, 1980, стр.52, табл.116.

1.6.3. Алга болсон дурсгалууд

Монгол нутагт аж төрж төр улсаа байгуулан мандаж мөхөж асан эртний олон аймаг, улс бичиг соёлын асар их өв дурсгал үлдээсэн нь лавтай ч тун цөөхөн хэсэг нь цагийн шалгуурыг давж өнөө үед уламжлагдан үлдсэн байна.

Гэрэлт хөшөөний мэлхий чулуун суурь нилээд хэд байгаа ч түүн дээр байсан бичигт хөшөө ор сураггүй болжээ.

Монгол нутгаас олдсон эртний бичгийн зарим дурсгал үл мэдэгдэх шалтгаанаар алга болсон тохиолдол хэд хэд бий. Бичгийн дурсгалууд хоёр зүйлийн шалтгаанаар алга болж байна.

Нэгдүгээрт, байгаль цаг уурын эрс тэс уур амьсгалд он удаан жил болсноор хөшөө чулуу өгөршин муудаж түүн дээр байсан бичээс холцрон унаж сүйдэх,

Хоёрдугаарт, санаатайгаар алга хийх, хулгайлан бусдад өгснөөр ор мөргүй алга болох

Цаашид энэ мэт шалтгаанаар эртний бичгийн дурсгалыг алга хийх, үрэгдүүлэхийг таслан зогсоох зайлшгүй шаардлагатай байна.

Монголын төдийгүй Төв Азийн, ер дэлхийн түүх, соёлын чухаг үнэт сурвалжид хэтэрхий хайнга хандсан, харамсмаар жишээг өгүүлэхээс аргагүй байна.

Нэгэнт алга болсон дурсгалуудыг эрэн сурвалжилж олох, байгаа дурсгалуудаа байгалийн гамшиг болон ухвар мөчид хүний аюулаас хамгаалах цаг нэгэнт болжээ.

Ор сураггүй болсон дурсгалуудын нэрсийг дурдвал;

-Зоосны бичээс
- Налайхаас олдсон шавар эдлэлийн хэлтэрхий дээрх бичээс
- Номын баринтгийн тээг дээрх бичээс

Эрэн сурвалжилбал олдож болзошгүй дурсгалууд

-Байбалыкийн бичээс
-Сүүжийн бичээс
- Нэгэн хэлтэрхий дээрх бичээс зэргийг дурдаж болно.

Зоосны бичээс

Археологич Н.Сэр-Оджав гуай 1961 онд Дорнод аймагт хийсэн археологийн хайгуул, шинжилгээний ажлын явцад, нэг зоос санамсаргүй олсон нь хурц үзүүртэй зүйлээр зурчиж бичсэн нэг мөр руни бас нангиад бичигтэй байжээ. Тэрбээр уг зоосыг "Элэгдэж хар болсон зоосны өрөөсөн нүүрэнд хятад бичээстэй бөгөөд нөгөөд нь түрэг бичээстэй, бичээсний дээгүүр татсан хэд хэдэн зураас байна. Хан улсын "У-шу" зоосон..." хэмээн тодорхойлсон байдаг[541]. Эртний бичигт зоосны диаметр 25 мм, зузаан нь 1мм бөгөөд доторх дөрвөлжин 10х10 мм, руни бичгийн 21 үсэг зурлагыг хурц үзүүртэй зүйлээр бичсэн гэх ба үсгийн өндөр 4-5 мм байжээ.

Зоосны руни бичээсийг түрэг судлаач, нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный анх уншиж судалсан байна. Тэрээр бичээсийг "Qum^{a}š b^{a}qšy qutl^{u}γ bolzun" гэж уншаад "Да будет благословен Кумаш-Бакши!" [542] хэмээн орчуулжээ. С.Г.Кляшторный "Qumaš~Qumač" нэр Кумаш-бай (уйгурын хуульзүйн бичиг), Кумач атабек Санджара (огуз-салчукын захирагч,1096он), Ала ад-дин Кумач (Балхын төр баригч, 1153 он), Кумаш-хан (Ак-Орда, 1521он) гэх мэтээр түүхэн хүний нэрээр тохиолдохоос гадна "qumaš~qumač –шелковая

[541] Н.Сэр-Оджав, Монголын эртний түүх (Түүхэн найруулал), Улаанбаатар, 1977, 41-42 дугаар тал.

[542] С.Г.Кляшторный, Монета с рунической надписью из Монголии, -Тюркологический сборник 1972, Москва, 1973, стр.335-338.

ткань, одежда; красная хлопчатобумажная ткань; товар" гэсэн утгатайг ч тэмдэглэсэн байна. Мөн удаах үг болох "baqšy- буддийский вероучитель, наставник- буддын (бурханы) сургаал айлдагч, багш " гэсэн утгатай бөгөөд уйгур нарын X зууны үеийн бурхан шашны холбогдолт ном сударт, бас согд хэлний "p'γqšynt- советник, наставник- зөвлөгч, зөвлөх, багш" гэх үг VIII-IX зууны үеийн манихей бичигт сурвалжид тус тус тохиолдож байгааг дурджээ. Руни бичгийн сурвалжид "baqšy" хэмээх үг анх удаа тохиолдож байгааг онцлон тэмдэглэсэн байна.

Зоосны бичээсийг тайлж уншсан дээрх судалгаа хэвлэгдсэнээс даруй таван жил өнгөрсний хойно С.Харжаубай руни бичээсийг дахин уншиж монгол хэлнээ орчуулан нийтлүүлжээ. С.Г.Кляшторный, С.Харжаубай нарын судалгаа, орчуулга "тэнгэр газар" мэт зөрүүтэй юм. Учир иймд, харьцуулан үзэхэд дөхмийг санаж С.Харжаубайн өгүүллийг ямар нэгэн засвар хийлгүй, бүрэн эхээр нь сийрүүлье. Хасаж засварласан зүйлгүй, угаас маш товчхон болохыг давтан дурдах нь зүйтэй байх.


Эртний гурван бичээс

<< Эртний түрэг бичээсийн түүхэн эрин үед холбогдох янз бүрийн хэд хэдэн дурсгал ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн археолог-этнографийн лабораторид хадгалагдаж байна. Тэдний дундаас Хан улсын зоосон дахь түрэг бичээс, Тоньюкукийн тахилгын сумийн шаваасны бичээс удаа дараа нийтлэгдсэн боловч, тайлан уншигдаагүй учир өдий хүртэл нууцаа хадгалсаар байгаа юм. Бид эл хоёр бичээсийн хамт Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулнаас олдсон түрэг бичээсийг дахин нягталж тайлан уншихыг оролдов.

I. Хүннүгийн үеийн зоосны бичээс

"Доктор Н.Сэр-Оджав 1961 онд Дорнод аймагт археологийн хайгуул хийж явах үед уг зоосыг олсон байна. Зоосны нэг тал нь эртний түрэг бичээстэй бөгөөд нөгөө тал нь хятад бичээстэй юм. Сэр-Оджав эл зоосыг Хан улсын үеийн "У-шу" зоос болохыг тогтоосон юм. Зоосон дээр дундах дөрвөлжин нүхийг тойруулан 17 үсэг хурц үзүүртэй зүйлээр зурчин бичсэн байгаа учир уншихад нилээд бэрхшээл тулгарч байсан юм.

Уг бичээсийг сийрүүлбээс:



Галиглан буулгаваас:

altun edis edigin altid. taqiy olur

Үгчлэн орчуулбаас:

Алтан эрдэнэс сайн нь, алтан ширээнд /хааны/ байна

Утгачлан буулгаваас:

Үнэт алтан эрдэнэс, хааны алтан ширээнд /санд/ байна.

Эл бичээсний хэлний зүйн зарим онцлогийг ажихад: Орчин цагийн түрэг хэлнүүд хийгээд монгол хэлний олон тооны дагаварууд "-S, -D, "хүнү нарын үед мөн нэгэн адил олон тооны дагаварын утгыг илтгэж байв. Харин хүннүгийн үеийн IN хэмээх 3-р биеийн хамаатуулахын дагавар орчин цагийн ихэнх түрэг хэлэнд –IN хэлбэрээр хадгалагдан үлдсэн ба монгол хэлэнд -INÜ, -ÏNÜ хэлбэртэй болсон бололтой байна[543] *>>* хэмээн өгүүллийн зоосны бичээсийг тайлж уншсан хэсэг төгсчээ.

С.Харжаубай энэ зоосыг хүннүгийн үеийнх бөгөөд руни бичгээр түрэг хэлээр бичсэн, тодруулбал хүннү нар руни бичигтэй, түрэг хэлтэн байсан гэж үзсэн нь илэрхий байна. С.Г.Кляшторныйн нийтлүүлсэн гэрэл зураг, гэрэл зургаас дам буулгасан хуулбартай С.Харжаубайн сийрүүлсэн гар хуулбар, үсэг тэмдэгт (Кляшторный 21 үсэг тэмдэгт, Харжаубай 17 үсэг тэмдэгт буй гэжээ) зөрж байгаа нь нэн хачирхалтай байна.

Л.Болд бүтээлдээ С.Г.Кляшторныйн галиг орчуулгыг дурдаад *"Үүний дараагаар уг бичээсийг уншихад н.Харжаубай өөрийн хөдөлмөрийг зориулсан байна. Судлаач харин өөрийн ажилдаа уг бичээсийн талаар өмнө гарсан дээрх судалгааны ажлыг ашиглаагүй нь хачирхалтай....Уг бичээсийг уншсан эхүүд ийнхүү хол зөрүүтэй байгаа нь уг түрэг бичээсийг дахин нягтлан үзэх, гэхдээ зөвхөн орчуулга, тайлбарыг биш, жинхэнэ эхийг нь нягтлан үзэхийг шаардаж байна. Ийм судалгааг дахин хийсний дүнд эдгээр орчуулга, дүгнэлтүүдийн аль нэгийг зөвтгөх буюу эсвэл үнэнд аль болохоор илүү ойртсон гурав дахь*

[543] С.Харжаубай, Эртний гурван бичээс, -Studia Archaeologica, Tom.VII, fasc.10-18, Улаанбаатар, 1979, 32 дугаар тал.

дүгнэлтийг хийх хэрэгтэй юм"[544] гэж зоосны бичээсийг судалсан судалгааны талаар өөрийнхөө саналыг бичсэн байна. С.Г.Кляшторный гуайн судалгааг тэр бүр олж уншигч нь цөөн, тэгээд ч түүхийн зарим ном, сурах бичигт С.Харжаубайн уншлага орчуулгыг оруулснаар оюутан сурагч, түүх сонирхогч нар уг зоосны бичээсийн утга агуулгыг түүний мадагтай уншлага орчуулгаар буруу ташаа ойлгож байгаа нь туйлын харамсалтай. Далимд тэмдэглэхэд, хойшид ч чамбай сайн судлагдсан, шинжлэх ухааны баттай мэдээ баримтыг нийтийн боловсролд зориулсан ном, сурах бичигт оруулахыг анхаарууштай юм. Мэдээж хэрэг, эрдэмтдийн судалгааны асар их зөрөөг шинжлэх ухааны үүднээс нягтлан судалж зөв бурууг нутлан тайлбарлах ганц зөв арга зам бол уг эх дурсгалыг "өөрийн гараар барьж нүдээр үзэж" судлах явдал юм. Гэвч ховор чухаг тэр ор сураггүй алга болжээ. Руни бичигт зоос байсныг мэдэх хүн олон, алга болсонд халаглан харамсагч олон ч байхгүй болгосон этгээдийг олж шүүн шийтгэсэн нь энэ хэр огт үгүй юм.

Номын баринтгийн тээг дээрх бичээс

Улсын нийтийн номын санд хадгалагдаж байсан "Гучин хоёр модон хүний үлгэр" гэх номын баринтгийн оосорт буй чулуун тээг дээрх хоёр мөр бичээсийг 1956 онд хожмын академич А.Лувсандэндэв гуай тайлж уншсан нь монгол хүн анх удаа руни бичгийг судалсан судалгаа, монгол эрдэмтдийн руни бичгийн судлалын эхлэл байлаа. Тэрбээр бичээсийг 1.Чиниз хаан, 2. баатар хаан байсан гэж уншаад "... уул өгүүлбэрийг хэлзүйн талаар ажиглавал өгүүлэхүүнийг нь илтгэсэн үйлт нэр нь өнгөрсөн цагт (баатар хаан) байсан гэж байна. Үүнээс үзэхэд энэ бичээсийг Чингис хааныг үхсэний дараа бичжээ. Энэ нь эртний түрэг бичиг Чингисээс хойш үед ч хэрэглэгдэж байсныг гэрчилж байна" хэмээн дүгнэсэн[545] байдаг.

Тэрбээр 1960 онд герман хэлээр нэгэн өгүүлэл нийтлүүлж[546] түрэг судлаачдын сонорт дахин хүргэж мэдээлсэн ажээ.

Б.Ринчен академич "БНМАУ-ын Нийтийн номын санд байгаа нэг судрын баринтгийн оосрын чулуун тээгний түрэг бичээс" нэртэйгээр хэвлүүлсэн байна[547].

Б.Ринчен академич мөн "La Mention du Nom de Činggis Qagan en écriture des turcs d'Orkhon (Орхоны түрэгүүдийн бичээсэнд Чингис хааны нэрийг дурдсан нь)"[548] хэмээх илтгэл хэлэлцүүлсэн байдаг.

1959 онд Г.И.Константин " A late Kök-Türkish runic inscription on a semi-precious stone, found in Mongolia (Монгол нутгаас олдсон, жирийн нэгэн чулуун дээрх хожуу үед холбогдох Хөхтүрэгийн руни бичээс)[549], 1960 онд С.Г.Кляшторный "К вопросу о подлинности древнетюркской надписи с именем Чингис хана"[550], 1971 онд Г.Айдаров " Шингис Ханның атына баяланси ескерткиш туралы" (Чингис хааны нэртэй холбогдох нэгэн дурсгалын тухай)[551] зэрэг өгүүлэл нийтлүүлж XIII зууны үед руни бичиг хэрэглэгдэж байсан эсэх, цаашлаад уг бичээс үнэхээр жинхэнэ эсэх асуудал сөхөгдсөн байна.

---

[544] Л.Болд, Зоосон дээрх түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 31-33 дугаар тал.

[545] А.Лувсандэндэв, Шинээр олдсон тюрк бичээсийн тухай, Улаанбаатар, 1956, нийт 7 хуудас болой.

[546] A.Lubsangdendüp, Über eine in der Mongolei neu entdeckte türkische Runeninschrift aus dem 13.Jh, - Ural-altaische Jahrbücher, Wiesbaden, 1960, pp.122-123.

[547] Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc. 1, Улаанбаатар (Oulanbator) 1968, pp.69.

[548] B.Rintchen, La Mention du Nom de Cinggis Qagan en écriture des turcs d'Orkhon, -XXIV International Orientalisten –Kongres Arbeitsplan und Mitgliederverzeichniss, München, 1957, pp.42.

[549] G.I. Constantin, A late Kök- Türkish runic inscription on a semi-precious stone, found in Mongolia, - Archiv Orientalni, Prag, 1959, pp.427-437.

[550] С.Г.Кляшторный, К вопросу о подлинности древнетюркской надписи с именем Чингис хана, -Проблемы Востоковедения, Москва, 1960, № 1, стр.173-175.

[551] Г.Айдаров, Шингис Ханның атына баяланси ескерткиш туралы, -Қазақ Епиграфикасы, Алматы, 1971, стр.156-160.

Тиймээс ч бичээсийг дуурайлган хийсэн хуурмаг зүйл, хэн нэгнийг чадах гэж бичиж үйлдсэн хуурамч бичээс байсан тухай яриа дэгдэж тархсан гэх ба одоо ч сонирхон асуугчид байсаар.

С.Г.Кляшторный 2003 хэвлүүлсэн бүтээлдээ Көлтигинд зориулан (732 он) босгосон гэрэлт хөшөөний их бичээсийн гуравдугаар мөрнөө " *bil(g)e qayan ärmis alp qayan ärmis (мудрый каган был, мужественный каган был)*" хэмээн гарах бөгөөд энэ нь Чингис хааны нэртэй холбогдох хуурамч бичээсийн эх загвар мөн хэмээн өмнөх саналаа давтан лавшруулжээ[552].

Үнэндээ, ердөө л "*bil(g)e qayan ärmis alp qayan ärmis*" гэхийг *"čiŋiz qayan [ärmis] alp qayan ärmis z"* хэмээн хувилгахад л хангалттай.

Хуурамч эсэхийг батлан нутлах цорын ганц баримт болох чулуун тээг, эх дурсгал ор мөргүй алга болжээ.



Чулуун тээг дээр бичиг байсан нь маргаангүй үнэн лавтайн адил бичээс хуурамч байсан эсэх бас үнэн, маргаангүй нууц болон үлдсэн байна.

Манай эрдэмтдийн хэвлүүлсэн ном зохиолд номын баринтгийн тээг дээрх түрэг бичээс хуурамч эсэх талаар, байгаа үгүйн тухайд огт юу ч дурдаагүй байдаг билээ[553].

Нэр үл мэдэгдэх нэгэн дурсгалын тухай

Турк улсын эрдэмтэн Ахмед Бижан Ержиласун (Ahmet Bican Ercilasun), Осман Фикри Серткаяа (Osman Fikri Sertkaya) нар 1990 онд Монгол оронд ирж цөөн хэдэн хоног ажилласан байна. А.Ержиласон "Монгол ба Нангиадад хийсэн аялал" хэмээх аян замын тэмдэглэл бичиж нийтлүүлсэн бөлгөө[554].

Осман Фикри Серткаяа Улаанбаатар хотод байх хугацаандаа Чойрын бичээс болон нэр нь тодорхойгүй хөшөөний хэлтэрхий дээрх бичээсийн гэрэл зургийг үзэж судлан улмаар нутаг буцсаны хойно энэ хоёр бичээсийн талаар эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлжээ. Түүний өгүүллийн нэг "Moğolistan'dan bilinmeyen bir yazıtın parçası"[555] хэмээх нэртэй бөгөөд хаанаас олдсон нь тодорхойгүй, нэг хөшөөний хэлтэрхий дээрх бичээсийг уншиж судалсан тухайгаа бичсэн байна. Өгүүлэл маш товч тул орчуулан буулгавал " *1990 онд Улаанбаатарт /Монгол улсад/ Чойрын бичээсийг судалж байх үед хамтрагч /багийн гишүүн/ Казак түрэгч Сартхожагийн Харжаубай нэгэн гэрэл зураг, гэрэл зургаас гараар хуулсан хуулбар, өөрийн тэмдэглэл зэргээ надад авчирч өгөв. "Энэ аль бичээсийн хэлтэрхий вэ?" гэж асуухад энэ бичигт хэлтэрхий /хугархай/-г 1920-иод онд олж гэрэл зургийг нь авсан, одоо алга болсныг бас анх олдсон, байсан газрыг ч мэдэхгүйгээ өгүүлээд дурсгалыг судлахыг хүсэв. Ийм учраас энэ бичээсийн хэдэн онд, хаанаас олдсоныг мэдэхгүйн адил, нэгэнт үгүй болсон тул хэдий хэмжээний болохыг ч тодорхойлох боломжгүй юм. Бас чулууны бусад талуудад бичээс байгаа эсэхийг ч мэдэх боломжгүй. Харжаубайн өгсөн гэрэл зураг, гэрэл зургаас гараар хуулсан хуулбар энэ болой. / гэрэл зураг тавьжээ/. Гар хуулбар, тэмдэглэл нь" Надпись на известной местности" (М.XXI) гэсэн нэртэй гээд*

1. 
2. 
3. 

1.: NČ': $WT^2N^2M^2S^2N^2S^2$ (?) K^2

---

[552] С.Г.Кляшторный, К вопросу о подлинности древнетюркской надписи с именем Чингис хана, -История Центральной Азии и памятники рунического письма, Санктпетербург, 2003, стр.278-281.

[553] Л.Болд, Номын баринтагийн тээг дээрх түрэг бичээс, -БНМАУ-ын хадны бичээс, Улаанбаатар, 1990, 72 дугаар тал.

[554] Ahmet B.Ercilasun, Moğolistan ve Çin günlüğü, -Türk Kültürünü Araştırma Enstitüsü, Yayınları :120, Seri:I, Sayı: A.22, Ankara, 1991.

[555] O.F. Sertkaya, Moğolistan'dan bilinmeyen bir yazıtın parçası, s.

1. : (a)nça: öt(ü)nm(i)ş(i)n k^2
2. : B^{2}YZ: ZG^1 wK^{2}S^{2}G^2 wKN^2? T^{2}G^2 R^2…
2. :biz: (a)z(ı)g: (ü)k(ü)ş(ü)g ök(ü)n ? t(e)g (e)r..
3. :K^{2}Ş^2: YŞ^{2}G^2: B^{2}R^{2}T^{2}NK: T^{2}Y^{2}N^2: Y^1
3. : iş(i)g: b(i)rt(i)ng: t(i)y(i)n: y^1

1. Tercüme: öylece: arzettiğini…
2. Tercüme: Biz azı (ve) çoğu: ükünür gibi i[…
3. Tercüme: ??: işig verdin tiyerek…" хэмээн руни бичгийн эхийг сийрүүлж үсэг, үгийн галиг хийж орчин цагийн турк хэлнээ хөрвүүлсэн байна.

Орчин цагийн турк хэлнээ хөрвүүлснийг үгчлэн орчуулбал:

1. Тийнхүү: хүссэнийг …
2. Бид цөөхөн (ба) олуул: бөөн мэт […
3. ??: хүчээ өгсөн хэмээж …" энэ мэт болох ба хэсэг бусаг учир тоймтой зүйл хэлэх боломжгүй юм.

Ийм боловч нэгэн гэрэлт хөшөөний хэлтэрхий байсан нь гарцаагүй. Цаашид тухайн үед ажиллаж байсан өтгөс, буурлуудаас асууж лавлан эрэн сурвалжилбал хэдэн онд хаанаас олдсоныг тогтоож болох юм.

Лавтайяа, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн олдворын сан хөмрөг, Үндэсний түүхийн музейн сан хөмрөгийн аль алинд нь үгүй билээ.

Хад чулуу, гэрэлт хөшөөний бичээс нь
Хамгийн үнэн, бодитой түүхэн сурвалж мөн.

Төв Азийн өндөрлөгт аж төрж асан эртний олон улс, угсаатны түүх, соёлын эрдэнэсийн их сан нь Монгол нутагт буй. Эрдэнэсийн тэр их санд хүн төрөлхтний үсэг бичиг, түүх соёлын гэрч болох олон арван чулуун судар хадгалагдан үлджээ. Бид олон зүйл үсэг бичиг, хэлээр буй тэрхүү гайхамшигт сурвалжуудаас зөвхөн эртний түрэг, уйгур нарт холбогдох "руни бичгээрх" чулуун ном судрыг уншиж судалсныхаа багахан хэсгээс илтгэхийг хичээлээ.

МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА ДУРСГАЛУУД

(Эх бичгийн судалгаа)

1. АРХАНАНГИЙН БИЧЭЭС

2. БӨМБӨГӨРИЙН БИЧЭЭС

3. ГУРВАЛЖИН УУЛЫН БИЧЭЭС

4. ГУРВАНМАНДАЛЫН БИЧЭЭС

Дундмандалын бичээс

Адагмандалын бичээс

5. ДЭЛ УУЛЫН БИЧЭЭС

Нэгдүгээр бичээс

Хоёрдугаар бичээс

Гуравдугаар бичээс

Дөрөвдүгээр бичээс

6. ИХ БИЧИГТИЙН БИЧЭЭС

7. ИХ ХАНУЙ НУУРЫН БИЧЭЭС

8. НАЛАЙХЫН БИЧЭЭС (Шавар ваарын хэлтэрхий дээрх бичээс)

9. СЭВРЭЙН БИЧЭЭС

10. ТАХИЛЫН ШАВААСНЫ БИЧЭЭС

11. ТЭВШИЙН БИЧЭЭС

12. ХАНАНГИЙН БУУЦНЫ БИЧЭЭС

АРХАНАНГИЙН БИЧЭЭС

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын төвөөс урагш 40 орчим км-т Арханан гэх нэгэн багавтар уул буй. Тэрхүү уул нь ар өвөр, суга хажуугаараа олон хаваржаа, өвөлжөөтэй бөгөөд баруун хойт талд орших бууцыг Арханангийн бууц, өвөлжөө хэмээнэ.

Эл өвөлжөөний хаданд байх бичээсийг судлаачид "Арханангийн түрэг бичээс" хэмээн нэрлэж тэмдэглэсээр иржээ. "Арханан" гэх нэр уг газрын байрлалыг тодотгон тодорхойлж, уулын ард, ханан хадтай газар болохыг илэрхийлнэ.

Ханан хад нь ойролцоогоор 16 м орчим үргэлжлэх бөгөөд 50-80 см өндөр, арааралаа тэгш, нүүрэн талдаа эгц хана үүсгэсэн өвөрмөц тогтоцтой, цайвардуу бор шаргал өнгөтэй аж. Дурсгалын байршлын цэг: 1292 m. 48U 0408787, UTM 5323955

Судалгааны тойм

Арханангийн хэмээх нэрээр түрэг судлаачдын танил болсон эл бичээсийг анх Польшийн нэрт эрдэмтэн Е.Трыярски 1964 онд тайлан уншсан байна[1].

О.Намнандорж гуай 1966 онд уг бичээсийг очиж үзээд гар хуулбар хийж, гэрэл зураг авчээ[2].

Б.Ринчен академич бүтээлдээ[3] Арханангийн бичээсийн гэрэл зургийг хэвлүүлэн судалгааны эргэлтэд оруулж улмаар бичээсийг дахин унших, нягтлан судлах ажлыг эхлүүлсэн бөлгөө.

Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн "Бичээс судлал"-ын хэсэг 1977 онд уг дурсгалыг үзэж судалсан байна*. Уг бичээсийг судалсан судалгааны ажлын үр дүнгээ С.Харжаубай 1980 онд, С.Г.Кляшторный 1990 онд тус тус хэвлэн нийтлүүлжээ.

С.Харжаубайн судалгаа

С.Харжаубай уг бичээсийг гурван мөр, нийтдээ 140 үсэг тэмдгээс бүрдэх бөгөөд I мөр 83 үсэг тэмдэгттэй, урт нь 107 см, II мөрийн урт нь 36 см, III мөрийн урт нь 30 см, харин үсгийн өндөр дунджаар 1,5 см гэж тодорхойлсон байна[4].

---

[1] E.Tryjarski, L'inscription runiforme d'Arkhanen, en Mongolie, -Ural-altaische Jahrbücher36, fasc.3-4 (1964), 1965, pp.423-428

[2] О.Намнандорж, Арван өдрийн шинжилгээний аялал, Шинжлэх ухаан амьдрал, №5, Улаанбаатар, 1966, 38-41 дүгээр тал.

[3] Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum,Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.37.

* Хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд А.Очир, С.Харжаубай, С.Г.Кляшторный нар ажилласан байна.

[4] С.Каржаубай, Надпись на скале Арханана, -Хэл зохиол судлал, XIV боть, 1-25 дэвтэр, Улаанбаатар, 1980, 90-93 дугаар тал.

С.Харжаубай бичээсийг,

1. Teŋir ekin qunčuj jüzi (1) batur ič…örkim… …qa.... jïlqa bütkedük…(2) aj jana Kül-Tarqan küdegü (3) aγïz erti. But anta qaja etin bek bolzun.
2. …bekü bitik bitidim, qaja teŋir ekin qutluγ bolun!
3…qulačqïŋ qutluγ boluŋ! Qïrïn bedizdim гэж үгчлэн галиглаад, орос хэлнээ

1.Небом рожденного принца (свящeнного) лица скрылось (улетело). Высочеству.....к.....в году мы (обряды погребения) совершили.

...Лунного первого месяца зятю Кюль-тархана жертвоприношение принесли. Бирюзой украшали, навек погребли насыпью.

2. ...тщательно надпись написал я. Небом рожденный скале. Пусть будеть благодатным!

3. ...твоя сажень ((тело)) пусть будет благодатным!. Вырезаль, начертил я гэж орчуулжээ.

С.Харжаубайн галиг, уншлага нь С.Г.Кляшторный, Е.Трыярский нарын судалгаанаас нилээдгүй зөрүүтэй байна.

С.Г.Кляшторный, Е.Трыярский нарын судалгаа

Дээрх эрдэмтэд бичээсийг

Line 1. t^{ä}ŋr^{i}k^{ä}n qunč^{u}y: yig^{ä}n butur [botor? botur? butor?] irk^{i}n y^{a}s^{a}l [y^{a}s^{au}l? y^{a}š^{i}l?] q^{a}zγ^{a}n t^{u}rdi: q^{a}ŋi kül [köl?] t^{a}rq^{a}n: k^{ä}ld^{a}k ök^{ü}z [ög^{ü}z?] ^{e}rti b^{u} nča […] ikin q^{a}ya t^{ä}gdik bolz^{u}n

Line 2. b^{ä}n bit^{i}g: bit^{i}d^{i}m q^{a}ya: t^{ä}ŋr^{i}k^{ä}n qutl^{u}γ bolz^{u}n […] lr

Line 3. ir[k]^{a} in^{a} y s l [y^{a}s^{au}l? y^{a}š^{i}l]: […] qutl^{u}γ bolz^{u}n qirurt^{i}m гэж галиглан амилуулж, англи хэлнээ,

Line 1: Her Sacred Majesty Princess Yigän, Butur (Botor, Botur, Butor) Irkin, Yasal Qazγan pitched here (their) camp. Her (?) father (is) Kül (Köl) Tarqan. We arrived. There was a river. We penetrated (so far) as (these) two rocks. Let it be (known).

Line 2: I wrote the inscription (in) the rock. May Her Sacred Majesty enjoy divine favour (…)

Line 3: May Irkin (?) Yasal (?…) enjoy divine favour[5] хэмээн орчуулсан бөлгөө.

Эх бичээс, бичээсийн хэв дардастай харгуулан нягталж үзэхэд дээрх эрдэмтдийн судалгаа нилээд мадагтай болжээ. Эрдэмтэд алдаа мадагтай уншсан нь уг бичээсийг олон удаа очиж үзэх боломж хомс бага байсантай холбоотой буй за.

Олон зууны нар салхи, цас борооны усанд, ялангуяа нэгдүгээр мөрийн бичээс ихэд идэгдэн гэмтэж уншихад нэн бэрхтэй болжээ.

Тиймээс бичээсийн газар 1998, 2001, 2003, 2004 онуудад очиж хэв дардас авч нарийвчлан судалсан билээ.

---


[5]G.Kljaštornyj, Tryjarski, An Improved Edition of the Arkhanen Inscription, Rocznik Orientalistyczny, Tom.XLVII, Warszawa, 1990, pp. 65-68.


Удаа дараагийн судалгааны дүн, бидэнд байгаа хэв дардсаас үзэхэд уг гурван мөр бичээс нийтдээ 132 үсэг тэмдэгтээс бүрдэж байна.

Бичээсийн I мөр 105 см урт, 83 үсэгтэй, II мөр 36 см урт, 26 үсэгтэй, III мөр 25 см урт, 23 үсэгтэй ажээ.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:









Үсгийн галиг;

1. tŋrkn¦ QWnčY¦ yign¦BWTWR¦ irkn¦ BLQ ri BWLi¦ TWRDi¦ Yŋi kül TRQN¦ kü dgü klrti¦ BWNa ..:süg: ..iki:.QYa¦ tg bk BWLzWN¦

2. bitč bitdm¦ QYa¦ tŋrkn¦QWTLGBWLŋ¦

3. QWL č wQa¦QWTLG¦BWLŋ¦ QYa¦RWRTm

Үгийн галиг;

1. täŋrikän qunčuy yigän butur irkin balïq eri bolï turdï. yaŋi kül tarqan kü edgü kelirti. buna ..süg ..iki.. qaya teg bek bolzun.

2. bitič bitdim qaya täŋrikän qutluγ boluŋ.

3. qul ačuqa (ačoqa) qutluγ boluŋ qaya ur[t]urtum.

Орчуулга;

1. Тэнгэрхэн гүнжийн зээ Бутур иркин балгасын цэрэг болон суув. Шинэ Күл /Көл/ Тархан сайн чимээ ирүүлэв. Энд...цэргийг..хоёр.. хад мэт бэх болтугай.

2. Бичээч бичив, би. Хад тэнгэрхэн өлзийтэй болог.

3. Боол Ачука (Ачока) өлзийтэй болог. Хаданд цохиулав, би.

Бичээсийн уншлагын зөрүүг хүснэгтээр харуулбал:

С.Г.Кляшторный, Е.Трярский	С.Харжаубай	Бидний уншлага
I мөр		
täŋrikän qunčuy	teŋir ekin qunčuj	täŋrikän qunčuy
yigän butur	jüzi (1) batur	yigän butur
irkin yasal	ič….örkim…. qa… jïlqa	irkin balïq
qazγan turdi	Bütkedük……	eri bolï turdï
qaŋi kül tarqan	(2) aj jana Kül-Tarqan	yaŋi kül tarqan
Kaldak	küdegü	kü edgü
oküz (ögüz) erti	(3) aγïz erti	kelirti
bu nča	but anta	buna ..süg
[…] ikin qaya	qaja	..iki.. qaya
tägdik bolzun	etin bek bolzun	teg bek bolzun
II мөр		
bän bitig bitidim	……..bekü bitik bitidim	bitič bitdim
qaya täŋrikän	qaja teŋir ekin	qaya täŋrikän
qutluγ bolzun [..] lr	qutluγ bolun!	qutluγ boluŋ
III мөр		
ir[k]a ina y s l [..]	……..qulačqïŋ	qul ačoqa (ačuqa)
qutluγ bolzun	qutluγ boluŋ!	qutluγ boluŋ
Qirurtim	qïrïn bedizdim.	qaya urturtum

Тайлбар:

Тайлбар

𐰉𐰇𐰴𐰆 bitič- бичээч гэх үгийг 5 удаа 𐰆 /b/ үсэг зурчсаны эцэст бичсэн, 𐰴𐰃𐰇 хэмээн үгийг 𐰃/Y/ үсгийг орхиж бичээд дараа нь 𐰴𐰃𐰇 гэж нөхөж бичсэн зэргийг эс тооцвол бичгийг нэгэн хаднаа сийлсэн болох нь тодорхой байна.

"Тэнгэрхэн гүнж" хэмээн өргөмжлөгдсөн нэгний зээ Бутур иркин цол балгас (хот)-ын цэрэг болон суусан хийгээд (магадгүй) түүнээс Күл (Көл) Тархан цолд өргөмжлөгдсөн сайн мэдээ, чимээ ирүүлсэн тухай эхний буюу нэгдүгээр мөрнөө өгүүлжээ.

Удаах мөрүүдэд бичээч, түүний (Ачукагийн) даалгаснаар Хад тэнгэрхэн, боол (ноён) Ачука (Ачока) өлзийтэй байх болтугай хэмээн "Тэнгэр, газартаа залбиран даатгасан сэтгэлийн үг"-ийг нь хаднаа сийлснээ дурджээ.

Арханангийн бичээст "Согд гаралтай түрэгжсэн Күл-тархан ноёныг нас барахад эртний нүүдэлчдийн заншил ёсоор хойллого үйлдэн оршуулсан тухай

өгүүлж байна"[6] хэмээн үзсэн нь эх бичиг болон түүхэн баримтаар огт нутлагдахгүй, ямар ч үндэслэлгүй болохыг далимд тэмдэглэе.

 täŋrikän. täŋri + kän Уйгур улсын үеэс энэ нь нилээд өргөн дэлгэр хэрэглэгдэх болсон цол юм. Уйгурын Хар балгасын гэрэлт хөшөөний бичээст тохиолдож байгаагаас үзвэл хаан, хаан язгуурт хүнд "тэнгэрээс болгоогдсон, тэнгэрээс заяат болох"-ыг тодруулан "тэнгэрхэн" хэмээх өргөмж цол олгодог байсан бололтой.

 qunčuy 公主gong zhu гэх нангиад үг. Түрэг, монгол хэлэнд идэвхтэй хэрэглэгдэж байсан хаан, ноён язгууртны охиныг нэрлэх нэр юм.

 yigän – зээ. Уг үг Көличурын гэрэлт хөшөөнөө yigän čur гэж бусад дурсгалуудад yigän külüg saŋün, yigän qara, yigän qïŋrul saŋün гэм мэтээр цол хэргэмийн утгаар бас тохиолддог болохыг толь бичигт[7] тэмдэглэжээ.

 butur – хүний нэр

 irkin – түрэг, уйгурын үед хэрэглэгдэж байсан дээд албан тушаалтанд олгодог цол. Эрхэм, эрхэм хүндэт гэж хэлэлцэж буй нь угтаа "irkin ~erkin" цол, хэргэмээс үүсэлтэй байж болох юм. Хожим цол, хэргэм зэргийн утгаа алдаж төрийн болоод албаны хүнийг дуудах нэр болж хувирсан бололтой.

"Эрхэм" гэх үгийг голдуу төрийн хар хүн, албан тушаалтан нарт холбогдуулан хэлж ярьж, бичихээс бус "лам, хувраг"-ийг дууддаггүй нь цаанаа "irkin ~erkin~erkim" цолын язгуур утга санаа агуулагдаж буйтай холбоотой байж мэднэ.

 balïq хот суурин, балгад, балгас гэх үг. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудад олонтоо тохиолддог. Эдүгээ "хот" гэх утгаа алдаж эртний хотын туйрыг нэрлэх нэр болжээ.

 turdï монгол нутгаас олдсон руни болоод уйгур бичгийн дурсгалд ер тохиолддоггүй үг. Орчин цагийн турк болоод түрэг төрөл хэлүүдэд "dur~tur" хэлбэрээр "зогс-, бай-, орш-" гэх утгаар идэвхтэй хэрэглэгдэж буй.

Академич Ш.Лувсанвандан Нагаржунайн найман үгүйсгэлийн утгыг задлан тайлбарлахдаа "Хуучин монгол сударт арвин тохиолддог türidkü-ügei, törükü-ügei, möngke-ügei, tasural-ügei, irekü-ügei, odqu-ügei, öber-e činartu busu, nigen činartu busu гэсэн Нагаржунын найман үгүйсгэлийг сайн ойлгохын тулд ойролцоо утгатай янз бүрийн үгээр сольж хэлбэл 1. türidkü-ügei- törükü-ügei гэсэн нь эвдрэхгүй-бүтэхгүй, үхэхгүй-төрөхгүй, бий болохгүй-үгүй болохгүй, 2. möngke ügei-tasurqui ügei буюу үргэлжлэхгүй-тасрахгүй, үүсэхгүй-төгсөхгүй, 3. irekü-ügei - odqu-ügei гэсэн нь илрэхгүй-арилахгүй, орохгүй-гарахгүй, 4. öbere činartu busu-nigen činartu busu гэсэн салахгүй-нийлэхгүй, сарнихгүй-хурахгүй, хагацахгүй-учрахгүй гэсэн жишээтэй болно"[8] хэмээсэн байна. Дээрх жишээнээс үзвэл türidkü-ügei буюу türidkü нь turdï гэх үгтэй гарал язгуур нэг байж болох үндэстэй байна. Монгол хэлнээ агшин, хоромхоноо зогсосхийх гэсэн утгатай " tür-түр" гэх үг ч мөн холбоотой биз ээ.

---

[6] С.Каржаубай, Надпись на скале Арханана, Хэл зохиол судлал, XIVботь, 1-25 дэвтэр, 90-93 дугаар тал; Болд Л, Ар Ханангийн түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 17дугаар тал.

[7] Древнетюркский словарь, Ленинград, стр. 252.

[8] Ш.Лувсанвандан, Монгол хэлний авианзүйн онол практикийн асуудлууд. Дөтгөөр дэвтэр, Улаанбаатар, 2002, 192 дугаар тал.

sü -цэрэг. Монгол хэлнээ “сүр, сүр үзүүлэх, сүр хүч” гэх үгс буй бөгөөд энэ нь эртний түрэг хэлний “ sü er- цэрэг эр ” гэх хоёр үгнээс үүссэн бололтой. Түүнээс гадна олноор цугларсан, бөөгнөрснийг “сүрэг, сүрэглэх” гэдэг нь мөн л “sü” язгууртай холбогдоно.

bek (bök$^{(e)}$~bük$^{(e)}$) Түрэг, монгол хэлний нийт дундын үг бололтой орчин цагийн монгол хэлнээ “бэх, бат бөх” гэх үндсэн утгаараа буй.

bitič- Сяньбигийн үеийн албан тушаалын нэрийн дотор “pı-tö-tchen” гэх цол тэмдэглэгдэн үлджээ. Уг үгийн талаар Л.Лигети абугай “ pı-tö-tchen, эртний хятадын “b’ji-t k-t’sen bi-tikčın” “бичээс” гэж уншина. Үүнд түрэг хэлний тайлбар ямар ч хамаагүй. Түрэгийн хамгийн эртний хэлбэрүүд bitigüci, bitikäči бөгөөд bitikči гэдэг нь нилээд саяхан үүссэн болно гээд чинагш Юань, Мингийн үеийн хятад галигт монголоор bicecі “бичээч” гэж тохиолдохоос гадна араб үсгээр бичигдсэн толиудад, сонгодог монгол бичгийн хэлний өмнөх үеийн монгол хэл халимаг, ордос, халх, буриад аялгууны жишээг дурдаад монголоор bičigeči, bitigeči нь biči “бич” biti –гээс, манжийн bitxesi, bitegeci-bitxe-bitege сяньбийн нэгэн аялгуунаас гарсан бололтой”[9] хэмээн тэмдэглэжээ. Тэгэхээр бич-iči~ bičig~ bičigeči) гэх үг язгуур үүслийн хувьд их эрт үед хамаарагдах лавтай. Өгүүлэн бүхүй бичээснээ 5 удаа /b/ үсэг зурчсаны дараа эл үгийг бичсэн байна.

Бичээст гарах үгийн толь

täŋrikän – tngriken, тэнгэрхэн

qunčuy- günjü, гүнж

yigän – jige, зээ

butur - butur, хүний нэр

irkin - erkin, цол

balïq - balγasun, хот балгас

er – er-e, эр цэрэг

bolï

bol - bolqu болох

b.- ï- болоод

turdï-

tur – saγuqu, bayiqu, суух байх

t. –dï, суув

yaŋi- šin-e, шинэ

kül kül, көл, күл (цол, хэргэм)

tarqan- darqan, цол

kü – suraγ, aldar čuu сураг, алдар цуу

edgü - sayin, сайн, сайтар

---

[9] Л.Лигети, Табгач хэл Сяньбийн нэгэн аялгуу болох нь, -Хэл зохиол судлал, Tom.VII, fasc.9, орчуулсан Л.Маналжав, Улаанбаатар, 1970, 236-237 (227-241) дугаар тал.

kelirti [kelürti]

kel - irekü, ирэх

k.- irti, ирүүлэв

buna

bu – ene, энэ

b.-na ende, энд

süg

sü - čerig, цэрэг

s.- g, цэргийг

iki - qoyar, хоёр

qaya – qada хад, чулуу

teg – metü, мэт шиг

bek – batu, beki, бат бэх

bolzun - boluγ, болог

bol– bol-, бол-

b.- zun, болог

bitič - bičigeči, бичээч

bitdim

bit – biči-, бич-

b.- dim- бичив би

qutluγ

qut – öljei, qutuγ өлзий (хутаг)

q.-luγ, өлзийтэй

qul - boγul, боол

ačoqa – ačuq-a хүний нэр

ur[t]urtum)

ur– čoqi, цохи-

u.- [t]urtum- цохиулав би

БӨМБӨГӨРИЙН БИЧЭЭС

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын төвөөс баруун өмнө зүгт, 11 орчим км-т Тайн нурууны төгсгөл, Шивээт хэмээх намхан уулын оройд бичээс, тамга бүхий гэрэлт хөшөөт дурсгал буйг нутгийн ард түмэн Шивээтийн эхний "Шивээ"* хэмээн нэрлэдэг байна. Эл шивээ анх хэрэмтэй байсан гэх ба хэрмийн чулууг сумын төвд зөөж хашаа, байшин барихад хэрэглэсэн ажээ. Нилээд эрт үед шивээг гол дунд нь малтаж нилээд гүнзгий хонхорхой үүсгэсэн байх бөгөөд бүр хожуу малтсан ул мөр ч ажиглагдаж байна. Уйгурын үед уул, толгойн орой зэрэг өндөрлөг газарт их хэмжээний чулуу овоолон шивээ байгуулдаг ёс байсан бололтой юм.

Жишээ нь, мөн үед холбогдох Тарнын голын хүн чулуут шивээ[10], Шивээт улааны тамгат хөшөө бүхий цогцолбор (хүн чулуу, хонь, арслантай)[11] зэрэг судалгааны эргэлтэд хэдүйнээ мэдэх болсон олон дурсгалыг дурдаж болно.

Түүнчлэн Архангай аймгийн Хашаат сумын нутаг хөгшин Орхоны хөвөө, Хөшөө Цайдамд буй түрэгийн Билгэ хаан, түүний дүү цэргийн нэрт жхнжин Көлтигин нарын гэрэлт хөшөөнөөс өмнө зүгт мөн томоохон шивээ байх бөгөөд ойролцоох хаднаа янгир зэрэг хэдэн тамга сийлсэн байдгыг бас тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Шивээт улааны цогцолбороос өөр тухайлан гэрэлт хөшөөнөө олон (24) тамга сийлсэн дурсгал одоогоор монгол нутгаас олдоогүй байна. Харин магнайдаа 4 мөр, баруун хажуудаа нэг мөр руни бичээстэй, нийт 34 тамганаас бүрэлдэх Бөмбөгөрийн бичиг, тамгат хөшөө олон тамгатай удаах дурсгалд зүй ёсоор тооцогдоно. Гэхдээ хөшөөнөө нэг тамгын олон хувилбар зонхилж байгааг дурдалтай. Хөшөөний магнайн бичээсийн доор голлож бусдаас илүү томоор цохисон тамга нь Карлук нартай холбогдох нь мэдээж бөгөөд бусад хувилбар тамгууд худ ураг болон тэдний бүрэлдэхүүнд багтагсадтай холбоотой буй за.

Бид тамга тэмдгийн судалгааг гол болгосонгүй, зөвхөн бичгийн дурсгалын судалгааг толилуулж байна.

Шивээн нуруу хэмээн нутгийнхан нэрлэдэг, тал хээрийн үргэлжилсэн намхан уулын эх, молцог толгойн орой (Газрын байршил: N 46° 07' 07,9", E 099° 31' 51,6" солбилцлын цэгт, далайн төвшнөөс дээш 1525м)-д байгуулсан "шивээ"-ний өмнө талд, овоолго чулуун дотор Бөмбөгөрийн гэж нэрлэгдэх бичиг, тамгат хөшөөг босгосон байна. Уг цайвар шаргал боржин чулуун хөшөөний магнайд 4 мөр бичээс байх бөгөөд хөшөөний оройн хэсэг холцрон унасан тул мэдэгдэж буй дөрвөн мөрөөс дээш тамга болоод бичиг байсан эсэх талаар таамаглан хэлэх боломжгүй юм. Нэгдүгээр мөрийн эхний гурван үсэг нь хагас дутуу, харин төгсгөлийн нэг үсэг тодорхой мэдэгдэж байна. Түүнчлэн 2,3,4-р мөрийн үсэг тэмдэгтүүд маш тодорхой ажээ. Хөшөөний баруун хажууд цохисон нэг мөр бичээсийн эхний хоёр үсгийн дараагийн гурав, дөрвөн үсэг холцорч унасан хэдий ч бусад үсэг тэмдэгтүүд маш тод юм. Уг хөшөө тахилга булшны овоолго чулуунд нөмөрлөгдөж, тал хэсэг нь

---

* Их чулуу овоолон үйлдсэн нэгэн зүйл тахилын онгон. Голдуу уулын оройд байдаг онцлогтой.

[10] Д.Баяр, Монголын төв нутаг дахь түрэгийн үеийн хүн чулуу, Улаанбаатар, 1997, 91 дугаар тал.

[11] Ц.Доржсүрэн, Шивээт Улаан гэдэг юу вэ?, -Шинжлэх Ухаан, Техник, Улаанбаатар, 1957, №1, 46-47 дугаар тал; С.Харжаубай, Шивээт Улааны цогцолбор дурсгалан, -Археологийн судлал, Tom. XIX, fasc. 2, Улаанбатар, 1979, 15-23 дугаар тал; С.Харжаубай, Шивээт Улааны тухай дахин өгүүлэх нь, -Түүхийн судлал, Tom.X, fasc. 7, Улаанбаатар, 1982, 103-120 дугаар тал.

далд дараастай байсан тул бичээсийн үсэг тэмдэгтүүд харьцангуй сайн хадгалагдан үлдсэн байна[12].

Хөшөөний магнайн бичээс

Эх бичиг;

1. ᛋ..... [ᛋ]ᛟᚱ[ᛋ]
2. ᛚᛉᛟᛁᛉᛖ ᛇᚲᛝᛈᚠ
3. ᛇᛇᛋᚺᚱᛇ:ᛚᚢᛗᚱᛟ
4. ᛚᛒᛇᚢᛗᚱᛟ:ᛩᛋᛃᚱᛇ

Үсгийн галиг;

1. [L]W T [R]..... ŋ
2. ŋ Y nč W wQ g l s b l i
3. T W LT N i: L W Q R L wQ
4. wQ W B Rp: T W LT N L D i

Үгийн галиг;

1. .....
2. ilbis ilig qunčuyïŋ
3. tultonï: alu qarluq
4. qub arïp: tulton aldï

Үгчилсэн орчуулга;

1. .....
2. Илбис Илиг гүнжийн
3. бэлэвсрэлийн хувцсыг авруун Карлук
4. хурж бэлэвсрэлийн хувцас авав.


Утгачилсан орчуулга;

1.....
2. Илбис Илиг гүнжийн
3.гашуудалд /хойллогод/ Карлук
4. хурж гашуудав /бэлэвсрэв/.

[12] Ц.Баттулга, Бөмбөгөрийн бичээс, -Acta Mongolica, Vol.4 (236), Ulaanbaatar, 2005, 117-124 дүгээр тал.

Баруун хажуугийн бичээс

Эх бичиг;



Үсгийн галиг;

üza [tŋrk]a SRa yrka:yüknük̲m BR rti YŋL̲T w̲Qm Yw̲Q:BSmlG: BWDN

Үгийн галиг;


üzä [tŋrik]ä asra yerkä:yükünüküm bar ärti yaŋïltuqïm yoq:basmïlïγ:bodun


Орчуулга;

Дээд тэнгэр, доод газарт залбирч асан бөлгөө. Буруутсан минь үгүй. Басмылыг ард түмэн

Тайлбар

Хөшөөний магнайн бичээсийн хоёрдугаар мөрийг буруу харуулан бичсэн нь нилээд анхаарал татаж байна. Зүй нь  гэж бичих байсныг буруу харуулан гэж сийлсэн нь магадгүй талийгаачтай холбоотой нэр цээрлэх зан үйл, ёс байж мэднэ.

 ilbis ilig гэдэг нь гүнжийн нэр бололтой. Хэрвээ il bilgä байсан бол Ил Билгэ гүнж хэмээн илүү зохист, эртний түрэгийн бичгийн дурсгалуудад олонтоо тохиолдох нэр гарч байна хэмээн үзэж болох. Гэтэл эх бичигт (i) бус (s) байгаа тул ilbis ilig гэж уншихаас өөр аргагүй юм.

 tulton. tul-бэлбэсэн [13], ton-дээл хувцас гэсэн хоёр үг "tulton" буюу бэлэвсрэлийн хувцас[14] гэх үг үүсгэжээ. Tulton гэх үг монголын руни бичгийн дурсгалуудад урьд өмнө нь огт тохиолдож байгаагүй үг бөгөөд Турфаны цуглуулгын манихей, уйгур бичгийн дурсгалд гарч байна.

Чингисийн чулууны бичигт "Yisüngge ontudur-un γurban jaγud γučın tabun aldas-tur ontudulaγ-a (at the long-distance shooting [contest] Yisüngge shot an arrow 335 alda)"[15] хэмээн бичсэн байдаг. Энэ өгүүлбэрт Yisüngge ontudur-un гээд дараа нь уг санаагаа батлан лавшруулж ontudulaγ-a хэмээн давтжээ. Лавтай, Монголын нууц товчоонд энэ мэт жишээ олон бий.

Бидний судлан бүхий бичээст монгол хэлний дээрх дурсгалын адил аргаар үйл явдлыг батлан лавшруулсан байна. Өөрөөр хэлбэл "ilbis ilig qunčuyïŋ *tultonï alu*

---

[13] Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр.585; Sir Gerard Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish, Oxford, 1972, pp.489.

[14] Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр.585; Sir Gerard Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish, Oxford, 1972, pp.512.

[15] Igor de Rachewiltz, Some remarks on the stele of Yisüngge, -Tractata Altaica.Denis Sinor Sexagenrio Optima de Rebus Altaicis Merito Dedicata, Herausgegeben von W.Heissig und K.Sagaster, Wiesbaden, 1976, pp.447-448.

(Илбис гүнжийн *бэлэвсрэлийн хувцасыг авч*) гээд уг санаагаа батлан лавшруулж qarluq qubranïp tulton aldï (Карлукууд цуглаад *бэлэвсрэлийн хувцыг авлаа*) [*гүнжийн бэлэвсрэлийн хувцыг авч... бэлэвсрэлийн хувцыг авлаа*)] хэмээн тодотгосон ажээ. Энэ жишээнээс үзэхэд ямартаа ч монгол, түрэг хэлэнд үг давтаж уг зүйлийг бататган лавшруулж бичих нэгэн зүйл уламжлал, зүй тогтол байсан бололтой.

Хөшөөний баруун талын бичээс üzä (дээд) гэж эхэлж байгаа ч дараагийн үсэг, үг сийлсэн хэсгээс эмтэрч унажээ. Удаах өгүүлбэр asra yerkä (доод газарт) гэж буй тул эмтэрсэн хэсэгт [tŋrik]ä гэсэн үг байсан болов уу хэмээн үзэж байна. "üzä teŋrikä asra yerkä-дээд тэнгэрт, доод газарт" гэх тогтсон хэллэг, хэлц нь монголын руни бичгийн сонгодог дурсгалуудад байнга давтагддаг онцлогтой.

𐰺𐰇𐰋𐰾 yükün -Уг үг бөхийх, гудайх, тонгойх, мэхийх гэсэн утгаар Билгэ хааны гэрэлт хөшөөний хойт талын 10, зүүн талын 3,13, 16-р мөр, Көлтигиний гэрэлт хөшөөний зүүн талын 2,15-р мөрнөө тус тус тохиолддог. Жишээ нь Билгэ хааны гэрэлт хөшөөний хойт талын 10-р мөрнөө "bašlïγïγ yüküntürtüm tizligig sökürtüm –толгойтыг бөхийлгөв би, өвдөгтийг сөхрүүлэв би" хэмээн гарч байна.

Хожим уг үгийн утга шилжиж, мөргөх, залбирах гэсэн утгатай болсон бололтой. Уйгур нар мааниин болон бурханы шашинд орж "Алтан гэрэл" тэргүүт сударнома орчуулснаас эл үгийн утга шилжихэд хүрсэн байж болох юм. Уйгур "Алтан гэрэл" сударт уг үгийг ихэвчлэн "бурханд мөргөх, залбирах, мөргөх, шүтэх" гэсэн утгаар олон удаа гарч байна[16].

Хижрагийн 466 он буюу нийтийн тооллын 1072-3 оны хооронд Кашгарын Махмудын зохиосон толь бичигт "yükün" хэмээх үгийн утгыг нилээд олон жишээ гарган дэлгэрэнгүй тайлбарлажээ. Тухайлбал, "Teŋrige yükün" гэсэн үгийг "Allaha secde et demektir- Аллахад залбирал үйлд гэсэн үг" [17] хэмээн тайлбарласан байна. Мөн "qul teŋride yükündi-боол тэнгэрт залбирав", "toyun burxanqa yükündi- тойн бурханд залбирав" гэх мэт жишээ дурдсан ажээ. Бас

Yükünüp maŋa imledi
Közüm yašïn yamladï
Baγrïm bašïn emledi
Elkin bolup ol kečer...[18] гэсэн дөрвөн мөр шүлэг хадаж уг үгийн "бөхийх, мэхийх" гэдэг утгыг тайлбарласан ажээ.

"Махмудын тайлбарт тулгуурлан эл шүлгийг;
Мэхийн тэр намайг ажиглалаа
Мэлмэрэх нулимсийг минь [тэр] арчлаа
Зүрхний минь гунигийг [тэр] эмчиллээ [эмчилчхээд]
Зүгээр л явж одлоо тэр, зочлон ирчихээд..." хэмээн утгачилан орчуулж болох мэт.

---

[16] Cevel Kaya, Uygurca Altun Yaruk, giriş, metin ve dizin. Türk Dil Kurumu Yayınları: 607, Ankara, 1994, s. 825-826.

[17] Divanü-Lûgat-it Türk, Türk Dil Kurumu Yayınları:522, çeviren Besim Atalay, Cilt II, 4.baskı, Ankara, 1998, s.167.

[18] Divanü-Lûgat-it Türk, Türk Dil Kurumu Yayınları:523, çeviren Besim Atalay, Cilt III, 4.baskı, Ankara, 1999, s.84-85.

𐰋𐰃𐰚𐰇:𐰴𐰺𐰃𐰚𐰇 Basmïlïγ bodun- basmïl гэх нэр Көлтигин, Билгэ хааны гэрэлт хөшөө зэрэг хөх түрэгийн бичгийн сонгодог дурсгалууд, Моюнчур, Тариатын зэрэг уйгурын үеийн руни бичгийн дурсгалуудад олонтоо дурдагддаг. Хамгийн сонирхолтой нь *–ïγ* гэх нөхцөл юм. *–ïγ~* lïγ нь Билгэ хаан, Көлтигиний гэрэлт хөшөөний бичээст гарах qaγan- lïγ (хаантай), ton- luγ (хувцастай), kedim-lig (тоногтой) гэх мэт үгийн нэгэн адил нэрээс нэр үүсгэх дагавар[19] байж болох юм. Ийн үзвэл уг хөшөөний баруун хажуугийн бичээсийг дан ганц басмыл түмэн биш харин басмыл давамгайлж ноёлсон, бусад овог аймгууд хамтран бичсэн болж таарна. Нөгөө талаар 𐰴(l) давтагдаж ороогүй гэж үзвэл *–ïγ* нөхцөл нь заах утгыг илтгэнэ. Тэгвэл басмылыг улс түмэн гэж орчуулж болно. Бид *basmïlïγ* гэх үгийг хувиргаж орчуулсангүй, харин цаашид лавлан судлах шаардлагатайг тэмдэглэн үлдээе.

Бичээсийн утгаас үзвэл шивээ, хөшөөг Илбис Илиг хэмээх нэгэн гүнжийн дурсгалд зориулсан болох нь тодорхой байна.

𐰴𐰖𐰍𐰃 qarluq-Харлук. Нангиад сурвалж бичигт Карлук хэмээх нэр 143 онд анх удаа тэмдэглэгдсэн гэдэг. Э.Шаванн Карлукийн талаар "D'après le *T'ang chou*, chap.CCXYII, b, p. 6 r^0, les *Ko-lo-lou* (Karlouk) demeuraient au nord-ouest de *Pei-t'ing* (près de Goutechen) et à l'ouest du *Kin-chan* (Altai). Ceci ne peut guère s'enteudre que s'ils étaient établis sur les bords de la rivière Ouroungou qui se jette dans le lac Kysyl-bach, appelé aussi lac Ouroungou; c'est en effet entre la rivière Ouroungou et l'Irtych noir que la carte des contrées occidentales à l'époque des *T'ang* (*Si yu t'ou tche*, chap. III, p.8 v^0 et 9 r^0) place les Karlouk; cette carte identifie avec l'Irtych noir la rivière *Pou-kou-tchen* 僕固振 sur les bords de laquelle, d'après le T'ang chou (chap. CCXYII, b, p. 6 r^0) vivaient les Karlouk. Cf. aussi *Si yu t'ou, tche*, chap. XXY, p. 7 v^0," [20] хэмээн тэмдэглэжээ.

Энэ мэдээнээс үзвэл Карлукууд одоогийн Алтайн уулын баруун тал, Кызыл баш нууранд цутгадаг Өрөнгө голын эрэг хавиар нутаглаж байсан нь тодорхой ажээ. Зарим сурвалжид Карлукууд Алтайн нуруунаас Талас гол, Балхаш, Зайсан нуурын өмнө бие, Дорнод Туркестаны хойд биеэс Иссык-куль нуурын өмнөд тал хүртэлх газар нутгийг эзлэн суудаг хэмээн өгүүлсэн нь буй[21].

Карлук нэрийг нангиад сурвалжид ko-lo-lu, ka-lo-luk, төвд сурвалжид gar-log, араб сурвалжид halluh, harluh, согд сурвалжид γrr-wγt хэмээн тус тус тэмдэглэсээр иржээ[22].

Карлук (𐰴𐰖𐰍𐰃qarluq) нэр Көлтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээст долоон удаа, Моюнчур, Тариатын гэрэлт хөшөөний бичээст мөн нижгээд удаа тохиолдоно. Харин монгол сурвалжууд, тухайлбал Монголын нууц товчооны 198-р зүйлд "naiman-u gücülük-qan ui'urtai *qarlu=ud-i* da'arin sarda'ul-un qajar-a cui-müren-e bükün qara-kidad-un gür-qan-tur neyilen otcu'ui"[23] , мөн 235-р зүйлд "qubilai-noyan-

---

[19] Cengiz Alyılmaz, Orhun Yazıtlarının Söz Dizimi, Atatürk Üniversitesi Yayınları No:830, Erzurum, 1994, s.15-16.

[20] Edourd Chavannes, Documents Sur les Tou-kiue (Turcs) Occidentaux, Paris, 1941, pp.33.

[21] А.Г. Малявкин, Материалы по истории уйгуров в IX-XII вв., Том II, Новосибирск, 1974, стр.97.

[22] Hüseyin Salman, Karluklar, -Türkler 2, Yeni Türkiye Yayınları, Ankara, 2002, s.421.

[23] Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, Bloomington, 1972, pp. 109.

i *qarlu'ut-tur* ca'ura'ulba. *qarlu'ud-un arslan-qan* qubilai-tur elsen irejü'üi"[24] хэмээн гарч байна.

Уйгурын хаант улсын үед Харлукууд гурван хэсэгт хуваагдаж байсан ажээ. Үүнд нэг хэсэг нь Өтүкэн /Ц.Б. Хангайн нуруу/-д амьдарч байсан бөгөөд тэд Уйгурын хаант улсын харьяат байв. Хоёрдахь хэсэг /гурван харлук/ нь Иртиш мөрний сав дагуу нутаглаж байсан ба тэд өөрсдийн Ябгутай буюу эзэн захирагчтай байжээ. Бешбалык хотын ойролцоо нутаглах гуравдахь хэсгийг Тун Билгэ (Toen Pi-kia Tun) Ябгу захирч байжээ[25].

Басмыл (𐰉𐰢𐰼𐰃𐰇 basmil)-ийн тухай түүхэн сурвалжуудад дэлгэрэнгүй мэдээ төдий л олон бус бололтой.

Н.В.Кюнер Басмылийн тухай "Басими (Басмюль) одно и то же, что государство Били. Стали известны во время династии Суй /589-618/. Находится на юг от Бэйтина и Бэйхая /Байкала/, на восток от цзйегу /хягасов/. На юге примыкают к горам"[26] гэж өгүүлсэн байна.

Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудад Басмыл нэр Карлукын хамт болон дангаараа цөөнгүй тохиолддог. Жишээ нь, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 25 дугаар мөрд "yegirmi yašïma basmïl ïduq qut uγušum bodun ärti: arqaz ïdmaz tiyin süledim- Хорин насандаа Басмыл ариун өлзий /хишиг/-т садан түмэн билээ. Жин ирүүлсэнгүй хэмээн дайлав би" гэсэн нэгэн сонирхолтой мэдээ бий.

741 онд Түрэгийн хоёрдугаар хаант улсын насан бага Тэнгэр (Тэнгри) хааныг хороогоод, түүний авга ах Кутлуг Ябгу хаан ширээг нь эзэлсэн байна[27].

742 онд Уйгур, Карлук, Басмыл нар түрэгийн эсрэг босч эхэлсэн[28] бөгөөд Басмылууд 744 онд түрэгийн Озмыш хааныг алаад толгойг нь Чанъянд илгээсэн ажээ[29].

Түрэгүүдийн зарим нь үүнд ихэд дургүй байсан хэдий ч Басмылын удирдагч байсан нэгэн Түрэгийн хаан ширээнд суусан гэдэг[30].

Гэвч төдөлгүй Уйгурууд холбоотон болох Карлук, Басмыл нарыг дарж эрхшээлдээ оруулан төр улс байгуулжээ. Энэ талаар Моюнчурын гэрэлт хөшөөний бичээсэд тодорхой өгүүлснийг дурдвал " */баруун талын 2-р (W2) мөр/*... basmïl qarluq yoq boltï qony yïlqa...- басмыл, карлук үгүй болов. Хонин жил (755)..." хэмээжээ.

Уг мэдээнд тулгуурлан зарим судлаачид Моюунчур 754 оны 10-р сард Карлук, Басмыл нарыг бүрэн эрхшээлдээ оруулан захирсан [31] гэж үзсэн байдаг.

---

[24] Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, Bloomington, 1972, pp. 135.

[25] Hüseyin Salman, Karluklar, -Türkler 2, Yeni Türkiye Yayınları, Ankara, 2002, s.421-422.

[26] Н.В Кюнер, Китайские известия о народах Южной Сибири, Центральной Азии и Дальнего Востока, Москва, 1961, стр. 49.

[27] С.Г.Кляшторный, Т.И.Султанов, Государства и народы Евроазийских степей. Древность и средневековье, Санкт-Петербург, 2000, стр.99.

[28] Л.Н.Гумилев, Древние Тюрки, Москва, 1993, стр.363.

[29] Liu Mau-tsai, Die chinesischen Nachrichten zur Geschichte der Ost Turken, Buch I-II, Wiesbaden, 1958, s.261; Л.Н.Гумилев, Древние Тюрки, Москва, 1993, стр.364.

[30] Н.Я.Бичурин, Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена, Москва-Ленинград, 1950-1953, Том.I-III; Том.I, стр.308.

[31] Saadettin Gömeç, Uygur Türlkleri Tarihi ve Kültürü, (düzeltilmiş, yeniden gözden geçirilmiş 2. bask,) Ankara, 1998, s.34.


Энэ цаг үеэс хойш Карлук, Басмыл нар дахин энэ газар нутагт ирсэнгүй бөгөөд дундад Азид буцаж суурьшин торгоны замаар Араб, Ойрхи Дорнодын орнуудтай харилцах болжээ[32].

Моюнчурын гэрэлт хөшөөний бичээст давхардсан тоогоор Карлук нэр 12 удаа, Басмыл нэр 4 удаа тохиолдож байгаа нь тэд (Карлук, Басмыл нар)Түрэгийн хаант улсын төгсгөл, Уйгурын хаант улсын эхэн үеийн түүхэн хэрэг явдалд ихээхэн идэвхтэй оролцож байсныг нутлан харуулж байна.

Сурвалжуудын дээрх мэдээ баримт, тухайн үеийн түүхэн хэрэг явдлуудтай харгуулан үзвэл 744-755 оны үед уг бичээс бичигдсэн байж болохоор байна.

Монгол нутгаас Карлук, Басмыл нарт холбогдох руни бичгийн дурсгал анх удаа олдож байгаагаараа ихээхэн онцлогтой болохыг тэмдэглэе.

Бичээст гарах үгийн толь



[32]Hüseyin Salman, Karluklar, -Türkler 2, Yeni Türkiye Yayınları, Ankara, 2002, s. 422.

ГУРВАЛЖИН УУЛЫН БИЧЭЭС

Булган аймгийн Гурванбулаг сумаас зүүн өмнө зүг 17 км-т Гурвалжин нэрт багахан шовх уулын бэлд, Тарнын голын баруун талд нэг мөр бичээс буйг судлаачид "Гурвалжин уулын бичээс" гэж нэрлэсээр иржээ.

Дурсгалын байршлын цэг; 1176 m, 48 T 0391591, UTM 5276223.

Судалгааны товч

Эл бичгийн дурсгалыг анх мэргэн гүн Мөнх-Очирын Гомбожав гар хуулбар хийж Судар бичгийн хүрээлэнгийн захирал байсан Жамсрангийн Цэвээн гуайд өгсөн гэдэг. Мэргэн гүн Мөнх-Очирын Гомбожав гуай тухайн үедээ нилээд боловсролтой нэгэн байсан гэдгийг түүхийн олон баримтууд нуталдаг билээ.

Тэрээр Франц улсад суралцсан анхны монгол оюутнуудын нэг бөгөөд лавтай мэдэхээс монгол, төвд хэл бичигт нэвтэрсэн тэрээр уг бичээс түүхийн чухаг эх хэрэглэгдэхүүн мөн учир утга агуулгыг мэдэж таниваас зохилтой хэмээн санаж хуулбарлан авсан нь магад буй за.

Ж.Цэвээн гуай 1929 онд Оросын эрдэмтэн А.Н.Самойловичид энэ бичээсийн гар хуулбарыг илгээсэн байна. А.Н.Самойлович хүргүүлсэн хуулбарт тулгуурлан "teŋri qulï bitidim-Тэнгэрийн боол бичив би" гэсэн утгатай болохыг тайлж 1934 онд хэвлүүлсэн ажээ[33].

Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун "Gürbelçin kaya yazıtı" нэртэйгээр А.Н.Самойловичийн нийтлүүлсэн эх галигийг хэвээр нь авч, орчин цагийн турк хэлнээ "Tanrı kulu yazdım" гэж хөрвүүлжээ[34].

Манай судалгааны ном зохиолуудад нилээд хожим олдож мэдэгдсэн мэтээр тэмдэглэсээр ирсэн билээ. О.Намнандорж гуай 1966 онд Архангай, Булган, Өвөрхангай аймгийн нутгаар 10 хоног аялал, судлалаар явахдаа нутгийн ард Аравжирийн мэдээллийн мөрөөр энэ дурсгалыг үзэж гэрэл зураг авч товч тодорхойлолт бичсэн ажээ[35].

Б.Ринчен академич "*Les dessigns pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie*" бүтээлдээ уг бичээсийн гэрэл зургийг нийтлүүлсэн байна[36]. Б.Ринчен академич нийтлүүлсэн гэрэл зургийн эхэд тулгуурлан 1969 онд Б.Базылхан уншиж судалжээ.

Тэрбээр уул бичээсийг "Тенри кулы амысде ит" гэж галиглан монгол хэлнээ "Тэнгэрийн боол одоо эрэл сурал хий" гэж орчуулсныг үзвэл нилээд ташаа уншсан байна[37]. Судлаач бичээсийг нүдээр үзээгүй нь ташаарах шалтгаан болсон биз ээ. 1975 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан түүх, соёл, бичиг судлалын хээрийн шинжилгээний ангийн "Бичээс судлалын хэсэг" энэхүү Гурвалжин уулын

---

[33] А.Н.Самойлович, Новые тюркские руны из Монголии, - Известия Академии Наук СССР, Отделение обшественных наук, № 8, Москва, 1934.

[34] H.N.Orkun, Ulan-Bator (Urga) kiremit yazıtı, -Eski Türk yazıtları II, İstanbul, 1938, pp.161-162, (Birinci Baskı: 1936, 1938, 1940, 1941, İkinci Baskı: 1987, Üçüncü Baskı:1994, Ankara, pp.353-354).

[35] О.Намнандорж, Арван өдрийн шинжилгээний аялал, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №5, Улаанбаатар,1966, 38-41дүгээр тал

[36] Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, - Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc I, Улаанбаатар (Oulan bator), 1968, pp.37.

[37] Б.Базылхан, Гурвалжин уулын түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, № 4, 1969, 14-15 дугаар тал.

бичээсийг үзэж судалсан ажээ. Уг хээрийн шинжилгээний ангийн ахлагч, түрэг судлаач, нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный уг бичээсийн уншиж судалсан байна.

Тэрээр бичээсийг "teŋri qulï bitidim" гэж галиглаад орос хэлнээ "Написанный мной небесного раба", "Я, раб божий, написал" гэж орчуулжээ[38].

"БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс" номонд С.Г.Кляшторный абугайн галигийг хэвээр нь авч, бичээсийн орос орчуулгыг монгол хэлнээ "Тэнгэрийн боол би бичив" гэж буулгасан байна[39].

Монголын нутаг дахь түүх соёлын дурсгал номонд энэ бичээсийн тухай мөн дэлгэрэнгүй өгүүлжээ[40].

Монгол-Туркийн засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу хэрэгжсэн "Орхоны хөндий дэх түрэгийн үеийн зарим хөшөө дурсгалыг судлах, сэргээн засварлах, хадгалах, хамгаалах төсөл"-ийн хүрээнд Ататурк их сургуулийн багш Жэнгиз Алйылмаз /Cengiz Alyılmaz/-ын хамт уул бичээсийг үзэж дахин нягталсан ба өмнө нь ч хэд хэдэн удаа очиж судалж байсан билээ.

Бичээсийн тухай

Гурвалжин уулын бичээс нь 130 х 98 см хэмжээтэй саарал боржин чулуун дээр маш тодорхой, гаргацтай бичсэн, цохимол бичээс юм.

Нийтдээ 70 см урт бичээсийн эхний үсэг 7 см, төгсгөлийн үсэг 11см өндөр бөгөөд 13 үсэг тэмдэгттэй, үсгийн зурлага бичлэгийн хэлбэр тогтсон, харьцангуй хичээнгүй ажээ.

Бичээсийн дээд талд хоёр тамга сийлсэн нь уул бичиг үйлдүүлэгч, үйлдэгчийн овогтой холбоотой бүй за.

Он цагийн хувьд эл бичээс нь Уйгурын хаант улсын үед холбогдох нь дамжиггүй юм.

Бичээсийн эхийн сийрүүлгэ;	Үсгийн галиг;	Үгийн галиг;
𐰚𐰃𐰠𐰇:𐰇𐰃𐰍𐰇	tŋriQWLi bitdm	teŋri qulï bitidim

Монгол хэлнээ орчуулбал; Тэнгэрийн боол бичив, би

Бичээст гарах үгийн толь

𐰉𐰍𐰇 *tŋri* - 𐰺𐰼𐰣 tngri, тэнгэр

𐰇𐰃𐰍 *qulï* - 𐰴𐰼𐰣 *boγul,* боол

𐰚𐰃 𐰋𐰉𐰍 *bitidim* - 𐰋𐰆𐰴𐰍 𐰋𐰆 *bičibe bi* бичив би

---

[38] С.Г.Кляшторный, Наскальние рунические надписи Монголии, -Тюркологическая сборник, Москва, 1975, стр.155; С.Г.Кляшторный, Надпись из Гурвалжин-ула, -История Центральной Азии и памятники рунического письма, Санкт-Петербург, 2003, стр.274-275.

[39] Л.Болд, Гурвалжин уулын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 23-24 дүгээр тал.

[40] Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал (сэдэвчилсэн лавлах), Улаанбаатар, 1999, 207 дугаар тал.

Гурвалжин уулын хэмээн нэрлэгдэх ганц мөр энэ бичээс уйгуруудын тэнгэрийг шүтэх шүтлэг, тухайн үеийн язгууртан болон бичгийн хүний өөрийгөө бусдад танилцуулах, өөрийнхөө тухай бичих ёс журмын талаар тодорхой мэдээлэл өгч байгаагаараа ихээхэн ач холбогдолтой юм.

Тэнгэрийг шүтэх ёс зөвхөн нүүдэлчид төдийгүй эртний нангиад зэрэг суурьшмал соёл иргэншилт улс гүрэнд ч байсныг түүхийн сурвалжууд баталдаг.

Тэнгэрийн шүтлэг нь магадгүй бөө мөргөл, шашин үүсэхээс өмнө байсан хүн төрөлхтний хамгийн эртний нийтлэг шүтлэг байсан бололтой.

Эртний нүүдэлчид, нэн ялангуяа Хүннү нарын үеэс тэнгэрийг шүтэх шүтлэг, түүнтэй холбогдох ёс заншлын талаар бичмэл болон археологийн сурвалжуудаас бага сага зүйлийг мэдэж болох бөгөөд хожмын түрэг, уйгур улсын үеэс энэ тухай харьцангуй тодорхой тэмдэглэгдсэн байдаг.

Уйгурууд хэдийгээр мааниийн шашин шүтэж байсан, мааниийн шашинд орсон гэх боловч язгуурын шүтлэг нь тэдний оюун санаанд хуучны адил үнэ цэнэтэй хэвээр хадгалагдсаар байсныг тэдний үлдээсэн чулуун судрын бичээс баттай нуталдаг билээ.

Энэ бичээсээс жишээлэн үзвэл тэр үед уйгурын дээдэс ихэс, язгуурт ноёд ч тэнгэрийн боол, боол би гэж тэнгэрийн агуу их суу, сүр хүчний өмнө өөрсдийгөө өчүүхэн дорд, доройд үзэх үзэл, тийн бичих ёс түгээмэл байсан бололтой.

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын нутагт байх “Арханангийн бичээс”-д мөн л “Тэнгэрийн боол” хэмээх үг тохиолдож байгаа зэрэг нь үүний давхар нуталгаа, гэрч гэлтэй.

Манай бичгийн уламжлалд ч мөхөс, дорой хэмээн өөрийгөө танилцуулж бичдэг нь магадгүй эрт цагаас улбаалсан өв уламжлал, өнө эртийн бичиг соёлын нөлөө тусгалтай холбоотой буй за.

ГУРВАН МАНДАЛЫН БИЧЭЭС

Судалгааны тойм

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутагт оройг нь тэгшилж тайрсан мэт нэн өвөрмөц тогтоц бүхий сөнөсөн гурван галт уул буйг "*Мандал Хайрхан*" буюу Гурван Мандал хэмээн нэрлэдэг байна. Гурван Мандал уул сумын төвөөс 42 орчим км-т баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон, Эхэн Мандал, Дунд Мандал нь хормой нийлэн орших ба харин Адаг Мандал нь хол саахалтын зайтай байх ажээ. Уулын оройн, толигор хар өнгийн ханан хаднаа олон зүйл зураг, тамга, руни бичиг сийлжээ. Уулын оройгоос өнхөрч бэлд тогтсон толигор гадаргатай том бага, үхэр хонин хаданд ч зураг сийлсэн байна.

1987 оны 8-9 сард ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан С.Дашцэвэл, Р.Бямба нар Гурван Мандалын дурсгалыг анх олж судлаач нарт мэдээлсэн байна[41].

Доктор Л.Болд нар эл бичээсийг уншиж тайлан "Гурван мандлын түрэг бичээс" нэртэйгээр хэвлүүлсэн бөгөөд улмаар "БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс" номдоо оруулжээ[42].

Монгол Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн "Бичээс судлал"-ын ангийнхан 1989 онд гүймэг судалгаа хийсэн бөлгөө*[43].

Доктор Д.Баяр Гурван Мандал уулын хадны бичээс тамга, тэмдгийг тухайлан судлан " Гурван Мандалын хадны зураг" хэмээх өгүүлэл нийтлүүлжээ[44].

Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал номд " Гурван Мандалын бичээс"-ийг Л.Болд гуайн уншлага, орчуулгаар оруулсан байна[45].

Бид 2003 оны 10 дугаар сард Гурван Мандал уулыг зорин очиж хадны зураг, эртний бичээс, тамга тэмдгийг судалсан бөгөөд нэгэн сэдэвт ном гаргахаар зэхэж байгаа болно.

---

[41] Л.Болд, Р.Бямба, Гурван Мандалын түрэг бичээс, -Дорно дахины судлалын асуудал, 1988, №1 (19), 103-108 дугаар тал.

[42] Л.Болд, БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 25-27дугаар тал.

* Уг ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, МУИС-ийн оюутан З.Дараже, Зөвлөлтийн талаас түрэг судлаач С.Г.Кляшторный, археологич В.Е.Войтов, гэрэл зурагчин В.Еремеев, жолооч Р.Бухаров нар оролцож ажилласан байна.

[43] Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, МЗТСХЭ-ийн бичээс судлалын ангид 1989 онд ажилласан ажлын тайлан, -Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан, 1989.

[44] Д.Баяр, Гурван мандалын хадны зураг, -Археологийн судлал, Tom.XVI, fasc.1-11, Улаанбаатар, 1996, 89-102 дугаар тал.

[45] Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал (сэдэвчилсэн лавлах), Улаанбаатар, 1999, 207 дугаар тал.

Дунд Мандалын бичээс

Дунд Мандал уулын баруун урд талд, ханан хаднаа гурван хэсэг руни бичиг, нижгээд тамга буй нь арваад алхмын газраас тодорхой харагдана.


Бичээсийн эхний хоёр мөр тус тус гурван тэмдэгт, гуравдугаар мөр 9 үсэг тэмдэгттэй. Бичээсийг хадны өнгөн хэсгийг холцруулан төдий л гүнзгий бус сийлжээ.

Дунд Мандалын бичээсийг проф. Л.Болд гуай "А" бичээс хэмээн болзмолоор нэрлэж улмаар уншиж тайлсан судалгаагаа нийтлүүлсэн байна[46].

Доктор Д.Баяр Дунд Мандалын хадны зургийн тухай өгүүлэлдээ эл бичээсийн зургийг оруулан хэвлүүлжээ.

Бидний авсан хэв дардас, гэрэл зураг, бусад эх хэрэглэгдэхүүн проф. Л.Болд гуайн нийтлүүлсэн эх болоод уншлагаас ихээхэн зөрж байгаа тул өөрсдийн судалгааг толилуулъя.

Дунд Мандалын бичээсийн эхийн сийрүүлгэ;



Үсгийн галиг;	Үгийн галиг;	Орчуулга;
1. t B z	1. täbiz / tabïz/	1. Тебиз /Табыз/
2. Qis	2. qis /qïš/	2. өвөл
3. rTWNLηla wQ	3. är tunulïη /tunuluη/ elä oq	3. Эр /баатар/ Тунулын гарт сум

Тайлбар

täbiz/ tabïz – Тевиз /Табиз/ хэмээх хүний нэр бололтой.

Уг үгийг "tabï~tapï az"[47] гэж унших боломж, нэгэн хувилбар байж болох бөгөөд хоёрдугаар мөрийн "өвөл" гэх үгтэй холбон "өнтэй бус, тааламжгүй, сайнгүй /зудтайвтар/ " гэсэн утгатай хэмээн таамаглаж болно. Харин эсрэгээрээ "tapïz" нь "өнтэй, тарган тавлаг" гэсэн үг байхыг ч үгүйсгэх аргагүй. Дараа дараагийн судлаач нар улам тодотгон нягтлах буй за.

är tunulïη /tunuluη/ ilä oq- үгчлэн "Эр /баатар/ Тунулын гарт сум" гэж монгол хэлнээ орчуулж болох ч утга хараахан бүрэн төгсөөгүй гэлтэй. Эр Тунул нэрийн "эр" нь баатар, зоригтой, эрэлхэг гэх утга агуулсан цолноос үүдэлтэй нь мэдээж ба цол, өргөмж нь хүний нэрийн өмнө тодотгол хэлбэрээр тохиолдох нь монгол түрэг хэлнээ нийтлэг байна.

---

[46] Л.Болд, Р.Бямба, Гурван мандлын түрэг бичээс, -Дорно дахины судлалын асуудал, 1988, №1 (19), 103-108 дугаар тал; Л.Болд, Гурван Мандалын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 25-27дугаар тал.

[47] Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр.534.

𐰴 oq -сум хэмээх үг 1. нум, сумын нум, 2. эртний түрэг, уйгурын бичгийн дурсгалд олонтоо гарах “он ок” буюу “арван овог” гэсэн утгатайг бас санах хэрэгтэй.

𐰇𐰚- Хэрэвзээ энэ үгийг “𐰇𐰚 el-a(ä)” гэсэн бүтэцтэй нэр үг хэмээн ухаарвал “гар-(н)аа, гар-т “ гэж орчуулж болно.

“𐰇𐰚 il-a(ä)” үйл үг мөн гэж үзвэл бичээсийн утгад дүйцүүлэн “тавих, илгээх” гэж утгачлан буулгаж болох юм.

Эл үгээс үүдээд уншлагын хөёр хувилбар гарч байгаа юм.

Нэгдүгээрт бидний дээр өгүүлсэн “1. täbiz (tabïz) 2. qis (qïš) 3. är tunulïŋ (tunuluŋ) elä oq” буюу 𐰇𐰚-г “el-a(ä)~ гар-(н)аа, гар-т” гэх үг гэж үзвэл “1.Тебиз (Табыз) 2. өвөл 3.Эр (баатар) Тунулын гарт сум” гэж тайлах боломж буй.

“Өвөл Эр Тунулын гарт сум” гэснээс үзэхэд аян дайн байлдааны үеэр бичсэн бус харин намрын сүүл, өвлийн эхэн сарын их ав хомрогын үеэр энд бичээс үйлдсэн байх магадлал ихтэйг харуулж байна. Нөгөө талаар, Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын зэрэг бичээсээр жишээлэхэд ер нь хадны бичээс, нэн ялангуяа хадны зураг олонтой газрын бичээс голдуу ан авын тухай өгүүлдгийг бас харгалзан үзэх хэрэгтэй болов уу.

Хадны зурагт олон ан амьтан дүрсэлсэн нь эрт цагаас энд ан ав, гөрөө ихтэй байсны гэрч төдийгүй Мандал уулын ус ундтай, нөмөр нөөлөгт байдал нь ч ан амьтан элбэгтэй байсныг бэлхнээ баталж байна.

Хоёрдугаарт, “1. täbiz (tabïz) 2. qis (qïš) 3. är tunulïŋ (tunuluŋ) elä oq” буюу 𐰇𐰚 “il-a(ä)”-г үйл үг гэж үзвэл бичээсийг “1.Тебиз (Табыз) 2. Акыс (Кыс) 3.Эр (баатар) Тунулун илгээ (тавь) сум” гэж үгчлэн тайлах боломж бас буй.


Аль ч хувилбараар уншсан гуравдугаар мөр бичээсийн гол санааг агуулж буй нь тодорхой байна.

Хоёрдугаар хувилбараар сэргээн уншсаныг “Эр (баатар) Тунулун сум тавив” гэж утгачлан буулгах боломжтой мэт. Ав гөрөөнд ирж анх Эр (баатар) Тунулун (Тунулан) гэгч нум эвшээлгэж сум тавьснаар (ан авласнаар) ав хомрого эхэлснийг тэмдэглэн үлдээсэн байж болох юм.

Тебиз (Табыз), Акыс (Кыс) нь энэ үйл явдлыг гэрчлэгч, оролцогч этгээдүүд буюу эсвээс тэр удаагийн ан хомрогын түүхэн үйл явдлыг хаднаа цохиж үлдээгсдийн нэр ч байж мэднэ.

Уг бичээсийн утга дараа дараагийн судалгаагаар улам лавтай, тодорхой болох буй за. Нэгэнт хоёр хувилбараар буй тул бичээст гарах үгийн толийг мөн хоёр хувилбараар оруулав.

Бичээст гарах үгийн толь



Проф. Л.Болд уг бичээсийг доорх мэт галиглан уншиж орчуулсан байна.

Үсгийн галиг:	Үгийн галиг:	Орчуулга:
I. т (2) б (1) з	I. ата быз …	1. …эцэг бид...
II. к (1) ы (-и) с	II. … Акыс …	2. …Акыз...
III. р (2) т (1) м л (1) нг ч ы (-и) к (1)	III. ер атым Улунгчик (-Олунгчык)	3. эр нэр минь Улунгчык[48]


[48]Л.Болд, Р.Бямба, Гурван Мандалын түрэг бичээс, -Дорно дахины судлалын асуудал, 1988, №1 (19), 103-108 дугаар тал.

Адаг Мандалын бичээс

Адаг Мандалын бичээсийг проф. Л.Болд гуай "Б" бичээс хэмээн нэрлэжээ.

Уг бичээсийг уншиж тайлсан тухай өмнөх эрдэм шинжилгээний өгүүлэл болон номд нийтлэгдсэн хуулбар нь эх бичигтэйгээ нилээд зөрж байна.

Бичээсийн эхийн сийрүүлгэ;



Үсгийн галиг;

1. QTLTWNdrrt
2. nl ükQiz: QRGz: čQ:k
3. TWnyLG: türtglta: tür QN

Үгийн галиг;

1. Qut altun äd ärürti
2. Inälük qiz qaraγaz ačqa iki
3. tunyaluγ tör tägi iltä tür qan


Хэдийгээр бичээсийн эхэд дурдсан мэт байрлалтай байгаа ч эхний мөрийн төгсгөл хоёрдугаар мөрийг бараг дарах шахам дууссан нь нэн сонин, хачирхалтай санагдаж байгаа юм. Бичээсийн бичлэгийн хэлбэр, үсэг тэмдэгтийг бичсэн байдал, тамга тэмдэг сийлсэн ур дүйг үзвээс яах аргагүй "руни үсэг бичигт тайлагдаж боловсорсон нэгэн" бичсэн болохыг гэрчилнэ.

Гэтэл чухам яагаад эхний мөрийг "хайнга" дээрээс доош уруудуулан хазгай бичсэн бол гэсэн асуулт зүй ёсоор гарч байгаа юм. Бидний санахад эхлээд олон зүйл тамга тэмдэг сийлсний хойно бичиг бичих санаа төрж улмаар тэдгээр сийлсэн тамганы дундах зайг ашиглаж энэ бичээсийн үйлдсэн бололтой. Тэгэхдээ нэгдүгээр мөрийн дээд талд хоёрдугаар мөрийг, хоёрдугаар мөрийн дээд талд гуравдугаар мөрийг тус тус бичжээ.

Эхний мөрийг тамгатай залгуулан бичсэнээс дараагийн мөрийг бичихэд бэрхтэй болж, хоёрдугаар мөрийг эсвэл тамганы доор, үгүй бол нэгдүгээр мөр бичээсийн дээд талд бичихэд хүрсэн бололтой.

Тамганы доор бичих боломжгүй, хадны барзгар, хагархай, толигор бус хэсэг дайрснаас шууд нэгдүгээр мөрийн дээд талд бичсэн байна. Иймд бичээсийг доорхи дарааллаар мөрлөн дугаарлаж болох юм.

Бичээсийн эхийг зөв дараалалд оруулан сийрүүлбэл;



Үсгийн галиг;

1. TWnyLG: türtglta: tür QN
2. nl ükQiz: QRGz: čQ:K
3. QTLTWNdrrt

Үгийн галиг;

1. tunyaluγ tör tägi iltä tür qan
2. Inälük qiz qaraγaz ačqa iki
3. Qut altun äd ärürti

Үгчилсэн орчуулга:

1. Хатуу чанга хууль ёс мэт улстай Төр хан
2. Итгэлт охин Карагаз, Ачха хоёр
3. Өлзийт алт, эд агуурс хүргүүлэв

Эх бичиг яруу найргийн хэлбэрээр бичигдсэн тул толгой холбон шүлгийн хэлбэрт оруулан

1. Чанд хатуу хууль ёст хүчирхэг улстай Төр хан

2. Чин итгэлт охин Карагаз, Ачка хоёр

3. Өлзийт алтан эд агуурс хүргүүлэв гэж буулгаж болно.

Гэхдээ чанд хатуу төртэй /хууль ёст/ бат бэх улстай Төр хан, түүний үнэнч охид Карагаз, Ачха хоёр чухам яагаад хэнд өлзийт сайн эд агуурс хүргүүлэх болсон, энэ тухай сэтгэл хангалуунаар бичүүлж үлдээх болсон шалтгааныг лавлан тодруулах зайлшгүй шаардлагатай.

Нэгдүгээрт, эхний хоёр өгүүлбэрийн төгсгөлийн "хан, хоёр" гэсэн үгс ерөнхийлөн хамаатуулахын ø нөхцлөөр хэлбэржсэн байна хэмээн үзэж тайлбарлах.

Эртний түрэг хэлний сурвалжийн хэлний судалгаанаас үзэхэд ерөнхийлөн хамаатуулах нөхцөл ø хэлбэрээр илрэх нь олонтоо байдаг[49]. Нэн ялангуяа яруу найраг, шүлгийн айзамт өгүүлбэрт харьцангуй олон тохиолдоно.

Нэг, хоёрдугаар мөрийн төгсгөлийн үгс ерөнхийлөн хамаатуулахын ø нөхцлөөр хэлбэржсэн гэж үзвэл монгол хэлнээ бичээсийг;

Чанд хатуу хууль ёст хүчирхэг улстай Төр ханаа

Чин Илтгэлт охин Карагаз, Ачка хоёроо

Өлзийт алтан эд агуурс /тай/ хүргүүлэв гэж орчуулж болно.

Хоёрдугаарт, эртний нүүдэлчдийн ёс заншилтай холбон тайбарлаж болох юм. Худ ураг барилдаж охиноо хадамд гаргах, бэлэг сүйд охиноо өгөх, бэлэглэх нь эртний нүүдэлчдийн ёс заншлын нэгэн нийтлэг билээ. Нүүдэлчдийн түгээмэл энэ ёс заншлын талаар руни бичгээр гэрэлт хөшөө чулуунаа тэмдэглэн үлдээсэн нэн чухаг ховор сурвалжийн нэг бол Сүүжийн дабааны бичээс юм. Нэрт эрдэмтэн Г.И.Рамстедт 1913 онд Булган аймгийн нутаг Сүүжийн даваа гэдэг газраас олсон энэ бичээсийн 6,7-р мөрөнд "(надад) долоон дүү, гурван хүү, гурван охин бий. Хөвүүд минь гэрлэцгээсэн. Охиноо сүйгүйгээр мордуулав....[50]" гэж буй нь тухайн үеийн гэрлэх, охиноо мордуулах ёс ямар байсныг хамгийн бодитой харуулсан гэж үзэж болно.

Сүүжийн дабааны бичээсийн дээрх мэдээнд тулгуурлан ёс заншлын улбаа, уламжлалыг харгалзан үзвэл, баян чинээлэг нэгэн өөрийн Карагаз, Ачха нэрт хоёр охиноо, Төр хэмээх хаанд өлзийт сайн эд агуурсын хамт хүргүүлсэн, охиноо хадамд гаргаж мордуулсан тухай энд тэмдэглүүлсэн /бичүүлсэн/ бололтой.

---

[49] Cengiz Alyılmaz, Orhun Yazıtlarının söz dizimi, -Atatürk Üniversitesi, Yayınları №830, Erzurum,1994, s.48.

[50] G.J.Ramstedt, -Zwei Uigurische Runeninschriften in der Nord-Mongolei, - Journal de la Soc.Finno-ougrienne, XXX,3, Helsinki, 1913, p.3-9.

Тайлбар

 tunyluγ (tunyalïγ) - энэ үгийг бид "бат бэх, тулгууртайн учир хүч чадалтай, тогтвортой" гэсэн утгатай хэмээн үзэж байна. Монголын нууц товчоонд "**tuγal**" гэх үг "...tulu metü beye cinu tulbas odu'asu **tuγal** metü ulus cinu ken-e mede'ülkün tede..." (§245, §254)[51] гэж хоёр удаа тохиолдож байна.

Энэ үг (tuγal)-ийн нангиад эхийг үзвэл (§245), 群鸟qúnniǎo ("сүрэг шувуу") (§254) 雀群quèqún ("бялзуухайн сүрэг") гэсэн утгатай ханз байх юм.

Жич тэмдэглэхэд, "tulu" хэмээх үг эдүгээ бидний мэдэх "тул загас" гэдгийн "тул" бус, харин хятад орчуулгаас үзвэл, 柱脚 zhùjiǎo буюу "багана, тулгуур, суурь" гэсэн үг байгааг дурдууштай.

Мөн **turqag-i, turqaq, turqa`ud-i, turqa`ut** гэх зэрэг үгсийг дурдаж болох ба жишээ нь "dalan **turqag-i** yekes turqa`ut ke`ekdün arqai-yin ba`atud-i ötögüs ba`atut ke`etkün ..." (§230)[52] гэж гардаг.

Монгол хэлнээ тураг (turaγ) амьтан (амьтны том биетэй нь), тураг мах (амьтны их биеийн ба хар мах)[53] гэх үг буй. Бас хүч чадалгүй, эр бяргүй, доожоогүй, тулх, тулгуур муутайг туниагүй, туниа (tuniya) муутай гэж хэлдэг.

Харин туниатай туниат, туниалиг гэх эсрэг утгатай үгс байдаггүй. Туниагүй, туниа муутай гэж голдуу эрэгтэй хүнд хандаж хэлдэг нь бас учиртай мэт санагдана.

Эрт цагт tunyluγ (tunyalïγ) гэсэн үг тамирлиг, чадалтай, хүч чадалтай, баатар, бат бэх, хатуу чанга гэсэн утгатай байсныг ч бас үгүйсгэх аргагүй.

Чуваш хэлнээ "туя"[54] нь таяг (tayaγ) гэх үг бөгөөд тулах, тулгуур гэх язгуур утгаа хадгалан үлджээ. Монгол хэлний таяг (tayaγ), тулга (tulγ-a), чуваш хэлний туя, түрэг хэлний tu~du, tur~dur (turmak, durmak-зогсох) цугаар "tu" язгууртаас гаралтай тул, тулах, тулгуур гэх утгатай үгс болно.

Орчин цагийн турк хэлэнд "dayanıklı / *tu<tuny<tu{ ñ /ŋ/}ıq < tayñıq < dayanık"[55] бат бэх, хүчтэй, чадалтай, бэрх гэсэн утгатай үг бий.

Дээрх цухас дурдсан баримт нь "tu" язгууртай үгс нэгдүгээрт их, том, олон, гол, цөм (tulu, tuγal, turaγ), хоёрдугаарт бат бэх, тулгууртай (tunyluγ, туя, tayaγ tulγ-a, dayanıklı), гуравдугаарт хүчтэй, чадалтай (том, бат бэх нь хүч чадалтайн баталгаа) гэсэн утга тус тус илэрхийлдэг болохыг нуталж байна. Өгүүлсэн жишээ, эх хэрэглэгдэхүүндээ тулгуурлан дүгнэхэд Tunyuquq, tunyaluγ нь бат бэх, хүч чадалтай гэсэн утгатай өргөмж цол бололтой.

 **tör** -төр. Төв Азийн нүүдэлчид эрт цагт ёс, хууль, ёс журмыг ерөнхийд нь "төр (**tör**)" гэдэг байсан нь олон зүйл баримтаар баттай

---

[51] Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, -Indiana University, Bloomington, 1992, pp. 325; Part I, text, pp. 142, 149.

[52] Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, - Indiana University, Bloomington, 1992, pp. 324; Part I, text, pp. 133.


[53] Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 558 дугаар тал; Ts.Norjın, M.Mören, Mongγol kelen-ü toli, Čiγulγatu qaγalγ-a, 1997, 2421, 2422 duγar tal-a; Sečenčoγtu, Mongγol üges-ün ijaγur-un toli, 1988.


[54] Чувашко-русский словарь (25 000 слов), Москва, 1961, стр. 447.



[55] Türkçe Sözlük, Türk Dil Kurumu, 1, A-J, yeni baskı, Ankara, 1988, s. 342.



нутлагдах бөгөөд бидний монголчууд нийтээр дагах ёс, хууль, ёс журмыг соёрхон гаргадаг, ханган сахиулдаг "дээд байгууллага"-ыг нэрлэх болжээ.



Бичээст гарах үгийн толь



 tunyaluγ - qataγu, čingγ-a, хатуу, чанга


 tör –  törü, yosu, төр ёс



 tägi –  metü, sig, мэт, шиг



 iltä /il-tä/ -  ulus, ulus-tai, улс, улстай



 tür –  tür, хүний нэр



 qan –  qan, хан

 inälük /inälik/ –  ünenči, dotunu, үнэнч, дотно, итгэлт



 qiz –  ökin, охин



 qaraγaz –  qaraγas, хүний нэр



 ačqa –  ačqa, хүний нэр

 iki –  qoyar, хоёр

 qut – öljei, buyan, өлзий, буян

 altun –  altan, алт, алтан

 äd —  ed, эд, эд агуурс

 ärürti –  yabuγulqu, oduγulqu, явуулах, одуулах хүргүүлэх

Проф. Л.Болд эл бичээсийг доорхи мэт галиглан уншиж орчуулсан байна.
Үсгийн галиг:
I. т (1) м д (2) р (2)
II. н (2) ч к (2) к (1) ы (-и) з к (1) р (1) г (1) з л (2) нг к (2)
III. т (1) о (-у) м л (1) г (1) т (2) ө (-ү) р (2) к (2) г (2) л (2) т (2) а (-е)
Үгийн галиг:
I. … атым др...
II. еничык Акыз кыргыз елентке
III. … утумлыг түрк егелтке...
Орчуулга:
1. нэр минь др...
2. еничык Акыз киргыз улсад
3. …Утумлыг түргийн эгэл түмэнд...

Дээрх бичээсийн үг хэллэгийн тайлбарыг эртний түрэг хэлний толиудаас лавлан үзнэ үү[56].

[56] Древнетюркский словарь, Ленинград, 1969; Sir Gerard Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish, Oxford, 1972; Э.В.Севортян, Этимологический словарь тюркских языков,

2. Тамга тэмдэгтийн судалгааны тойм

Гурван Мандалын уулын хаднаа давхардсан тоогоор ная илүү тамга тэмдгийн зүйл тоолсон билээ. Бид тамга тэмдгийн тоо гаргахыг хичээж нэг бүрчлэн тоолоогүй, зөвхөн замд дайралдсан тамга, тэмдгийг бүртгэснээ тэмдэглэе.

Говь-Алтай аймгийн Цагаан гол, Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хад зэрэг тамга тэмдгээр алдартай дурсгалуудад дөхөж очих олон тооны тамга Гурван Мандалын уулнаа лавтай бий.

Нэн ялангуяа түрэг, уйгурын үед холбогдох тамга тэмдгийн олон хувилбарууд байгааг онцлон дурдууштай.

Доктор Д.Баяр "Энэхүү Гурван Мандал уулын хадны сүг зургийн дотор эртний овог аймгийн тамганы дүрс олон тоотой байх ба эдгээрийг нарийвчлан тодорхойлж сэдэвчлэн ангилахад жич судалгааны ажил шаардлагатай юм.

Эндхийн тамгадын дотор нэн олон тоотой нь онги тамга бөгөөд үүний олон янзын хувилбар байна. Түүнчлэн сэрээ, хайрлага, чагтан болон янгир зэрэг тамга ч байх ажээ" гээд зарим эрдэмтэд хоёр эвэртэй онги тамгыг хүннү нартай холбогдуулан тайлбарласан байдгийг дурджээ[57].

3. Хадны зургийн судалгааны товч

Доктор Д.Баяр хадны зургийг дотор нь сийлмэл зураг, сараачмал зураг гэж хоёр зүйл хуваж тайлбарласан бөгөөд зургуудыг бүтээсэн цаг хугацааны тухайд "*Дээрх байдлаас үзэхэд Гурван Мандалын хаданд буй нэлэнхүйд нь цохих буюу тойруулан хөвөөлж цохих аргаар дүрсэлсэн зургуудын эртнийх нь, судлаачдын сайтар судлан гаргаснаар м.т.ө. II мянган жилийн сүүлийн хагасаас м.т.ө. I мянган жилийн тэргүүн хагаст холбогдохоор байна. Тэгээд ч ан гөрөө хүмүүсийн аж ахуйн үйл ажиллагааг дүрсэлсэн сэдэв хадны зурагт хүрэл төмрийн түрүү үеэс гарч ирсэн байна*"[58] хэмээн тодорхойлжээ.

Бид өвөрмөц дүрслэл бүхий 150 гаруй зургийг сонгон монгол нутгаас олдсон хадны зургууд түүнчлэн бусад ижил төсөөтэй зургуудтай харьцуулан үзэхийг хичээсэн билээ.

Гурван Мандал уулын хадны зурагт хүрэл зэвсгийн үед холбогдох зураг зонхилж байна.

Эцэст тэмдэглэхэд, Гурван Мандал уулнаа хүрэл, төмөр болон Хүннү гүрэн түүнчлэн Түрэг, Уйгур зэрэг Монгол нутагт оршин тогтнож байсан үе үеийн олон улс, аймгуудын түүх, бичиг, соёлын цогц дурсгал хадгалагдан үлджээ.

Москва,1974; Э.В.Севортян, Л.С.Левецкий, Этимологический словарь тюркских языков, Москва, 1989.

[57] Д.Баяр, Гурванмандалын хадны зураг, -Археологийн судлал, Tom.XVI, fasc. 1-11, Улаанбаатар, 1996, 92 дугаар тал.

[58] Д.Баяр, Гурванмандалын хадны зураг, -Археологийн судлал, Tom.XVI, fasc. 1-11, Улаанбаатар, 1996, 95 дугаар тал.

ДЭЛ УУЛЫН БИЧЭЭС

Эртний түүх, соёлын нэгэн томоохон цогцолбор дурсгал Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутаг Дэл ууланд буй билээ.

"Түүх соёлын цогцолбор" хэмээн нэрлэхийн учир нь 60 гаруй км үргэлжлэх уг уулнаа хэдэн арван мянгаар тоологдох хадны зураг байхаас гадна руни, нангиад, монгол, төвд бичээс, түүнчлэн булш хиргисүүр, сүм хийдийн туйр нэг газар цогцолсонд оршиж байгаа юм. Эрдэмтэд Дэл уулын хадны зургийг голлон судалжээ. Дэл уулын цөөн хэдэн булш хиргисүүрийг малтан шинжилсэн боловч судалгааны ажлын тодорхойлолт, үр дүнгийн талаар ямар ч мэдээлэл байхгүй ажээ.

Дэл уулын дурсгалын цөм хэсэг орших Зүүн Билүүний аманд бидний сайн мэдэхээр хүрлийн үеийн дөрвөлжин булш, түрэгийн үеийн хашлага, зэл /балбал/ чулуутай булш лавтай бий. Сүүлийн жилүүдэд бичгийн дурсгалыг нь илүүтэй судалсан байна. Дэл уулын хадны зургийг Д.Дорж, Э.А. Новгородова нар анх удаа судалсан байна[59]. Энэ судалгаанаас хойш 12 жилийн дараа буюу 1987 онд МУИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч доктор Д.Хүүхэнбаатар, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Т.Санжмятав нар руни бичгийн I, II дурсгалыг олж илрүүлжээ[60]. Монгол-Зөвлөлтийн түүх, соёл судлалын хамтарсан хээрийн шинжилгээний анги 1989 оны 7-р сарын дундуур Дэл уулнаа очиж руни бичиг болон хадны зарим зургийг хуулбарлан авсан байна[61]. Тийнхүү зорин очиж судалсан эрдэмтэд дээрх руни бичээсийг уншиж тайлсан эсэх нь тодорхойгүй байна. Т.Санжмятав "Монголын хадны зураг" хэмээх номдоо Дэл уулын зураг, мөн руни бичгийн I, II дурсгалыг тус тус хэвлүүлжээ[62]. Дэл уулын Баруун Билүүний нэгдүгээр бичээсийг судлаач Ю.Болдбаатар анх удаа уншиж тайлан шинжлэх ухааны эргэлтэд оруулсан байна[63]. II, III, IY бичээсийг Ц.Баттулга[64] , Зүүн Билүүний хятад бичээсийг Ц.Баттулга, Ц.Төрбат нар тайлан уншжээ[65]. Б.Напил Дэл уулын бичээсүүдийг судлан нийтлүүлжээ[66]. Дэл уулын, уйгуржин хэлбэрийн нэгэн бичээсийг одоо болтол судлаачид тайлж уншаагүй байсаар ажээ.

---

[59] Д. Дорж, Э.А. Новогородова, Петроглифы Монголии, Улаанбаатар, 1975, 31дүгээр тал,таблиц-X.

[60] Т.Санжмятав, 1988 оны хээрийн шинжилгээний тайлан, -Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1988.

[61] Б.Баяр, Д.Эрдэнэбаатар, МЗТСХЭ-ийн бичээс судлалын ангид 1989 онд ажилласан тайлан, -Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1989.

[62] Т.Санжмятав, Монголын хадны зураг. Улаанбаатар, 1995, 40-42дугаар тал, таблиц 125-143.

[63] Ю.Болдбаатар, Дэл уулын нэгдүгээр бичээс, -Mongolica vol. 10(31), Улаанбаатар, 2000, 219-226 дугаар тал.

[64] Ц.Баттулга Дэл уулын баруун Билүүний II III бичээс, -Археологийн судлал, Tom. XYIII, fasc. 1-16, Улаанбаатар, 1998, 109-115 дугаар тал; Ц.Баттулга, Дэл уулын IV бичээс, -Эрдэм шинжилгээний бичиг, МУИС, Монгол судлалын сургууль, Боть XIY (151), V дэвтэр, Улаанбаатар, 1999, 74-79 дугаар тал; Ц.Баттулга Ц, Монгол Солонгосын эрдэмтдийн хамтарсан "Дэл уулын дурсгалын судалгаа"-ны урьдчилсан дүнгээс, -Монгол Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээний III хурал, Улаанбаатар, 2002, 88-98 дугаар тал; Ц.Баттулга, Дэл уулын нэгдүгээр бичээсийг дахин нягтлах нь, -Эрдэм шинжилгээний бичиг, МУИС, Монгол, хэл, соёлын сургууль, Боть XXII (227), Улаанбаатар, 2004, 12-17 дугаар тал.

[65] Ц.Баттулга, Ц.Төрбат, Б.Ганчимэг, Дэл уулаас шинээр олдсон хятад бичээс, - Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, МУИС. Монгол судлалын сургууль, Боть XYII (169), Улаанбаатар, 2001, 103-105 дугаар тал.

[66] Н.Базылханұлы, Моңғолияда жаңадан табылған түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000. стр.68-78.


Дэл уулын нэгдүгээр бичээс

Дэл уулын нэгдүгээр бичээс нь Булаг Билүүтийн хурлын туйрыг голлон чанх хойно, туйрын арын хаднаас тоолбол гурав дахь дэл хад буюу нурсан овооны зүүн талд, газраас дөнгөж цухуйж тогтсон 1,6 х 1,8 м талбайтай хүрэн хаднаа хоёр мөр болгон сийлсэн ба нийтдээ 85 үсэг тэмдэгттэй ажээ. Хурц үзүүртэй зүйлээр маш нарийн зурж бичжээ.

Угаас зураасан бичиг тул энгийн нүдээр харж уншихад бэрхтэй бөлгөө.

Дэл уулын нэгдүгээр бичээсийн судлаач Ю.Болдбаатар анх удаа уншиж тайлан судалгааны эргэлтэд оруулсан ажээ.

Судлаач Ю.Болдбаатар бичээсийг,




1. [tniriq(a)n(i)m;ig,(ä)t(ü)q(ä)n; bun(i)m j(o)q]
2. [(ä)lig, (ä)r, (a)b(i)či; tül(ü)q; (a)č, j(a),(a)lp(i)n; (a)ltim(i)š,qul(a)n,

öl(ü)rtim; (a)li, t(ä)g, t(ä)bi, öl (ü)rt(i)m; jig(ä)rmi, böri, öl (ü)rt(i)m] гэж галиглаад монгол хэлнээ;

1. Тэнгэр хан минь, Этүгэн онгон(минь), гуниг зовлонгүй (байлгаач)
2. Улсын эзэн Абичи, сүр хүчтэй, мэргэн баатар Хорчи /харваач/ жаран хулан авлав, халтар тэх, тэмээн гөрөөс авлав, хорин чоно авлав хэмээн орчуулсан байна[67]. Ю.Болдбаатарын эхэд тулгуурлан Б.Напил уншсан байдаг[68].

Бид олон удаагийн судалгааны дүн, бичээсийн хэв дардаст тулгуурлан дахин галиглан орчуулсан билээ.

Бичээсийн эхийн сийрүүлгэ;



Үсгийн галиг;

1. tŋiri QNm a igtükn a BWŋk YwQ a
2. ligr Bši a tüLwQ a čY LpN a LTims QWLN ölrtim a Lititbiölrtm a ygrmibörölrtm a

Үгийн галиг;

1. täŋiri qanïm igittükin: buŋik yoq:
2. el[l]ig er bašï: ötü /ütü/ aluq: čaya alpïn: altïmïs qulan ölürtim: alï äti täbi ölürtim: yigirmi böri ölürtim:

Монгол орчуулга;

---

[67]Ю.Болдбаатар, Дэл уулын нэгдүгээр бичээс, -Mongolica vol. 10(31), Улаанбаатар, 2000, 219-228 дугаар тал.

[68] Н.Базылханұлы, Моңғолияда жаңадан табылған түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000.68-78.

1. Тэнгэр эзэн /хан/ минь, өвдсөн (алжаасан) зовлон үгүй

2. Тавин цэргийн тэргүүн Өтү Алук Чаяа баатар жаран хулан авлав. Хавтгай авлав. Хорин чоно авлав.

Тайлбар

1. 𐰇𐰃𐰚𐰤 täŋiri руни болон уйгур бичгийн дурсгалуудад олонтой тохиолдох уг үг ямагт 𐰇𐰃𐰚 teŋri хэлбэрээр бичигддэг. Харин эл бичгийн дурсгалд 𐰇𐰃𐰚𐰤 täŋiri гэж бичсэн нь бичиг бичигч сийлэгчийн санамсаргүй гаргасан зөв бичихзүйн алдаа юу эсвэл өөрийнх нь дуудлага, аялгууны онцлог уу гэдгийг ялган хэлэх боломжгүй, юутай ч уламжлалт тогтсон бичлэгээс зөрүүтэй бичжээ.

Манай зарим эрдэмтэн судлаачдын туурвисан руни бичгийн талаар судалгааны өгүүлэл, эрдэм шинжилгээний ном бүтээлд руни бичгийн бага дурсгалуудын өвөрмөц бичлэгтэй, уншиж тайлах, тайлбарлахад бэрхтэй үгийг "Орхон бичгээс өөр аялгуугаар бичжээ гэх буюу Күл-тегин, Тонькук нарт зориулсан хөшөөний бичээсийг бичсэнээс өөр аялгуугаар бичсэн нь нилээд тодорхой байна" гэх зэргээр өгүүлсэн байдаг нь учир дутагдалтай дүгнэлт юм.

Зөв бичихзүйн дээрх мэт өвөрмөц хэлбэр(алдаа мадаг?) бүр, уншиж тайлахад бэрхтэй үг бүхэн нутгийн аялгууны онцлогийг тусгасан баримт болж чадах эсэх нь туйлын эргэлзээтэй хэрэг. Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудыг хаад, ихэс язгууртан нарт зориулан сар, жилийн турш бэлтгэж сийлэх тул алдаа мадагтай байх учир шалтгаан үгүйгээс гадна хаад, ихэсийн бичгийг осолдож буруу бичих нь зүйд нийцэхгүй. Бага бичээсийг хэн нэгний алдар нэр, гавьяа зүтгэлийг мөнхжүүлэх, түүхэн хэрэг явдлыг тэмдэглэх, өөрийн санаа бодол, хүсэл сэтгэлээ илэрхийлэх зорилгоор богино хугацаанд шууд бичиж цохисон буй.

Тиймээс сонгодог бичгийн дурсгалуудыг бага бичгийн дурсгалуудтай харьцуулж, нэн ялангуяа нутгийн аялгууны тухай ярих боломжгүй мэт.

Уг үгийг уйгур, монгол бичгийн сурвалжуудад 𐰇𐰃𐰚 tŋri, дөрвөлжин бичгээр dėŋ-ri[69] гэж бичиж хэвшин уламжлагджээ.

Уг үгийг уйгур, монгол бичгийн сурвалжуудад 𐰇𐰃𐰚 tŋri, дөрвөлжин бичгээр dėŋ-ri[70] гэж бичих хэвшиж тогтсон уламжлал бий.

Гэтэл хэмжээ, агуулга, ач холбогдлоороо "Монголын нууц товчоо"-ны дараа орох дундад үеийн монгол хэлний чухал дурсгал "Хуа -и И-Юй (華夷譯語" толь бичгийн доод дэвтэрт захидал харилцааны 12 бичгийг унших хэрэглэгдэхүүн

---

[69] Н.Н.Поппе, Квадратная письменность, Москва-Ленинград, 1941; Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, -Bibliotheca Mongolica: Monograph II, Centre for Mongol Srudies, National University of Mongolia, Улаанбаатар, 2001, (Дөрвөлжин бичиг), 80-114 дүгээр тал; Жанчив Ё, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал, Улаанбаатар, 2002; Д.Төмөртогоо, Монголын дөрвөлжин үсэгийн дурасхалын судлагаа, Улаанбаатар, 2002.

[70] Н.Н.Поппе, Квадратная письменность, Москва-Ленинград, 1941; Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, -Bibliotheca Mongolica: Monograph II, Centre for Mongol Srudies, National University of Mongolia, Улаанбаатар, 2001, (Дөрвөлжин бичиг), 80-114 дүгээр тал; Жанчив Ё, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал, Улаанбаатар, 2002; Д.Төмөртогоо, Монголын дөрвөлжин үсэгийн дурасхалын судлагаа, Улаанбаатар, 2002.

болгон эмхэтгэн оруулсаны бичиг тус бүрд “тэнгэр” үг гэх тохиолдох ба ямагт “tenggiri” гэж бичиж тэмдэглэжээ[71].

Германы нэрт эрдэмтэн Э.Хэниш “Нангиад- Монгол толь I: Хуа-и И-Юй” хэмээх бүтээлдээ уг үгийг

a b c d e

tngri tenggili tenggiri 天 Himmel гэж тайлбарласан[72] байна. (Жич: a. Уйгуржин монгол эхийн галиг, b. “Уйгуржин дэвтэр”-ийн нангиад галиг, c. 1918 оны барын нангиад галиг, d. Уг нангиад эх, e. Герман орчуулга). Руни бичгийн бага дурсгалд цор ганц удаа “𐰚𐰃𐰠𐰇 täŋiri” гэж тохиолдож буйг бичигч, сийлээчийн алдаа мадаг, эсвээс аялгууных нь онцлог хэмээн хэлж болох боловч Мин улсын Тайзу хаан 1382 оны тэргүүн сард зохион найруулах зарлиг буулгаж[73] ёсоор үйлдэгдсэн толь бичигт “天~tenggili ~tenggiri” гэж бичих болсны учир юу билээ гэсэн асуулт гарна. Үүний учрыг хэлшинжлэлийн үүднээс нарийвчлан судалж үзвэл нилээд сонирхолтой дүгнэлтэд хүрч магадгүй юм.

2. 𐰴𐰍 qan (≫𐰴𐰍 qanïm). Монголын руни бичгийн дурсгалуудад хаан (𐰴𐰏𐰍 qaγan), хан (𐰴𐰍 qan) гэх цол олонтоо тохиолдоно. Сонгодог дурсгалуудад ихэвчлэн хаан гэх цол 𐰴𐰏𐰍 (qaγan) бичлэгтэй байх бөгөөд зөвхөн Туньюкуйн гэрэлт хөшөөний 2, 3, 28, 33 дугаар мөрүүдэд хан цол, 𐰴𐰍 (qan) бичлэгтэй буй. Хан цол Хангидайн хадны бичээснээ Баз хан (𐰴𐰍𐰋𐰃 baz qan), Их бичигтийн бичээст Боз хан (𐰴𐰍𐰋𐰺𐰃 boz (buz) qan) гэх мэтээр бага бичгийн дурсгалуудад тохиолдоно. Эртний түрэг, уйгур, монгол, солонгос хэл, бичгийн сурвалжуудад хаан (qaγan), хан (qan) цол нэн элбэг тохиолдоно.

Эл хоёр цолын тухайд проф. Б.Сумъяабаатар “ “Хаган, Хан” гэдэг нь, “Хаган” нь “Хаган” цолтой, эзэншил (эзэмшил) бүхүй хүн, “Хан ” гэвэл “Хаган” цол хүртээгүй, эзэмшил бүхүй хүнийг хэлдэг байсан байна”[74] гэсэн дүгнэлт гаргаад

---

[71] Ё.Жанчив, Ц.Бямбацэнд, Нангиад Монгол “Хуа-И И-Юй” толь “華夷譯語”, Улаанбаатар, 2003, 51-78 дугаар тал.

[72] E.Haenisch, Sinomongolische Glossare: I. Das Hua-I ih-yü, Berlin, 1957, pp.9.

[73] “ Мин Ши-лу (明實録) буюу Мингийн магад тэмдэглэл”-ийн “Тайзу хааны магад хууль” хэмээх 141-р ботид 1382 оны 1-р сарын 20-ны үйл явдал болгон тэмдэглэсэн нь: “ (Хаан бээр) бичгийн явдлын хорооны асран тайлбарлагч Хуо Юань- Гиэ нарт “Хуа-и И-юй” бичгийг найруулагтун хэмээн зарлиг буулгав. Хаан бээр, Юаньд уулаас бичиг үсэг байхгүй билээ. Зарлиг заавар буулгахад Гоу чангийн (өөрөөр хэлбэл, уйгурын Ё.Ж) үсгийг зээлэн монгол үсэг зохиогоод дэлхий дахины хэлүүдийг нэвтэрцүүлэн авна хэмээн Хуо Юань-Гиэ, найруулагч Ма-ша И-хэ нарт зарлиг буулгаж тэдний хэлийг хятадаар орчуулуулбай. Тийнхүү одон орон, газар зүй, хүний явдал, бодисын зүйл, өмсөх идэх, эдлэл хэрэглэл тэргүүтнийг эс бүрдүүлсэн нь үгүй. Дахин “Юаний Нууц Товчоон”-ыг авчран лавлалт болгон үсгүүдийг таслан дуудлага дор нь зохицуулбай. Найруулан төгөсмөгц жуу зарлан хэвлүүлэн тархаажээ. Түүнчлэн элч нар умар говь орноо одох, ирэхүйд цөм тэдэн лүгээ нэвтрэлцэн чадах болов” гэжээ. Ё.Жанчив, Ц.Бямбацэнд, Нангиад Монгол “Хуа-И И-Юй” толь “華夷譯語”, Улаанбаатар, 2003,8 дугаар тал.

[74] Д.Наваан, Б.Сумъяабаатар, Өвөг монгол хэл, бичгийн чухаг дурсгал, Улаанбаатар, 1987, 113 дугаар тал; Т.А.Бертагаев,К этимологии xān~xaγan, xatun и об их отношении к xāt, Тюркологические исследования. Москва, 1976, стр.45-50.

"Хан" гэдэг үгнээ эзэншил утга түлхүү байна гэж тэмдэглэжээ[75]. Дөрвөлжин үсгийн дурсгалуудад Чингис хааны цолыг "jiŋ-(gis) qa$_o$-nu ba$_o$ q'-nu I-6, II-8, III-9, V-8, VIII-9, IX-9, XI-9, XII-5, XIII-9, XIV-9, XVI-9, XVIII-10, XIX-9, XX-10, XXI-9, XXV-10, XXVI-12, XXVII-5, XXIX-8, XXX-6, XXXI-9, XXXII-7, XXXIII-9, XXXIV-9, LXI-6"-д тус тус "хан" хэлбэрээр олон удаа, харин "čin-gis q'-nu ba q'-nu IV-9, jiŋ-(gis) q'-nu ba$_o$ ja$_o$r-liq-dur VI-7, x-5, XY-7, XVII-8"[76] хэмээн "хаган" тун цөөн тохиолдож байгааг анхааран үзүүштэй.

Руни бичгийн дурсгалд тохиолдох 𐰆𐰃𐰏𐰍𐰃 teŋri qan гэх үгийг "Тэнгэр эзэн", харин хүний нэрийн хамт буй 𐰆𐰃 qan цолыг хаан (𐰆𐰍𐰃 qaγan) цол хүртээгүй, эзэмшил бүхүй хан хүн хэмээн ойлгож, орчуулбал зохилтой.

3. Нэгдүгээр мөрийн гурав дахь үгийг бид "𐰃𐰍𐰇𐰴𐰞 igittükin" гэж унших саналтай байна. Энэ үгийг задлан үзвэл ig + t + tük +n гэсэн бүтэцтэй, "өвдсөн, өвчилсөн, алжаасан" гэсэн утгатай үг.

ig-өвчин гэх утгатай нэр үндэс

-t- нэрээс үйл үг үүсгэх дагавар

-tük- үйлт нэрийн өнгөрсөн цагийн нөхцөл

-n- харьяалахын тийн ялгалын нөхцөл.

Өгүүлбэр эхлэхдээ тэнгэр эзэн /хан/ минь гэсэн байх тул удаах үгийг мөн нэгдүгээр биед хамаатуулан этүгэн онгон минь гэж бичих учиртай. Гэтэл ийн хамаатуулан бичээгүй байна. Ер нь Монголын руни бичгийн сонгодог дурсгалд 𐰃𐰍𐰇𐰴 /ötükän/ Өтүкэн гэх үгийг "𐰴ö/ü" эгшигтэй бичдэг тогтсон уламжлалыг анхаарахгүй байж огт болохгүй.

4. 𐰚𐰍𐰃𐰓 buŋik- эл үг buŋ-k гэсэн бүтэцтэй. buŋ- зов-, гуни-, зүд- гэх үйл язгуураас тэмдэг нэр үүсгэх –k дагавар залгаж үүсчээ.

Энэ мэт жишээ Көлтигиний гэрэлт хөшөөний бичээснээ тохиолдохыг emge-k, bulga-k, yaz-uk гэх үгсээр үлгэрлэн өгүүлсэн байдаг[77]. Зөв бичихзүйн үүднээс үзвэл 𐰇𐰍𐰃𐰓 buŋaγ хэлбэрээр бичих байсан биз ээ. Судлаач Ю.Болдбаатар 𐰚 тэмдэгтийг 𐰋 тэмдэгт хэмээн үзэж 𐰋𐰍𐰃𐰓 buŋim гэж уншсан байна[78].

Бидний авсан хэв дардас болон гэрэл зураг, эхэд 𐰋 бус 𐰚 тэмдэгт маш тодорхой, маргаангүй буй.

Эртний түрэг, уйгур хэлнээ зовлон, зүдүүр /зүдгүүр/, гуниг, уйтгар, шаналал гэх утгатай энэ үг МНТ-нд "nökör či bürün maši muŋtaniju aisu ajuγu. Ere-yin muŋ nigen bui je"[79] гэж тохиолдох бөгөөд монгол хэлний мунгинах /mungginaqu/, бунгинах /bungginaqu/ хэмээх үг(buŋ~bung~mung)-тэй гарал нэг юм. Монгол хэлний тайлбар толь бичгүүдэд мунгинах /mungginaqu/ хэмээх үг будилах,

---

[75]Д.Наваан, Б.Сумъяабаатар, Өвөг монгол хэл, бичгийн чухаг дурсгал, Улаанбаатар, 1987, 112 дугаар тал.

[76] Ё.Жанчив, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал, -Monumenta Mongolica: Tomus III, Centre for Mongol Studies National University of Mongolia, Улаанбаатар, 2002.

[77] Cengiz Alyılmaz, Orhun Yazıtlarının Söz Dizmi, Erzurum, 1994, s.13.

[78]Ю.Болдбаатар, Дэл уулын нэгдүгээр бичээс, -Mongolica, Vol. 10(31), Улаанбаатар, 2000, 219-228 дугаар тал.

[79]Б.Сумъяабаатар, Монголын нууц товчоо, үсгийн галиг. Улаанбаатар, 1990, 115 дугаар тал.

самуурах, төөрөгдөх, мунгинах гэсэн утгатай[80], бунгинах /bungginaqu/ нь уйгур, түрэг хэлнээ ижил утгатайг тэмдэглэжээ[81].

5. **el[l]ig er bašï**-хоёрдугаар мөрийн эхний үгийг бид ellig er bašï гэж уншиж байна. 𐰴-нь ~𐰴~𐰺 гэх нэг тэмдэгтийн хувилбар байх боломжтой.

Мөн "elli-тавь" гэсэн тооны нэр хэлбэржин ellig болж тавь гэх үг өмнөх үгээ холбон тодотгож тавин эр, тавин цэрэг гэсэн санааг илэрхийлж байна. Нэгэнт тавин цэрэг гэх үг тодорхой тул "ellig er bašï" буюу тавин цэргийн дарга, тавьтын дарга гэж ойлгох бүрэн үндэстэй. Тэгээд ч жаран хулан, хорин чоно авласан нь тавин цэргийн тоотой дүйж байна.

6. 𐰋𐰇𐰾 qulan, (Equus hemionus) хулан. Энэ нэр хул /𐰋𐰇qula/ хэмээх зүснээс үүссэн нэр үг юм. "Хулан зээр мэт зүсээ нийлүүлж" хэмээн хэлэлцэх нь уг хоёр зүс ойролцоо болохыг хэлсэн хэрэг. Монголчууд хуланг "чихт, чихтэй" хэмээн нэрлэх нь буй. Түрэг хэлнээ чихийг "kulak" гэдэг бөгөөд монгол, түрэг угсаатан ямартаа ч уг амьтны чихийг нь онцгойлон үзэж нэрлэсэн байж болох талтай. Нөгөө талаар "хул" гэх зүс, хулан (qulaq-kulak [түрэг.чих]~quliki [монгол.чихний хэнгэрэг, чихний дотоодод хуралдсан хаг мэт юм[82]])-гаасаа үүсэлтэй юу, эсвээс хулан нэр хул гэх зүснээс эхтэй юу гэсэн ауулт аандаа гарна. Монгол хэлний хул, хонгор, ухаа, хоо гэх үгс бүгд язгуур нэг бөгөөд ойрад аман аялгууны "хоо" гэх үгийн тухай доктор Н.Балжинням "Баруун монголд баяд, дөрвөдүүд одоо ч гэсэн адуу, үхэр, тэмээ, буга... зэрэг мал, амьтны цайвардуу, хул шарга зүсийг "ухаа" гэлгүй "хоа" гэж хэлдэг. Монгол бичгийн хэлэнд энэ хоёр үгийг [qow-a] гэсэн ганц дүрсээр тэмдэглээд тухайн нутгийн аялгуунаа –о, -у хоёрын (хоа, хуа) аль дууддагаар нь тохируулан хэрэглэхэд зориулагджээ. Түүгээр ч үл барам энэхүү "хоа-хуа" үгийг төв халхын аялгуунд [qow-a] гэж бичих боловч ярианд "ухаа" гэдэг нь монгол бичгийн хэлний бас нэг онцлог юм"[83] гэж тэмдэглэжээ.

7. **alï äti**- Эх бичигт 𐰀𐰇𐰚 гэж нилээд тодорхой буй. Бас бидний авсан хэв дардаст ч эдгээр үсэг тэмдэгт мадаггүй харагдана. 𐰚(L) үсгийн дараахи 𐰇(i) нилээд урт, бөгтөр бичигджээ. 𐰉(t) үсэг тэмдэгт дунд хэсгээрээ зурагдаж баларсан нь даруй танихад бэрхтэй болжээ. 𐰉 үсгийн дараа 𐰇 үсэг тэмдэгт маш тодорхой буй.

𐰀𐰇𐰚 **alï äti** холбоо үгийн талаар товч өгүүлье.

В.В.Радловын цуглуулсан түрэг хэл, аялгууны эх хэрэглэгдэхүүнээс үзвэл "al" гэх үг арван нэгэн утга илэрхийлдэг болохыг тэмдэглэжээ.

Жишээ нь, "хитрость, обманъ, уловка-Schlauheit, List, Betrug, Strategie" гэх мэт. Мөн "возвышенный, могущественный, лютый-er haben, mächtig, grimmig (in Märchen)" хэмээх салаа утга буйг "лютый волкъ-der mächtige Wolf" гэсэн

---

[80] Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 349 дүгээр тал.

[81] Sečenčoγtu, Mongγol üges-ün ijaγur-un toli, jing jian keu, 1988, 746 duγar tal-a.

[82] Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 728 дүгээр тал.

[83] Н.Балжинням, "Монголын Нууц Товчоо"-ны "Гуа" гэдэг үгийн учир, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть 7(117), 1-25 дэвтэр, МУИС, Монгол судлалын дээд сургууль, Улаанбаатар, 1996, 49 дүгээр тал.

жишээгээр үлгэрлэн дурджээ[84]. Түрэг хэлний толь бичгүүдэд ч энэ үгийн утгын талаар товч өгүүлсэн байна[85]. Дээрх жишээнээс үзэхэд өгүүлэн бүхүй бичээсийн al, alï хэмээх үг зальтай, овтой, мэхтэй, мөн түүнчлэн догшин, ширүүн гэсэн утгатай нь тодорхой байна.

äti~eti -нь мах, бие, махбод гэсэн утгатай үг. Догшин, ширүүн (al,alï), мах, бие, махбод (äti~eti) гэх үгс хоршиж догшин, ширүүн биетэй тэмээ, эдлэгдээгүй, зэрлэг тэмээ гэсэн утга илэрхийлж байна.

ali äti täbi ölürtim- гэж буйгаас тэмээ авласан нь илт ч гаршуулж гэршүүлсэн тэмээ авлаагүй нь мэдээж. Иймд гэршүүлсэн тэмээ(Camelus bactrianus)-ээс ялгахын тулд тодотгон "alï äti-зэрлэг тэмээ (хавтгай) гэж бичсэн бололтой. Монголчууд бидний "хавтгай (Camelus ferus)" хэмээх зэрлэг тэмээг түрэгүүд "alï äti täbi" гэж нэрлэдэг байсныг үгүйсгэх аргагүй юм. Тэмээ, Енисейн дурсгалд, тухайлбал Телее (Е-46), Бегре (Е-11)-ийн бичээснээ "𐰀𐰃𐰇𐰃𐰆ägritäbä" хэмээн тэмдэглэгджээ.

Телеегийн бичээсийн 3-р мөрийг В.Томсен, С.Е. Малов, А.М.Щербак нарын эрдэмтэд[86] хэд хэдэн хувилбараар уншиж тайлсан байна. И.В.Кормушин эдгээр эрдэмтдийн судалгааг дахин хянан нягталж эл мөрийг "äldä kišim ägritäbä tört butluγ jïlqïm" гэж галиглаад орос хэлнээ "Мои наложницы, мои верблюды, мой четвероногой скот" хэмээн орчуулжээ[87]. Бегре (Е-11)-ийн бичээснээ "är ärdämin üčün alpun altun kümüšig ägritäbä eldä kiši qazγandïm-a (Благодаря моей доблести мужа-воина отвагой приобрел я золото и серебро, верблюдов, наложниц)" гэж гарах бөгөөд В.Радлов, Х.Н.Орхун, С.Е. Малов, А.М.Щербак, И.В.Кормушин нарын судалгаа буй[88].

Енисейн бичээсийн энэ баримт гэршүүлсэн тэмээ (Camelus bactrianus)-г 𐰀𐰃𐰇𐰃𐰆ägritäbä гэж нэрлэдэг болохыг нутлаж байна. Иймд, зэрлэг тэмээ (Camelus ferus)-г 𐰃𐰃𐰇𐰃𐰇 alï äti täbi гэж нэрлэдэг байжээ хэмээн үзэх үндэс буй.

alï- язгуур монгол хэлний албин (albin), алмас (almas)[89], казах хэлний албасты, тува хэлний албас гэх үгст хадгалагдан үлджээ. Албин, алмас гэдэг нь угтаа зэрлэг, хээрийн амьтан гэсэн үг бололтой. Толь бичигт "албин" -нь уйгур гаралтай үг хэмээн тэмдэглэгджээ[90].

---

[84] В.В.Радлов, Опытъ словарь тюркских наречий. Том. I, часть 1.Санктпетербургъ.1893, стр. 349.

[85] Древнетюркский словарь. Ленинград,1969, стр.31-32; Clauson Sir Gerard, An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish. Oxford, 1972, pp.120-123.

[86] V.Thomsen, Turcica. Étude concernant l'interprétation des inscriptions turques de la Mongolie et de la Sibérie, Journal de la Société Finno-Ougrienne, Helsinki, 1916, pp.69; С.Е.Малов, Енисейская письменность тюрков. Москва-Ленинград,1952, стр.83; А.М.Щербак, Памятники рунического письма енисейских тюрок. Народы Азии и Африки, 1964, №4, стр.447-448.

[87] И.В.Кормушин, Тюркские Енисейские Эпитафии (тексты и исследования), Москва, 1997, стр.225.

[88] И.В.Кормушин, Тюркские Енисейские Эпитафии (тексты и исследования), Москва, 1997, стр.273.

[89] Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 33 дугаар тал.

[90] О.Сүхбаатар, Монгол хэлний харь үгийн толь. Улаанбаатар, 1999, 21дүгээр тал; Sečenčoγtu, Mongγol üges-ün ijaγur-un toli, jing jian keu, 1988, 95 duγar tal-a.

Бичээст гарах үгийн толь

teŋiri –  tngri, тэнгэр

qanïm

qan- qan, хан, эзэн

q.-ïm

igittükin

ig – ebedčin, өвчин, эмгэг

i. -ittükin

buŋik

buŋ - jobalang, зовлон зүдгүүр

b.- k

yoq- ügei, үгүй

el[l]ig

el[l]i- tabi, тавь, тавин

e.- ig

er-  er-e эр, цэрэг

baši-  terigün, тэргүүн, толгойлогч,

ötü aluq čaya-  ötü aluq čaya, хүний нэр

alpïn

alp- baγatur, баатар

a. -ïn

altïmïs – jiran, жар, жаран

qulan-  qulan, хулан, (урт чихт)

ölürtim

öl-  ükükü, үх

ölür- алах, авлах,

ö.-ürtim

alï äti täbi

alï – jerlig, зэрлэг, догшин

äti- miq-a, мах, бие, махбодь

täbi – temege, тэмээ, хавтгай /зэрлэг тэмээ/

yigirmi- qorin, хорь, хорин

böri – činu-a, чоно

Дэл уулын хоёрдугаар бичээс

Газрын хөрснөөс дээш 5-8 см цухуйсан, хэвтээ том хавтгай хүрэн хадан дээр дөрвөн мөр бичээсийг хурц үзүүртэй зүйлээр олон дахин зурж сийлсэн байна.


Нэгдүгээр мөрийн зүүн дээд талд нь янгир, хоёрдугаар мөрийн харалдаа баруун өмнө талд морьтой хүн, дөрөвдүгээр мөрийн доор олон хэрчлээс, зураас, янгир, түүний дор мөн олон хэрчлээс зураас, янгирын зураг буй ажээ[91].

Бичээсийн зүүн дээд талд хэдэн янгир болон бусад амьтны дүрс цохисон нь бичээстэй холбогдолгүй бололтой.

Өөрөөр хэлбэл угтаа амьтны дүрс цохисон хадан дээр бичээс сийлжээ.

Эл бичээс хийгээд зураг "Монголын хадны зураг" номонд хэвлэгдсэн байна[92]. Б.Напил уншиж орчуулжээ[93].

Бичээсийн эхийн сийрүүлгэ;



Үсгийн галиг;	Үгийн галиг;	Орчуулга;
1. k g Y R Q	kig (kik) yarïq	Антай (ан автай) салаа
2. t r	……..	…….
3. t ŋ r m s n i g	taŋrim sen igä	Тэнгэр минь та эзэн
4. š W [y/k?]	aš?	[Хоол, хүнс?]…

Тайлбар

Бичээсийн хоёрдугаар мөрнөө "тэнгэр" гэх үгийг эхлэн буруу бичсэнээс орхиод дараагийн мөрөнд дахин шинээр бичжээ.

yarïq нь монгол хэлний ярах, ирэх гэдэг үгтэй утга язгуур нэг болов уу.

Газар ярагдсанаас салаа хавцал үүсдэг ажээ. Тэрхүү ярагдсан гэх үндсэн утгаар нь түрэг хэлтэн уулын салаа хавцлыг (гуу жалгыг ч) yarïq хэмээн нэрлэх бөлгөө. Орчин цагийн түрэг хэлнээ yar(ucurum), казак хэлнээ жылға, жыра, тува нар ойык гэх бөгөөд ийм нэртэй газар ч буй ажээ.

Дөрөвдүгээр мөрийн үсэг тодорхой боловч үг болгон уншихад бэрхтэй. Юутай ч бичээсийн агуулгад тулгуурлан "aš -хоол, хүнс" гэсэн үг байж магад хэмээн таамаглаж байна. Босоо ханан зураас эл бичээснээс гадна Шар хошууны хойт хад, Зүүн билүүний хаданд байх бөгөөд чухам ямар учир холбогдолтойг хэлж эс мэднэ.

---


[91] Ц.Баттулга, Дэл уулын Баруун билүүний II, III бичээс, - Археологийн судлал, Tom. XVIII, fasc.1-16, Улаанбаатар, 1996, 110 дугаар тал.

[92] Т.Санжмятав, Монголын хадны зураг, Улаанбаатар,1995, 41 дүгээр тал.

[93] Н.Базылханұлы, Моңғолияда жаңадан табылған түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000.68-78.

Бичээсийн ерөнхий утгаас сэжүүрлэн мөчидхөн дүгнэвэл уул бичээст “антай салаа, тэнгэр эзэн минь та олз омгийн үүдийг нээж өглөө хэмээн талархсан эсвээс ан автай салаа, тэнгэр эзэн минь та олз омог ангийн хишиг үүдийг нээж хайрла” гэж гуйж залбирсан сэтгэлээ бичиж үлдээхийг хичээжээ гэлтэй байна.

Бичээст гарах үгийн толь



kig (kik) – ang, ав, ан ав
yarïq – salaγ-a, γuu jilγ-a, салаа, гуу, жалга
taŋri- tngri, тэнгэр
-m- биеийн төлөөний үгийн нэгдүгээр биеийн хамаатуулах нөхцөл
sen – či, чи
igä – ejen, эзэн
aš? – qoγula künesü, хоол хүнс

Дэл уулын гуравдугаар бичээс


Босоо, улаан хүрэн чулуун дээр сийлсэн ганц тамга, 10 үсэг зурлага бүхий нэг мөр эл бичээс II бичээст хадны баруун хойно, алхмын зайтай буй.

Бичээсийн эхний тэмдэгт 1 см, төгсгөлийн тэмдэгт 2.5 см өндөр бөгөөд бичихдээ жижгээр эхэлж жигд томорсоор төгсчээ. Уг бичээсийг буруу харуулан бичсэн байна. Монгол нутгаас руни бичгээр буруу харуулан тонгоруулан цохисон дурсгал олдож байсан нь Өвөрхангайн бичээс билээ[94].

Бичээсийн эхийн сийрүүлгэ;



Тонгоруулан зөв дараалалд оруулбал;



Үсгийн галиг;
RQ : R W l W y i š

Үгийн галиг;
arqa ara ulu yiš

Үгчилсэн орчуулга;
Олон завсар (салаа) их шугуй


Уг бичээснээ газар нутгийн байдлыг тодорхойлон бичсэнээрээ бусад дурсгалуудаасаа нилээд онцлогтой байна.

Бидний санахад энд авлаар ирэгсэд өмнө нь энэ газар нутагт нутаглаж байгаагүй, түүгээр ч үл барам огт ирж байгаагүй бололтой.

Хэрэвзээ энэ орон нутагт авлаар урьд өмнө ирж байсан бол газрын байрлалыг тодорхойлон бичиг, бичээс үйлдэхгүй байсан биз ээ.

Нэгдүгээр бичээснээ "тавьтын дарга /тэргүүн/", дөрөвдүгээр бичээст "чур" цолтны нэр дурдагдаж байгаа нь санамсаргүй хэрэг огт биш "цэрэг, цэргийнхэн " эл газар нутагт ирсэн болох нь тодорхой байна. Эдгээр бичээсүүдийг бичсэн цаг улирлын хувьд намар цаг байх боломж магадлал бүрэн буй бөгөөд магадгүй цэргийн хүнс төхөөрөх, намрын их ан хомрогод оролцогсод "сэтгэгдэл"-ээ бичиж үлдээжээ гэлтэй.

Бичээст гарах үгийн толь



arqa – olan, олон
ara – jabsur, завсар
ulu – yeke, их
yiš - köndei, siγui, хөндий, шугуй

[94]Л.Болд, Өвөрхангайн түрэг бичээс, - БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 83-84 дугаар тал; Л.Болд, Өвөрхангайн орхон бичээс, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 254-258 дугаар тал.